

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭН



**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ,
СУДАЛГААНЫ ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА**

Судалгааны ажлын тайлан

Улаанбаатар хот

2023 он

1

АГУУЛГА

Товчилсон үг
Нэр томъёоны тайлбар

УДИРТГАЛ

НЭГ. ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ, ТЭДГЭЭРИЙГ БЭЛТГЭЖ, МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.1. Тээврийн цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хангалт, бүрдүүлэлт, тулгамдаж буй асуудал, шийдэл
- 1.2. Дотоод хэргийн их сургуулиас цагдаагийн байгууллага, түүний дотор тээврийн цагдаагийн албаны хүний нөөцийг сургаж буй өнөөгийн байдал, сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчлэл
- 1.3. Тээврийн цагдаагийн алба хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал

ХОЁР. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР СУДАЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

- 2.1. Доктор, магистр, бакалаврын түвшинд судлагдсан байдал, дэвшүүлсэн асуудал, хэрэгжилт
- 2.2. Цаашид судлах шаардлагатай хууль зүй, техник, боловсролын болон бусад чиглэлээр судалгааны сэдвийн томъёолол
- 2.3. Сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага эрхлэн гаргасан байдал, түүний ашиглалт
- 2.4. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, дэвшүүлсэн асуудал, хэрэгжилт

ГУРАВ. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

- 3.1. Олон Улсын гэрээ, конвенц
- 3.2. Монгол Улсын хууль, тогтоомж
- 3.3. Бодлогын баримт бичиг
- 3.4. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан эрх зүйн акт
- 3.5. Үйл ажиллагааны журам, заавар, тушаал

ДӨРӨВ. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТЫГ ЧАНАРЖУУЛАХ, СУДАЛГААНЫ АЖЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- 4.1. Тээврийн цагдаагийн алба хаагчдаас авсан санал асуулгын үр дүн
- 4.2. Тээврийн цагдаагийн алба хаагчдын сургалтад нөлөөлж буй хүчин зүйлс
- 4.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр сургалтын байгууллагуудын тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох шийдэл

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ
САНАЛ, ЗӨВЛӨМЖ
АШИГЛАСАН МАТЕРИАЛ
ХАВСРАЛТ

Товчилсон үг

АНУ – Америкийн Нэгдсэн Улс
БНТУ – Бүгд Найрамдах Турк Улс
БНСУ – Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БШУ – Боловсрол, шинжлэх ухаан
ДХИС – Дотоод хэргийн их сургууль
ЗХАБ - Замын хөдөлгөөний аюулгүй байдал
ЗХУ – Зөвлөлт Холбоот Улс
ЗТО - Зам тээврийн осол
ОХУ – Оросын Холбооны Улс
МУИС – Монгол Улсын их сургууль
МУБИС – Монгол Улсын боловсролын их сургууль
ТЦА - Тээврийн цагдаагийн алба
ХБНГУ – Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗС – Хууль зүйн сургууль
ХАЗО - Хүн-авто машин-зам-орчин

Нэр томъёоны тайлбар

1. **"Тээврийн хэрэгсэл"** гэж хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг;
2. **"Механикжсан тээврийн хэрэгсэл"** гэж мопедоос бусад, хөдөлгүүрээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг;
3. **"Жолооч"** гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн, жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүнийг;
4. **"Зам"** гэж тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газрыг. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, явган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарна;
5. **"Замын хөдөлгөөн"** гэж нийтийн хэрэгцээний зам дээр явганаар болон тээврийн хэрэгслээр хүн, ачаа шилжих үйл ажиллагааг;
6. **"Зам тээврийн осол"** гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг;
7. **"замын хөдөлгөөнд оролцогч"** гэж замаар явж байгаа жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчийг;
8. **"Замын хөдөлгөөний аюулгүй байдал"** гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг;
9. **"Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах"** гэж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;
10. **"Замын хөдөлгөөний зохион байгуулалт"** гэж замын хөдөлгөөнийг удирдан явуулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг;
11. **"Явган зорчигч"** гэж замаар явган яваа /зам дээр ажил үүрэг гүйцэтгэж яваагаас бусад/ хүн, жагсаалаар яваа болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж, чарга чирж, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүнийг.

УДИРТГАЛ

Судалгааны ажлын шаардлага, үндэслэл

Орчин үеийн нийгэм, эдийн засаг, техник технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны шаардлага, шинж чанар шинэчлэгдэн өөрчлөгдөх үйл явцын үр дүнд насан туршдаа суралцах үйл явцад дэмжлэг үзүүлэх хандлага давамгайлж байна. Өөрөөр хэлбэл, сургалтын арга, агуулга, мэдээлэл харилцааны технологийн тусламжтай сурах боломж нэмэгдсэн нөхцөлд хүн бүрийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн, чанартай, хүртээмжтэй, боловсрол эзэмших эрхийг хангах нь дэлхийн улс орнуудын тулгамдсан асуудлуудын нэг болсон.

Эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, хуульт ёсыг мөрдүүлэх, нийгэмд дэг журам тогтоох, иргэдийн аюулгүй байдлыг хангахад голлох үүрэгтэй цагдаагийн алба хаагчийн боловсролын асуудлыг хууль зүй, цагдаа судлал, боловсрол судлалын талаас уялдуулан авч үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, сургах тогтолцоо нь нийгмийн хөгжлөөс шалтгаалан хувьсан өөрчлөгдөж, улам ээдрээтэй болж байгаа тул зөвхөн хууль зүйн төдийгүй бусад салбарын шинжлэх ухааны ололт амжилтад суурилах бөгөөд сургалтын нэгдмэл тогтолцоог болон эрх зүйн зохицуулалтыг тусгайлан судлах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Боловсролын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоод хэргийн их сургуулийн захирал дангаар болон хамтарсан байдлаар батлан хэрэгжүүлж байгаа эрх зүйн актууд нь энэ төрлийн сургалт, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулж байна.

Үүнээс үзвэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх талаар алба хаагчийн сургалтын тогтолцоо, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн эх сурвалж, баримт бичиг, хууль, тогтоомжууд хангалттай мэт байгаа боловч нэгдсэн тогтолцоог бүрдүүлээгүй, сургалтууд нь зөвхөн тухайн нэг үе шатны боловсролыг олгоход чиглэж байгаа нь хоорондын уялдаа, залгамж холбоог хангахгүй байх гол нөхцөл болжээ.

Замын цагдаагийн алба хаагчийг сонгон шалгаруулах, бэлтгэх, албаны сургалт гэсэн хэд хэдэн төвшнөөс бүрдэх онцлог тогтолцоо байгаа бөгөөд эдгээрийг дамжихаас гадна бусад байдлаар алба хаагчид бэлтгэгдэх, алба хаагч бүр харилцан адилгүй сургалтад хамрагдаж, хөгжих боломж тэгш бус байгаа нь сургалтын тогтолцоо, түүний эрх зүйн зохицуулалтын хувьд нэгдсэн шийдэлд хүрээгүй гэж үзэхэд хүргэж байна.

ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан алба хаагчийн албан тушаалын тодорхойлолтод тус бүрийн шаардлага, шалгуурт нийцсэн алба хаагчийг бэлтгэх, томилох, ажиллуулахад

мэдлэг, ур чадвар, хандлагын нийцэмж учир дутагдалтай байгаа нь иргэд төдийгүй алба хаагч, удирдах албан тушаалтнуудаас авсан санал асуулгын судалгаагаар илэрдэг.

Тээврийн цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, хөгжүүлэх сургалтын тогтолцоог алдаатай ангилсан нь сургалтуудын уялдаа холбоо, ялгаа заагийг тогтооход хүндрэл учруулж байгаа бөгөөд сургалтын тогтолцоонд дүн шинжилгээ хийхэд уялдаа холбоогүй, байгууллагууд тус тусдаа сургалтаа зохион байгуулж байна.

Анхан шатны буюу ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалт, тэдний элсүүлэх, сургах үйл ажиллагаа нь мэргэжил сургалтын чиглэлээр буюу богино хугацаанд анхан шатны мэдлэг, ур чадварыг олгож байгаа бол бакалаврын түвшний сургалт нь хэд хэдэн мэргэшүүлэх хөтөлбөртэй ч жил бүр авч байгаа төгсөгчдийг мөшгөх судалгааны үр дүнгээр төгсөгчдийн чанар сул байгаа нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэж буй сургалтын байгууллага болон захиалагч байгууллагын уялдаа холбоо нягт бус байгаатай холбон үзэхээр байна.

Ахисан түвшний сургалт буюу магистр, докторын сургалтад хамрагдах боломж алба хаагчдад нийтлэг бус байдаг бөгөөд дарга, удирдлагын арга барил, алба хаагчдыг дэмжих бодлоготой холбоотой байна. Энэ нь тухайн алба хаагч өөрийгөө хөгжүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх чухал алхам хэдий ч ажлын ачаалал, бусад нөхцөл байдлуудаас шалтгаалан тэр бүр хамрагдаж чаддаггүй. Ингэснээр алба хаагч бүр тэгш боломжоор хангагдахгүй байгаа юм.

Улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр 1981 оноос хойш техникийн ухааны докторын зэргийг 6, хууль зүйн ухааны докторын зэргийг 2 хүн хамгаалсан байна. Мөн энэхүү чиглэлээр Дотоод хэргийн их сургуульд магистрын 47, Шинжлэх ухааны технологийн их сургууль, Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Орхон их сургууль, Төмөр замын дээд сургуулиудад магистрын 94, бакалавр зэргийн дипломын 19 ажил тус тус бичигджээ.

Алба хаагчийг нэг удаагийн сургалтаар бэлтгэн практик ажил, үүрэгт шууд нийлүүлснээр цаашид суралцан хөгжих шаардлагагүй гэх ойлголтод судлаач, практик дахь ажилтан, алба хаагчид шүүмжлэлтэй хандсаар байна.

Мөн нөгөө талаас ажлын байранд хэрэгжүүлдэг албаны болон давтан, мэргэшүүлэх сургалт нь үр дүн муутай, хоорондын уялдаа холбоогүй, тайлан, мэдээ төдийд л дурдагдаж байгааг цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо болон бүрдүүлэх хэсгүүд төлөвшөөгүйтэй холбон тайлбарлаж болох юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагчийн сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, алба хаагчийн албан тушаалын тодорхойлолт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд бэлтгэгдэж буй хөтөлбөрийн индекс зөрүүтэй, алба хаагчийг бэлтгэх, алба хаагчийн ажлын байрны бусад сургалтын уялдаа, залгамж холбоо алдагдсан, сургалтын үе шатууд, давтамжийн хувьд нэгдсэн хэв шинжгүй, сургалтаар олж авсан мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх, хянах, ажлын байрны ахих, дэвших боломжтой уялдах зохицуулалт хэрэгждэггүй зэрэг нь тулгамдсан асуудал үүсгэсээр байна.

Хууль зүйн шинжлэх ухаанд хууль сахиулагчийн сургалтын тогтолцооны суурь зарчмыг тодорхойлж, түвшинд нь тулгуурлан уялдаа, харилцан хамаарлыг судалж,

мэргэжлийн онцлог, хувь хүний онцлогт тохирсон сургалтын тогтолцоо боловсруулан нэвтрүүлэх үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтаар боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Судалгааны сэдвийг сонгон авахад нөлөөлсөн дээр дурдсан сургалтын тогтолцоонд тулгамдсан асуудал болон эрх зүйн зохицуулалт, хүчин зүйлүүд, тэдгээрийн хүрээнд дэвшүүлж буй санаа, үзэл баримтлал зэрэг нь судалгааны таамаглалын хэмжээнд ойлгогдож байгааг дурдах нь зүйтэй бөгөөд нэг сэдэвт бүтээлийн хүрээнд эдгээрт дүн шинжилгээ хийх аргаар магадлах оролдлого хийсэн болно.

Судалгааны зорилго

Хууль зүй, цагдаа судлал, боловсрол судлалын уялдаа шүтэлцээнд тулгуурлан тээврийн цагдаагийн алба хаагчийн боловсролын чиг хандлага, сургалтын онол, тогтолцоо, уламжлалыг судлан, сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх замаар тэдгээрийг боловсронгуй болгох талаар дүгнэлт, санал дэвшүүлэхэд оршино.

Судалгааны зорилт

Энэхүү зорилгыг хангах үүднээс дараах зорилтыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- ✓ Тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тогтоох, нөлөөлж буй хүчин зүйлсийг нээн илрүүлэх;
- ✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн судалгааны бүтээлүүдэд анализ хийх (Доктор, магистр, ном, бүтээлийн судалгаа);
- ✓ Цагдаагийн сургуулийн Замын цагдаагийн тэнхимийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, цаашдын чиг хандлагыг тодорхойлох;
- ✓ Замын цагдаагийн тэнхимийн хэтийн төлөв, хийгдэх ажлуудыг 2023-2026 оны хооронд (календарьчилсан төлөвлөгөө гаргах).

Судалгааны арга зүй

Энэхүү сэдвийг судлахдаа шинжлэх ухааны түгээмэл хэрэглэгддэг юмс үзэгдлүүдийн хоорондын шүтэлцээ, хамааралд тал бүрээс судлах боломж олгодог диалектик арга болон нийгмийн шинжлэх ухааны судалгааны ерөнхий ба тусгай арга болох түүхчлэх, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, загварчлах, статистикийн, социологийн зэрэг аргуудыг хэрэглэсэн.

Судалгааны шинэлэг тал

Тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог хууль зүй, цагдаа судлал, боловсролын талаас судлан, сургалтыг үр дүнтэй явуулах шинэлэг тогтолцооны загвар, баримталж болох бодлогын төсөөлөл боловсруулсан, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үйл ажиллагааг сайжруулах санал дэвшүүлсэн зэрэг нь судалгааны ажлын шинэлэг тал болно.

Судалгааны баг:

Судалгааг Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэн гүйцэтгэв.

НЭГ. ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ, ТЭДГЭЭРИЙГ БЭЛТГЭЖ, МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Тээврийн цагдаагийн албаны үүсэл, хөгжил нь Монгол улсын Авто тээвэр, Цагдаагийн байгууллагын үүсэл, хөгжилтэй холбоотой юм. Ардын засгийн газрын 1924 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 6 дугаар хурлаар хэлэлцэн “Уурын тэргийг товчлон эрхлэх газар”-ыг байгуулах, цахилгаан тэргийг хэрхэн явуулах дүрэм хэмжээг боловсруулах комиссыг томилж, мөн оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хурлын тогтоолоор Цэргийн яамны дэргэд “Уурын тэргийг товчлон эрхлэх газар”-ыг байгуулснаар энэ газар нь ачаа, зорчигчдын тээврийг зохион байгуулах, автомашин, түүний хөдөлгөөнд хяналт тавих ажлыг хариуцаж байсан байна.

Ардын засгийн газрын 1924 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 6 дугаар хурлаар байгуулсан дүрэм, хэмжээ боловсруулах комисс нь тухайн үеийн төв, суурин газрын гудамж, зах зээлээр зорчиж байгаа автомашин, ердийн хөсөг, явган явагчдын хөдөлгөөнийг журамлах явдлын чухлыг харгалдан “Аливаа гал, усны уурын хүчээр явах тэрэг зэргийг БНМАУ-ын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм”-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын 1925 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулсан нь өнөөгийн Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн анхдагч суурь нь болж хөгжлийн түүхэн үеүдэд улам бүр боловсронгуй болж иржээ.

Тус алба нь Монгол улсын хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх ажил, үйлчилгээг сайжруулах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар хуульд заасан эрх, үүрэг болон “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.1. Тээврийн цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хангалт, бүрдүүлэлт, тулгамдаж буй асуудал, шийдэл

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/208 дугаар тушаалаар тус албаны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж, Монгол Улсын нутаг дэвсгэрт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, төмөр зам, иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн газар, хэлтсийг харьяалан удирдах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Тээврийн цагдаагийн алба болон өргөжин байгуулагдсан. Тус алба нь 3 газар, 15 хэлтэс, 12 тасаг, нийт 730 алба хаагчтай үүрэг гүйцэтгэж байна. Үүнээс офицер 381, ахлагч 329, энгийн 20 алба хаагчтай. 2022 оны байдлаар офицер 57, ахлагч 70, энгийн 3 нийт 130 орон тоо дутуу үүрэг гүйцэтгэж байна.

Үүнээс үзвэл, Тээврийн цагдаагийн алба нь цагдаагийн байгууллагын нийт хүний нөөцийн 10 хүрэхгүй хувийг бүрдүүлж байгаа бол нийт зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 60-70 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих үйлдэл байдаг гэдгийг онцлох хэрэгтэй.

Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын баталсан Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийг 2021-2022 оны хичээлийн жилд “Цагдаагийн ажил-Эрх зүй”, “Аюулгүй байдал-Дотоод цэрэг” мэргэжлээр төгссөн төгсөгчдөд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах чиглэлийн дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулан, тус сургуулийн Замын цагдаагийн тэнхимийн “Цагдаагийн ажил-Эрх зүй” мэргэжлийн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэргэшүүлэх хөтөлбөр”-ийн анхны төгсөлтийн 19 офицерыг тус албаны хурлын зааланд хүлээн авч, мэдлэг бататгах 7 сэдвийн 6 цагийн сургалтыг зохион байгуулсан.


Цаашид Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлийн хууль тогтоомж, дүрэм журмыг судлуулах, практик дадлагыг гудамж замд урт хугацаанд хийх зэргээр сургалтын хөтөлбөрт шинэчлэл оруулах нь чухал асуудал болоод байна.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвтэй хамтран 2022 онд “Офицерын нөөцөд бүртгэгдсэн алба хаагчид”, Шинээр томилогдсон цагдаа зохицуулагч нарыг чадавхжуулах” сургалтыг тус бүр 1 удаа, “Цагдаа зохицуулагч болон Зохицуулагч нарыг чадавхжуулах, “Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагчдыг мэргэшүүлэх”, “Чиглэлийн ахлах, ахлах зохицуулагч нарыг мэргэшүүлэх” давтан сургалтыг тус бүр 2 удаагийн давтамжтайгаар 3 хоногийн сургалтуудыг зохион байгуулж, гэрчилгээ олгуулсан.

Тээврийн цагдаагийн алба нь Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, төмөр зам, нисэх онгоцны буудлын нутаг дэвсгэр, аюултай бүс, зурвас газарт мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, осол, хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиг үүргийг улсын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.


Боловсролын талаар: Тус албанд удирдах албан тушаалтан /газар, хэлтэс, тасгийн дарга/ 33 алба хаагч байгаагаас Дотоод хэргийн их сургууль /хуучин нэрээр Цагдаагийн дээд сургууль, Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль/-ийг эрх зүйч мэргэжлээр 21 алба хаагч буюу 63.7%, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Батлан хамгаалахын их сургуулийг авто инженер мэргэжлээр 7 алба хаагч буюу 21.3%, Тагнуулын академийг эрх зүйч мэргэжлээр 1 алба хаагч буюу 3%, хувийн сургуулийг эрх зүйч мэргэжлээр 3 алба хаагч буюу 9%, нягтлан бодогч мэргэжлээр 1 алба хаагч буюу 3% нь тус тус суралцаж төгссөн байна.

График 1. Удирдах албан тушаалтны хүний нөөц




Тээврийн цагдаагийн албанд ахлахын албан тушаалтан /ерөнхий жижүүр, ахлах зохицуулагч, ахлах мэргэжилтэн, ахлах мөрдөгч, техникийн ахлах мэргэжилтэн, жижүүрийн ахлах офицер/ 88 алба хаагч байгаагаас Дотоод хэргийн их сургууль /хуучин нэрээр Цагдаагийн дээд сургууль, Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль/-ийг эрх зүйч мэргэжлээр 45 алба хаагч буюу 51.2%, Оросын Холбооны Улс болон Батлан хамгаалахын их сургууль, Хилийн цэргийн дээд сургууль, Тагнуулын их сургуулийг эрх зүйч мэргэжлээр 7 алба хаагч буюу 8%, Оросын Холбооны Улс болон Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Батлан хамгаалахын их сургуулийг авто инженер мэргэжлээр 12 алба хаагч буюу 13.6%, энгийн сургуулийг эрх зүйч мэргэжлээр 22 алба хаагч буюу 25%, нягтлан бодогч мэргэжлээр 1 буюу 1.1%, сэтгэл зүйч мэргэжлээр 1 буюу 1.1 хувь нь тус тус суралцан төгссөн.

График 2. Ахлах албан тушаалтны хүний нөөц




Тээврийн цагдаагийн албанд дээд боловсролтой, бакалаврын болон түүнээс дээш зэрэгтэй 479 алба хаагч байгаагаас эрх зүйч мэргэжилтэй 353 алба хаагч байна. Үүнээс Улсын их дээд сургууль төгссөн /ЦДС, ЦА, ХСИС, ДХИС, БХИС, ХЦДС/ 207 алба хаагч буюу 43%, хувийн их дээд сургууль төгссөн 146 алба хаагч буюу 30% нь байна. Мөн авто инженер мэргэжлээр их, дээд сургууль төгссөн 37 алба хаагч буюу 8%, бусад мэргэжлээр Улсын болон хувийн их, дээд сургууль төгссөн 89 алба хаагч буюу 19% нь Тээврийн цагдаагийн албаны магистрын зэрэгтэй 90 алба хаагчаас 29 буюу 32,2% нь тус тус байна.

График 3. Дээд боловсролтой алба хаагчдын хүний нөөц




Дотоод хэргийн их сургууль /Цагдаагийн дээд сургууль, Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль/, 16 буюу 17.4% нь Шинжлэх ухаан технологийн их сургууль, 10 буюу 10.9% нь Улсын сургууль /Удирдлагын академи, МУИС, БХИС, МУБИС, ХААИС/, 6 буюу 6.5% нь Оросын Холбооны Улсын их дээд сургууль, бусад 29 буюу 31.5 % нь хувийн их, дээд сургуульд суралцаж магистрын зэрэг хамгаалсан алба хаагчид байна. Албан хаагчдыг магистр хамгаалсан чиглэлийн хүрээнд ангилбал:

График 4. Алба хаагчдын магистрын зэрэг хамгаалсан сургуулийн ангилал



Хууль зүйн магистр-64, техникийн магистр-8, төрийн удирдлагын магистр-13, цагдаагийн байгууллагын удирдлагын магистр-1, цагдаагийн байгууллагын удирдлагын болон хууль зүйн ухааны магистр хосолсон-1, техникийн ухааны болон хууль зүйн ухааны магистр хосолсон-2, техникийн ухааны болон төрийн удирдлагын магистр хосолсон-1 алба хаагч тус тус байна.

График 5. Алба хаагчдын магистрын зэрэг хамгаалсан мэргэжлийн ангилал



Одоогийн байдлаар Тээврийн цагдаагийн албанд докторын зэрэгтэй алба хаагч 1, ажиллаж байгаа ба хууль зүйн докторант 2, техникийн ухааны докторант 3 алба хаагч ажиллаж байна.

Дээрх судалгаанаас үзэхэд тус албаны 608 алба хаагч, ажилтан /591 алба хаагч, 17 ажилтан/-аас бага боловсролтой 2, бүрэн бус дунд боловсролтой 4, бүрэн дунд боловсролтой 97, тусгай дунд боловсролтой 26, дээд боловсролтой бакалаврын зэрэгтэй 386, магистрын зэрэгтэй 90, докторын зэрэгтэй 1, докторант 2 алба хаагч тус тус байна.

Тус албаны газар, хэлтэс, тасгийн дарга 33 алба хаагчаас эрх зүйч мэргэжилтэй 25 буюу 75.8% , авто инженер мэргэжилтэй 7 буюу 21.2%, нягтлан бодогч мэргэжилтэй 1 буюу 3% алба хаагчид байна. Мөн ахлахын албан тушаалын 88 алба хаагчаас эрх зүйч мэргэжилтэй 74 буюу 84%, авто инженер мэргэжилтэй 12 буюу 13.6%, нягтлан бодогч мэргэжилтэй 1 буюу 1.2%, сэтгэл зүйч мэргэжилтэй 1 буюу 1.2% алба хаагчид байна.

Тус алба нь харьяа газар, хэлтэс тасгийн алба хаагчдаас Дотоод хэргийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд сургалцаж байгаа 26 алба хаагч, мөн сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилд 10, 2022 оны хичээлийн жилд 10 алба хаагч тус тус суралцаж байна.

Нийт алба хаагч, ажилтнуудаас бага боловсролтой 2, бүрэн бус дунд боловсролтой 4, бүрэн дунд боловсролтой 107, тусгай дунд боловсролтой 26, бакалаврын зэрэгтэй дээд боловсролтой 405, магистрын зэрэгтэй 90, докторант 2, докторын зэрэгтэй 1 алба хаагч байна.

2022 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Цагдаагийн өөр анги байгууллагаас тус албанд шилжүүлэн томилсон 27, цагдаагийн өөр анги байгууллагаас тус албанд дэвшүүлэн томилсон 23, тус албанаас цагдаагийн өөр анги байгууллагад шилжсэн 22, тус албанаас цагдаагийн өөр анги байгууллагад дэвшин томилогдсон 25, алба дотроо шилжүүлэн томилсон 8, алба дотроо дэвшин томилогдсон 48, өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөх 13, хүүхэд асрах чөлөө олгох 4, цэргийн алба хаасны тэтгэвэрт 18, цагдаагийн цол олгох 40, нөөцөд бүртгэгдсэн иргэнийг томилж, цагдаагийн цол олгох 11, сахилгын шийтгэл оногдуулсан 18, сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцсон 1,

шагнал, урамшуулал олгох 76, цалингийн зэрэглэл, шатлал, нэмэгдлийг шинэчлэн тооцож олгох 1, Тээврийн цагдаагийн албаны албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулсан 8, Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлж, томилох 68, нийт 594 мэдэгдэл хүргүүлжээ.

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлөөс зарласан “Цагдаа” мэргэжил олгох сургалтад хамруулахдаа тухайн албан тушаалд заасан тусгай шаардлагыг харгалзан иргэдээс нээлттэй сонгон шалгаруулан судалж тэнцсэн иргэдээс томилуулан ажилладаг.

Цагдаагийн анхан шатны буюу ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалт, тэдний элсүүлэх, сургах үйл ажиллагаа нь мэргэжил сургалтын чиглэлээр буюу богино хугацаанд өнгөц мэдлэг, ур чадварыг олгож байгаа бол бакалаврын түвшний сургалт нь хэд хэдэн мэргэшүүлэх хөтөлбөртэй ч жил бүр авч байгаа төгсөгчдийг мөшгөх судалгааны үр дүнгээр төгсөгчдийн чанар сул байгаа нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэж буй сургалтын байгууллага болон захиалагч байгууллагын уялдаа холбоо муу ажиллаж байгааг илтгэж байна.

Ахисан түвшний сургалт буюу магистр, докторын сургалтад хамрагдах боломж алба хаагчдад тэгш бус байдаг бөгөөд дарга, удирдлагын арга барил, алба хаагчдыг дэмжих бодлоготой холбоотой байна. Энэ нь тухайн алба хаагч өөрийгөө хөгжүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх чухал алхам хэдий ч ажлын ачаалал, бусад хувийн шинжтэй нөхцөл байдлуудаас шалтгаалан тэр бүр хамрагдаж чаддаггүй. Ингэснээр алба хаагч бүр тэгш боломжоор хангагдахгүй байгаа юм.

1.2. Дотоод хэргийн их сургуулиас цагдаагийн байгууллага, түүний дотор тээврийн цагдаагийн албаны хүний нөөцийг сургаж буй өнөөгийн байдал, сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчлэл

Тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоонд мэргэжлийн сургалт, бакалаврын сургалт, мэргэжлийн болон судалгааны магистр, докторын сургалт, албаны сургалт зэрэг сургалтууд хамаардаг. Өөрөөр хэлбэл, алба хаагчийг анхан шатанд бэлтгэхээс эхлээд ахисан түвшний үе шатлалтай бүхий л сургалт хамаарах юм.

Дээд боловсрол олгох тогтолцооны хувьд 2014-2015 оны хичээлийн жилээс өмнө “Цагдаагийн ажил-эрх зүй” мэргэжлээр суралцаж, эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөгчдийг томилон ажиллуулж ирсэн билээ. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл, индексийн жагсаалт”-ийг шинэчлэн баталснаар “Эрх зүй” ба Цагдаа-хууль сахиулах ажил сургалтын хөтөлбөрүүд нь ерөнхий болон төрөлжсөн чиглэлийн хувьд өөр ангилалд хамаарч, одоо төгсөгч нь энгийн салбарт хөрвөх боломжгүй, цагдаагийн дээд боловсрол эзэмшиж байна. Энэ нь сургалтын хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших цогц чадамжийн хүрээг өөрчилж, мэдлэг, ур чадварын хосолсон сургалтын хэлбэрээс ур чадвар, үр дүнд суурилсан сургалтын хэлбэрт шилжих үндсэн нөхцөлийг бүрдүүлж, Цагдаа-хууль сахиулах ажил хөтөлбөрийг 2015 оноос үе шаттайгаар шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэхэд хүргэсэн юм.

Гэвч төгсөгчдийн ажлын байранд гүйцэтгэж буй үйл ажиллагаа нь хүний эрхийг хангах, хамгаалах, хуулийг нэг мөр хэлбэрэлтгүйгээр сахин биелүүлэх, хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа байдал зэрэгтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагчийг бэлтгэж буй дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг Цагдаагийн ажил-эрх зүй болгон нэршлийг өөрчилсөн хэдий ч хөтөлбөрийн индекс нь аюулгүй байдлын индекстэй байгаа юм.

Цагдаагийн дээд боловсролтой, бакалавр зэрэгтэй алба хаагчийг сургаж бэлтгэх сургалтын үйл явц нь мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн прагматик сургалтын үзэл баримтлал давамгайлсан байдлаар хэрэгжиж ирсэн уламжлалтай бөгөөд сургалтын байгууллага нь Цагдаагийн ерөнхий газрын харьяанд үйл ажиллагаа явуулж, сургалтын бодлого, үзэл баримтлал, зорилгыг ажил олгогч буюу Цагдаагийн байгууллагын удирдлага тодорхойлж ирсэн.

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “Эрх зүйн бакалаврын боловсролын стандарт /MNS 5323:2007/” батлагдсанаар хөтөлбөрийн зориулалт, суралцахуйн үр дүнг албан ёсоор тогтоож, сургалтын агуулга, технологийг нийцүүлэн шинэчлэх ажил эхэлсэн.

Энэ ажлын хүрээнд “Цагдаагийн ажил-эрх зүй” сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, мэргэжлийн боловсролын 1 жил, бакалаврын 4 жилийн шаталсан, нийт 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр баталсан байдаг. Энэ хөтөлбөрийн зориулалтыг тодорхойлохдоо сургалтын эхний жилд цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн мэргэжлийн боловсролын зэргийн сургалт, дараагийн 2 жилд дээд боловсролын болон мэргэжлийн суурь мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн сургалт, төгсгөлийн 2 жилд төгсөгчийн ажиллах ажлын байрны төрөлжүүлэн

ангилсан 4-5 чиглэл тус бүрээр мэргэшүүлэх мэдлэг, ур чадвар олгох сургалтыг цогцолбор хэлбэрээр зохион байгуулж, эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөхөөр тодорхойлжээ. Сургалтын хөтөлбөрийн зорилго болох мэргэжилтний загвар, чадамжийг хүрээг тодорхойлж, хичээлүүдийн агуулгыг түүнд чиглүүлэн боловсруулахаар төлөвлөсөн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/183 дугаар Сургалтын хөтөлбөрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалаар Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг өөрчлөх ажлын хэсэг байгуулагдаж, 2 шатлалт 6 жилийн сургалтын хөтөлбөрийг өөрчилж, 4 жилийн сургалттай хөтөлбөрт шилжүүлэх шийдвэрийг баталгаажуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/336 дугаар тушаалаар “Мэргэжлийн чиглэл, индексэд өөрчлөлт оруулах тухай” шийдвэр гарч, энэ шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд D103201 (Аюулгүй байдал) индекстэй “Цагдаагийн ажил-эрх зүй” хөтөлбөрийг шинээр боловсруулан 2019-2020 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоо “Цагдаа судлал” гэсэн нэршилтэйгээр аюулгүй байдлын мэргэжилтнээр төгсгөж байна.

Гэтэл ЦЕГ-ын даргын А/154 дугаар тушаалаар баталсан албан тушаалын тодорхойлолтод үндсэн чиг үүрэг хэрэгжүүлэх офицер албан тушаалтан нь “Эрх зүйч” байх шаардлага тавигдаж байгаа нь зөрчилдөж байна.

Цагдаагийн алба хаагч бэлтгэх сургалтын технологи, арга зүйг олон улсын жишигт ойртуулах, академик сургалт давамгайлсан хөтөлбөрөөс прагматик буюу чадваржуулах сургалт давамгайлсан хөтөлбөрт шилжих, чадваржуулах сургалтын шинэ технологийг судлан нутагшуулах, мэдээллийн технологийн ололтод тулгуурласан цахим сургалтын технологийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөн хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлээс тодорхой ажиглагдаж байгаа юм.

Мөн дэлхийн бусад орны жишгээр их, дээд сургууль төгссөн элсэгчдийг авч 2 жилийн сургалтад хамруулан бакалаврын сургалтын үйл ажиллагааг явуулж эхлээд байна.

Хүснэгт 1. Цагдаа мэргэжлээр суралцаж төгссөн суралцагчдын судалгаа

№	Он	Мэргэжил	Төгсөгчийн тоо
1	2012	Цагдаа	201
2	2013	Цагдаа	340
3	2014	Цагдаа	211
4	2015	Цагдаа	196
		Цагдаа жолооч	42
5	2016	Цагдаа	256
		Цагдаа жолооч	43
6	2017	Цагдаа	281
		Цагдаа жолооч	59
7	2018	Цагдаа	485
		Цагдаа жолооч	128
8	2019	Цагдаа	152
		Цагдаа жолооч	33
9	2020	Цагдаа	487
		Цагдаа жолооч	155
10	2021	Цагдаа	159
		Цагдаа жолооч	28
11	2022	Цагдаа	866
		Цагдаа жолооч	124

Цагдаагийн офицер бүрэлдэхүүнийг Цагдаагийн сургууль бэлтгэж байгаа бөгөөд цагдаа судлал гэсэн хөтөлбөрөөр бакалаврын түвшинд бэлтгэж байна. Цагдаагийн судлал хөтөлбөр нь дотроо хэд хэдэн мэргэшүүлэх хөтөлбөртэй. Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдал
- Эдийн засгийн мөрдөгч
- Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил
- Мөрдөх алба
- Кибер аюулгүй байдал
- Цагдаа судлал эчнээ гэсэн мэргэшүүлэх хөтөлбөрүүд багтана.

Цагдаагийн байгууллага нь чиг үүргийнхээ хүрээнд олон төрөл, мэргэжлийн албадтай тул тэдгээр ялгаатай чиг үүрэг бүхий алба хаагчдыг бүгдийг нь төрөлжүүлэн бэлтгэх нь учир дутагдалтай. Олон улсад цагдаагийн алба хаагчийг анхан шатны, офицер албан тушаалын, мэргэшүүлэх, удирдах түвшний зэрэг сургалтуудаар бэлтгэдэг нь жишиг болоод байна. Манай улсын хувьд бакалаврын буюу офицер албан хаагчийг бэлтгэж буй энэхүү сургалтын хөтөлбөр нь хэд хэдэн удаа шинэчлэгдсэн бөгөөд мэргэжлийн индексийн хувьд аюулгүй байдлын үйлчилгээний индекстэй хэвээр байгаа юм.

Тээврийн цагдаагийн удирдах албан тушаалтнууд болон иргэдтэй хийсэн фокус ярилцлагын үр дүнд бид дараах дүгнэлтийг хийсэн юм. Дээд боловсролтой алба хаагчийг бэлтгэхдээ юун түрүүнд замын хөдөлгөөний аюулгүй байдал гэх зэргээр ангилж сургахаас илүүтэй нийтлэг, ерөнхий цагдаагийн алба хаагчийн онцлог, ур чадвар, тэсвэр хатуужил, хариуцлага, сахилга батыг эзэмшүүлэхэд гол анхаарлыг хандуулах нь чухал бөгөөд шинээр төгссөн алба хаагч нь эхний жилүүдэд хэв журам сахиулах, эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх, зөрчил шалган шийдвэрлэх, объект, субъектийн судалгаа хийх зэргээр хэсгийн байцаагч, эргүүлийн офицер, хэсгийн төлөөлөгчийн ажлыг хийж гүйцэтгэх нь илүү тохиромжтой. Ингэснээр төгсөгчийг цагдаагийн албанд дасгах, дадлагажуулснаар замын хөдөлгөөний

аюулгүй байдлыг хангахад улам гүнзгий, нарийн үйл ажиллагаатай албанд ажиллах нь үр дүнтэй гэж дүгнэж байна.

Нөгөөтээгүүр замын хөдөлгөөний аюулгүй байдал, эдийн засгийн мөрдөгч, кибер аюулгүй байдал зэрэг чиглэлээр ерөнхий боловсролын сургууль төгссөн суралцагчийг шууд бэлтгэн төгсгөх нь учир дутагдалтай бөгөөд энэ чиглэлээр өмнө их, дээд сургууль төгссөн эсвэл цагдаагийн алба хаагчийг энэ чиглэлээр мэргэшүүлэх тодорхой түвшний боловсрол эзэмшсэний дараа ажиллуулах нь илүү ач холбогдолтой юм.

Бакалаврын хөтөлбөрт элсэгчдийг шалгаруулахдаа жил бүрийн элсэлтийн журмыг баримталдаг хэдий ч элсэгчдийн чанар тааруу гэж дүгнэдэг нь фокус ярилцлагын үр дүнгээс харагдсан.

Тус хөтөлбөрт элсэгч нь их, дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтад харгалзах босго оноог давсан үзүүлэлттэй байх, насны хувьд эрэгтэй 17-25 насны, эмэгтэй 17-20 хүртэлх настай байх, ял шийтгүүлж байгаагүй, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүй, ярилцлагад тэнцсэн байх зэрэг шалгуурыг хангах ёстой.

Харин хоёр жилийн хөтөлбөрт элсэгч нь бакалаврын боловсролтой байх шаардлагатай бөгөөд голч дүн нь төрийн өмчийн сургууль бол 2.5, төрийн бус өмчийн сургууль бол 3.0-аас доошгүй байх, эдийн засаг, сэтгэл судлал, нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, даатгал, байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, мэдээлэл харилцаа холбооны технологи, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээгч, ХАА мал эмнэл зүй, эрүүл мэнд, цэрэг, батлан хамгаалахын мэргэжил эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.

Цагдаа мэргэжлийн сургалтад цагдаагийн алба хаагчийн заавал судалсан байх анхан шатны хичээлүүдийг агуулсан бөгөөд суурь мэдлэг, арга барилыг олгоход түлхүү анхаарч байна.

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс
2. Нийтийн хэв журам хамгаалах
3. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах
4. Зөрчил шалгах ажиллагааг явуулах
5. Хөдөлмөр, хамгаалал аюулгүй ажиллагааг хангах
6. Амьд үлдэх ур чадварыг эзэмших
7. Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх
8. Хүний эрхийг цагдаагийн байгууллага хангах
9. Компьютерын хэрэглээ, албан хэрэг хөтлөлтийг хангах
10. Цэргийн нийтлэг дүрмүүдийг хэрэгжүүлэх
11. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцааны сэтгэл зүй
12. Албадлагын арга хэмжээг хэрэглэх
13. Замын хөдөлгөөн зохицуулах, хяналт тавих
14. Хойшлуулшгүй ажиллагаа явуулах гэсэн хичээлүүдийг үзэж, судалдаг бөгөөд

үйлдвэрлэлийн дадлагаар бататгана. Энэ нь цагдаа мэргэжлээр анхан шатанд суралцаж буй иргэдэд практик үйл ажиллагаа буюу цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх чиг, үүргийг стандарт буюу хамгийн энгийн нөхцөл байдалд хэрхэн биелүүлэх талаар мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд гол зорилго нь оршиж байна.

Харин “цагдаа судлал” бакалаврын хөтөлбөрийн хувьд дараах хичээл сургалтууд хамаарна. Үүнд:

Хүснэгт 2. Цагдаа судлал хөтөлбөрийн хичээл

№	Шалгалтын төрөл	Хичээлийн нэр
1	Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны цогцолбор	Криминологи
2		Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги
3		Эрүүгийн эрх зүйн тусгай анги
4		Криминалистикийн техник зүй
5		Эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий анги
6		Эрүүгийн процессын эрх зүйн тусгай анги
7		Криминалистикийн тактик, арга зүй
8		Гэмт хэргийн нотолгоо, зүйлчлэлийн онол
9		Шүүхийн шинжилгээ зүй
10		Мэргэжлийн сонгох-1
11	Нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагааны цогцолбор	Цагдаагийн эрх зүй
12		Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа
13		Нийтийн хэв журам хамгаалах тактик
14		Бие хамгаалах бэлтгэл
15		Галт зэвсэг, тусгай бэлтгэл
16		Тактик, тусгай бэлтгэл
17		Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа
18		Замын хөдөлгөөний хяналт, зам тээврийн ослыг шалгах ажиллагаа
19		Мэргэжлийн сонгох-1
20	Тагнах үйл ажиллагааны цогцолбор	Тагнах үйл ажиллагааны тактик

Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогт тулгуурлан эдгээр багц хичээлүүдийг тус хөтөлбөрт тусгасан бөгөөд цагдаагийн байгууллагад анх томилогдох алба хаагчид ажлын байрны тодорхойлолтын дагуу эдгээр мэргэжлийн хичээлийг судалж байна.

Үүнээс үзвэл, эдгээрээс 14 буюу 70% нь эрх зүйн агуулгатай хичээл судалж байгаа нь харагдаж байна.

Харин магистр, докторын түвшний сургалтад судалгааны арга, зүйг түлхүү агуулсан байх бөгөөд суралцагч тухайн мэргэжлийн онцлогоос сонгон судалгаа хийж, санал дүгнэлт дэвшүүлж, мэдлэг оюуны хувь нэмэр оруулдаг. Мэргэжлийн хичээлүүдийг илүү гүнзгийрүүлж, тухайн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэн, судлаачдаас сургалт, зөвлөгөө авдаг нь эдгээр сургалтын онцлог юм.

1.3. Тээврийн цагдаагийн алба хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал

Тээврийн цагдаагийн алба хаагч, бие бүрэлдэхүүний албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр ЦЕГ-ын дарга батлан хэрэгжилтийг ханган ажилладаг. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах журам болон хүний нөөц, сургалтын үйл ажиллагааг зохицуулсан холбогдох бусад журмуудыг удирдлага болгон дараах төрлөөр явуулдаг.

- *Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт;*
- *Алба хаагчийг хөгжүүлэх сургалт;*
- *Дадлагажуулах сургалт;*
- *Бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах сургалт;*
- *Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах сургалт;*
- *Алба хаагчийн давтан, мэргэшүүлэх сургалт.*

Цагдаагийн алба хаагч жилд 3.5-5.0 кредит цаг буюу 60-80 цагийн танхимын болон цахим хэлбэрийн сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байхаар хөтөлбөрт тусгадаг. Алба хаагчдад явуулсан албаны сургалтыг дүгнэхдээ сургалтаар олж авсан мэдлэг, ур чадварыг бататгах сорил, тестээр үнэлэх, хамрагдсан байдал, идэвх оролцоо, багц цагийг шалгалтаар үнэлж, хагас бүтэн жилээр байгууллагын хэмжээнд дүгнэхээр зохицуулсан хэдий ч практикт үр дүнтэй болж чадахгүй байна.

Албаны сургалтыг зохион байгуулах төлөвлөгөөнд зохион байгуулах сургалтыг төрөл, сэдвийг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг алба, нэгжүүд хариуцдаг.

Албаны сургалтын хөтөлбөр, нэгж сургалтын хөтөлбөр тодорхойгүй, сургагч багш, заах арга зүй, хичээлийн агуулга байхгүй нь жил бүр хэдэн алба хаагчдад аль чиглэлээр хэдэн цагийн сургалт орсон талаар тайлагнасан зэргээс ажиглагдсан болно.

Албаны сургалтын чанар үр дүнг энэхүү судалгааны санал асуулгаар боловсруулж, цагдаагийн байгууллагын алба хаагчдаас авсан бөгөөд үр дүнг нэгтгэхэд сургалтын бэлтгэл ажил, үйл явц, үр дүн тааруу, сургагч багш нарын заах арга барил муу, сургалт үр дүнгүй, сургалтын хамрах хүрээ тодорхойгүй байдаг гэсэн үр дүнгүүд гарсан.

Мөн албаны сургалтыг зохион байгуулалт, эргээд үнэлэх үр дүн хангалтгүй байдаг нь үргүй зардал гаргах хүчин зүйл болж байна. Өөрөөр хэлбэл, ямар албан хаагч, аль сургалтад аль улиралд хамрагдах зэрэг нь огт төлөвлөгдөөгүй байдаг нь сургалтын хүрэх үр дүнд шууд сөргөөр нөлөөлж байна.

Тээврийн цагдаагийн алба хаагчийн хамрагдах сургалт дэлхийн улс орнуудад хэд хэдэн төрөл болж хэрэгжиж байна. Тухайлбал,:

- *Ажилд авах үеийн;*
- *Жил бүрийн тогтмол сургалт;*
- *Мэргэжил дээшлүүлэх сургалт;*
- *Дадлагажилт;*
- *Ажлын байран дээрх сургалт;*

- *Ажил сэлгэх үеийн сургалт;*
- *Дагалдан сургалт;*
- *Зөвлөх сургалт;*
- *Ажлын байрнаас гадуурх сургалт зэргүүд багтаж байна.*

ДХИС-ийн үйл ажиллагааны журамд “Цагдаагийн мэргэжлийн сургалт гэж цагдаагийн ажил эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагаа юм”¹ гэж тодорхойлжээ.

Тээврийн цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын тогтолцоонд их сургуулийн талаас дээрх сургалтууд хамаарч байгаа ч харилцан хамаарал, үйлчлэлцэл, эрх зүйн зохицуулалтын хувьд нэгдмэл шинжийг хангахгүй байгаа нь практик дээр батлагддаг. Нөгөөтээгүүр практикийн сургалт буюу алба хаагчдын албаны сургалт нь харилцан хамаарлын хувьд тусдаа байгаа нь сөрөг талтай.

Цагдаагийн байгууллагын сургалтын тогтолцоог цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд дараах байдлаар авч үзсэн. Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, хөгжүүлэх сургалтын тогтолцоо² нь дараах сургалтын төрлүүдээс бүрдэж байна:

- а/цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт;
- б/цагдаа-мэргэжлийн дээд боловсролын сургалт /бакалавр, магистр, доктор/;
- в/цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт;
- г/иргэд, олон нийтэд чиглэгдсэн бусад сургалт.

Энэ нь бидний дэвшүүлж буй сургалтын тогтолцоотой ижил байдлаар ангилсан хэдий ч иргэд, олон нийтэд чиглэсэн бусад сургалт гэсэн ангилал цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын тогтолцоонд хамаарахгүй гэж үзэж байна.


Сургалтыг хэрэгжүүлж байгаа байгууллагын хувьд ДХИС нь мэргэжлийн, бакалаврын, магистр, докторын сургалтыг хэрэгжүүлдэг бол ЦЕГ-аас албаны бусад сургалтыг хэрэгжүүлж байна.

Энэ нь зайлшгүй туулах шат дамжлага биш бөгөөд цагдаагийн алба хаагчдыг дээрх сургалтын тогтолцоонд байгаа аль нэг төрлөөр нь бэлтгэж, ажлын байранд сургаж байна гэж дүгнэж болно.


¹ Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны журам. 202-01

² ЦЕГ-ын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /код 118/ журам”

Бүдүүвч 1. Тээврийн цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагаас хэрэгжүүлж буй сургалтын тогтолцоо (өнөөгийн байдлаар)



Бүдүүвч 2. Цагдаагийн төв байгууллагаас хэрэгжүүлж буй сургалтын тогтолцоо (өнөөгийн байдлаар)



Сургалтын тогтолцоо нь хэд хэдэн шатлалтай байх боловч тэдгээр шатлалаар заавал дамжих шаардлагагүй байгаа төдийгүй аль нэг нөхцөлөөр бэлтгэгдэж, цагдаагийн албанд орж ажиллах боломж бүрдэж байна. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн анхан шатны буюу Ахлагчийн мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв, офицер албан хаагчийг бэлтгэж буй цагдаагийн сургуулийн бакалаврын хөтөлбөр нь цагдаагийн албанд орж ажиллах иргэнд албан сургалтын шинжтэй, Цагдаагийн төв байгууллагаас зохион байгуулах сургалтууд нь цагдаагийн алба

хаагчдад албан сургалтын шинжтэй бол магистр, докторын сургалт нь албан бус шинжийг агуулж байна.

Дотоод хэргийн их сургуулийн тухайд одоогийн байдлаар төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэдэг суурь болсон Их сургууль бөгөөд төгсөгчид нь 100 хувь ажлын байраар хангагддаг.

Энэ нь тухайн сургуульд монопол байх боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд өрсөлдөх чадвар төдийлөн шаардагддаггүй. Гэвч аливаа байгууллага эрсдэлээс сэргийлж, эрсдэлийн менежмент хийж байх шаардлагатай учир монопол байдлаа хадгалж үлдэхийн тулд ажлын байранд гарч буй өөрчлөлтүүдийг цаг алдалгүй судлах, оюутан, төгсөгч, ажил олгогч талуудын оролцоог дэмжих, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулдаг, урамшуулдаг, ур чадварын зөрүүгүй мэргэжилтэн бэлтгэх зайлшгүй шаардлагатай юм. Энэ бол удирдлагын менежментийн томоохон анхаарвал зохих асуудал учир шат шатны менежерүүд анхаарах шаардлагатай байна.

ДХИС-ийн Ахлагчийн мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв нь цагдаагийн ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэж, мэргэжлийн анхан шатны сургалтыг зохион байгуулдаг. Харин тус их сургуулийн Цагдаагийн сургууль нь аюулгүй байдлын чиглэлээр бакалаврын зэрэгтэй офицер бэлтгэхээс гадна магистр, докторын түвшний сургалтыг эрхлэн явуулж байна. Мөн тус их сургуулийн Удирдлагын академи нь цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнуудад Цагдаагийн удирдлага-стратегийн, тактик хөтөлбөрөөр мэргэжлийн магистрын хөтөлбөрт сургадаг жишиг тогтоод байна.

Харин Цагдаагийн ерөнхий газраас цагдаагийн нийт алба хаагчдад жил бүрийн батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу албаны, мэргэшүүлэх, зорилтот сургалтуудыг зохион байгуулдаг.

Үүнээс үзвэл, цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх түвшинд мэргэжлийн болон бакалаврын сургалт зайлшгүй шаардлагатай бол ахисан түвшний сургалтууд нь тухайн алба хаагчийн хүсэлт, удирдлагын шийдвэрт үндэслэн хамрагдах боломжийг бүрдүүлж байна.

Тээврийн цагдаагийн албаны анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт. Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалтыг цагдаагийн төв байгууллагын захиалгаар цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар зохион байгуулдаг.

Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалтад цагдаагийн албан тушаалд шинээр томилогдох иргэнийг сонгон шалгаруулах шалгалтад тэнцсэн, бүрэн дунд ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй иргэнийг элсүүлэн суралцуулж, төгсөгчдөд мэргэжлийн үнэмлэх олгоно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал-мэргэжлийн дээд боловсролын сургалт. Цагдаагийн мэргэжлийн бакалаврын зэргийн боловсролтой алба хаагчийг цагдаагийн төв байгууллагын захиалгаар цагдаагийн ажилтан, төрийн тусгай чиг үүрэг бүхий алба хаагчийг

бэлтгэх сургалтын тусгай зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын их, дээд сургууль, академид бэлтгэдэг.

Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллагын захиалгаар магистр, докторын сургалтад суралцсан алба хаагчийн судалгааны ажлын хувийг албаны хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх, Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгж нь уг бүтээлийг алба хаагчдад сурталчлах, шаардлагатай бол гарын авлага, зөвлөмж хэлбэрээр хэвлүүлж нийтийн хүртээл болгох, судалгааны ажлын дүгнэлт, дэвшүүлсэн саналыг судалж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, танилцуулж, шийдвэрлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулдаг.

Цагдаагийн алба хаагчийг гадаад, дотоодод мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтад хамруулах болон төрийн ба төрийн бус байгууллага, их, дээд сургууль, академитай хамтарч сургалтыг зохион байгуулах ажлыг цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж, Сургалтын ажил хариуцсан нэгж, бүсийн сургалтыг нутаг дэвсгэрийн хариуцсан цагдаагийн байгууллага тус тус хариуцан зохион байгуулдаг.

Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл нь цагдаагийн алба хаагчаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэх мэдлэг, ур чадварыг олгоход чиглэгддэг.

Цагдаагийн мэргэжлийн бэлтгэл нь дараах төрөлтэй байна.

а/Мэргэшүүлэх сургалт;

б/Ур чадварын сургалт;

в/Чадавхжуулах сургалт;

г/Албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын сургалт;

д/Ёс зүйн сургалт.

Давтан сургалт нь алба хаагчийн урьд нь олж авсан мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгддэг. Тус сургалтыг цагдаа, дотоодын цэргийн сургалт хариуцсан нэгж, бүсийн сургалтын төвүүд зохион байгуулдаг.

Албаны сургалт нь цагдаагийн төв, харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулагддаг байна.

Албаны сургалт нь дараах төрөлтэй байна. Үүнд:

а/ажлын байрны сургалт;

б/алба хаагчийн үргэлжилсэн сургалт;

в/ажлын байран дээрх албаны сургалт.

Ажлын байрны сургалт нь шинээр томилогдсон алба хаагчдад ажлын байрны чиг үүргийг гүйцэтгэх мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, түвшнийг нь дээшлүүлэх, ажил, албанд хандах хандлага төлөвшүүлэхэд чиглэдэг.

Алба хаагчийн үргэлжилсэн сургалт нь мэргэшлийн мэдлэг, ур чадвар, боловсролын түвшнийг тасралтгүй дээшлүүлэх, алба хаагчийн өөрөө сурч, хөгжих хандлагыг төлөвшүүлэх, эрмэлзлийг дэмжиж, хөгжүүлэхэд чиглэдэг.

Ажлын байран дахь албаны сургалт нь алба хаагчдын мэдлэг, ур чадварыг ажлын байрнаас хөндийрүүлэхгүйгээр дээшлүүлэхэд чиглэдэг.

Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах тухай сургалтыг төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно”, 17.2 дахь хэсэгт “Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэж заасан нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалтын байгууллагын тогтолцоог төдийгүй сургалтын зорилго, төрөл, хэлбэрийг тогтоосон хэрэг юм.

Тээврийн цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалтыг цагдаагийн төв байгууллагын захиалгаар цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна.

ДХИС-ийн Ахлагчийн мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв нь цагдаа, цагдаа жолооч гэсэн модуль сургалтыг зохион байгуулдаг бөгөөд сүүлийн 10 жилд нийт 3634 цагдаа, 612 цагдаа жолоочийг бэлтгэсэн. Үүнээс үзвэл, жилд дунджаар цагдаагийн байгууллагад 400 орчим цагдаа, цагдаа жолоочийг бэлтгэн гаргаж байна. Энэ нь нийт 11 мянга орчим алба хаагчтай харьцуулахад маш өндөр үзүүлэлт юм.

Өөрөөр хэлбэл, цагдаагийн анхан шатны сургалтын үйл ажиллагаа нь мэргэжлийн анхан шатны ойлголтыг өгөх үүднээс хөтөлбөр, төлөвлөгөө нь ХНХЯ-ны сургалтын бодлогод суурилж байгаа нь цагдаагийн байгууллагын алба хаагчийн анхан шатны ойлголтыг олгоход учир дутагдалтай байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 1. ДХИС-иас Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиглэлээр гадаадын байгууллагатай хамтран ажиллаж буй байдал

№	Улс	Байгууллага	Санамж бичиг байгуулсан огноо	Баримт бичгийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
2016 он				
1	БНСВУ	Ардын Цагдаагийн академи	2016.04.11	Оюутан солилцоо ОУЭШХ
2	ОХУ	ДХЯ-ны харьяа Удирдлагын академи	2016.04.28	Туршлага судлах. Оюутан солилцоо ОУЭШХ
2017 он				
3	БНСУ	Чангшин их сургууль	2017.02.20	Зочин багш Оюутан солилцоо 2+2 хамтарсан хөтөлбөр
2019 он				
4	ОХУ	ДХЯ-ны харьяа Сибирийн хуулийн дээд сургууль	2019.07.08	Оюутан солилцоо
2020 он				
5	БНХАУ-ын ӨМӨЗО	Цагдаагийн ажил мэргэжлийн дээд сургууль	2020	Оюутан солилцоо

ДХИС нь чиг үүргийн хүрээнд ижил, төстэй гадаад орны их, дээд сургуулиудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, түүнийхээ хүрээнд оюутан солилцох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал, БНСВУ-ын Ардын Цагдаагийн академи, ОХУ-ын ДХЯ-ны харьяа Удирдлагын академи, Сибирийн хуулийн дээд сургууль, БНСУ-ын Чангшин их сургууль, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Цагдаагийн ажил мэргэжлийн дээд сургууль гэсэн сургуулиудтай оюутан солилцооны чиглэлээр санамж бичиг байгуулсан байна.

Үүнээс үзвэл, тус сургуулиар дамжин гаднын их, дээд сургуульд цагдаагийн чиглэлээр их, дээд сургууль төгсөж ирсэн төгсөгчийг цагдаагийн албанд мөн томилон ажиллуулах боломжтой бөгөөд үүнийг зохицуулсан журам, шийдэл хараахан байхгүй байна.

Мөн цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй сургалтууд нь цаг үеийн нөхцөл, байдалд тулгуурлан сэдэв, зохион байгуулалтыг авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай байгаа хэдий ч сургалтын үнэлгээ, гарч буй үр дүн нь тодорхойгүй байна.

Мөн жил бүр өөр өөр сургалтуудыг зохион байгуулдаг, хамруулж буй алба хаагчдын хүрээ тодорхой бус, сэдэв зэрэг нь давтагдсан тоогоор тайланд тусдагаас үүдэлтэй жил бүрийн үр дүнг тооцоход хоорондын уялдаа холбоо, үр дүнг тооцох боломжгүй байгаа нь судалгаагаар авсан тайлан, санал асуулгын үр дүнгээр нотлогдож байна.

Тээврийн цагдаагийн албаны хүний нөөцийг бэлтгэх, тэднийг хөгжүүлэх, дадлагажуулан бэлтгэх, сургах талаар манай орны хувьд олон төрлийн сургалтыг зохион байгуулж буй талаар бид авч үзлээ. Тэдгээр сургалтын харилцан уялдаа, холбоо, тогтолцооны хувьд нэг нэгэндээ залгамж холбооны чанар сул байдаг нь харагдаж байна.

Анхан шатны буюу ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалт, тэдний элсүүлэх, сургах үйл ажиллагаа нь мэргэжил сургалтын чиглэлээр буюу богино хугацаанд өнгөц мэдлэг, ур чадварыг олгож байгаа бол бакалаврын түвшний сургалт нь хэд хэдэн мэргэшүүлэх хөтөлбөртэй ч жил бүр авч байгаа төгсөгчдийг мөшгөх судалгааны үр дүнгээр төгсөгчдийн чанар сул гэж дүгнэгддэг.

Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулдаг албаны, мэргэшүүлэх, давтан сургалт нь тогтсон чанар, стандартгүй, хүрэх үр дүн, үнэлгээ нь тодорхойгүй, сургагч багш нарын чанар муу зэрэг сэтгэгдэл алба хаагчдаас авсан фокус ярилцлагын үр дүнд ажиглагдаж байна.

Аль ч мэргэжлийн хувьд ажлын байрны сургалт нь хамгийн чухал практикийн ач холбогдолтой. Цагдаагийн байгууллагын албаны сургалт ч гэсэн алба хаагчдад ус, агаар шиг хэрэгтэй мэдлэг, ур чадварыг олгож байх шаардлагатай. Гэвч энэхүү сургалт нь алба хаагчдыг бэлтгэж буй сургалттай уялдаа, холбоогүй, нэгдсэн стандартгүй, үр дүнгүй болж буй нь зохион байгуулалттай холбоотой.

Ахисан түвшний сургалт буюу магистр, докторын сургалтад хамрагдах боломж алба хаагчдад тэгш бус байдаг бөгөөд дарга, удирдлагын арга барил, алба хаагчдыг дэмжих бодлоготой холбоотой байна. Энэ нь тухайн алба хаагч өөрийгөө хөгжүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх чухал алхам хэдий ч ажлын ачаалал, бусад хувийн шинжтэй нөхцөл байдлуудаас шалтгаалан тэр бүр хамрагдаж чаддаггүй. Ингэснээр алба хаагч бүр тэгш боломжоор хангагдахгүй байгаа юм.

Хүснэгт 2. Тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын зохион байгуулалтын өнөөгийн байдалд хийсэн “*SWOT*”, “*TOWS*” шинжилгээ

	<i>Давуу тал-S</i>	<i>Сул тал-W</i>
Дотоод хүчин зүйл	<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн алба хаагчийн сургалт зохион байгуулах хууль эрх зүйн орчин бий. - Бүх шатны сургалт зохион байгуулагддаг. - Суралцах орчин хангалттай. - Сургалтын хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн, ур чадварыг нэмэгдүүлэх, дадлагад тулгуурласан сургалтын хөтөлбөр боловсруулсан. - Дотоод гадаадад суралцах боломжтой. - Төрөлжсөн, олон түвшний сургалттай. - Цаг үеийн шинжтэй сургалтад нийт бие бүрэлдэхүүнийг тогтмол хамруулдаг. - Сургалтын зарим хөтөлбөр нь боловсролын магадлан итгэмжлэлд бүргэгдсэн. - Сургалтад элсэх хөтөлбөрүүд уян хатан. 	<ul style="list-style-type: none"> - Эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт сул. - Алба хаагчийн сургалтын үйл ажиллагааны харилцан уялдаа сул. - Алба хаагчийг бүх түвшинд бэлдэх үзэл баримтлал байхгүй. - Мэргэжлийн индекс, ажлын байрны тодорхойлолт зөрүүтэй. - Цагдаагийн байгууллагад алба хаагчид тогтвор суурьшилтай ажилладаггүй. - Сонгон шалгаруулах, сургалтад элсүүлэх чанар муу. - Ажлын ачаалал ихтэй. - Ажлын байрны сургалт үр дүнгүй.
Гадаад хүчин зүйл		
Боломж-O	OS стратеги	OW стратеги
<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн албаны тухай хууль, цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой. - Бусад хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага, гадаадын байгууллагуудтай хамтарч сургалт, бэлтгэлийг зохион байгуулах боломжтой. - Цаашид сургалтын зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж, дараагийн сургалтад тусгах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэглэж хэвших. - Цагдаагийн алба хаагчийн сургалтын талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинээр боловсруулж, батлуулж, мөрдүүлэх. - Цагдаагийн алба хаагчийг бэлдэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагын бүтэц, орон тоог өөрчлөлгүй үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх, Цагдаагийн төв байгууллагын сургалт хариуцсан нэгжийг өргөжүүлэн үйл ажиллагааны чиглэл, орон тоог шинэчлэх. - Цагдаагийн алба хаагчийн 	<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн алба хаагчийг бүх түвшинд бэлдэх, хөгжүүлэх сургалтын уялдаа холбоог хангасан тогтолцооны загварт оруулах. - Цагдаагийн алба хаагчийн ажлын байрны сургалтын ангиллыг шинэчлэх. - Цагдаагийн алба хаагчийн сургалтын үр дүнгээр ахиж, дэвших боломжийг тогтоох.

	сургалтын үйл ажиллагаанд баримтлах үзэл баримтлалын төслийг боловсруулж, холбогдох яам, агентлагаар дамжуулан албажуулж, хэрэгжүүлэх боломжтой.	
Эрсдэл /Аюул занал/ -Т	ST стратеги	WT стратеги
<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн алба хаагчийн албан тушаалд мэргэжлийн бус хүмүүс томилогдох нь боловсон хүчний чадавх алдагдах эрсдэлтэй. - Цагдаагийн алба хаагчийг сурган, бэлтгэж, хөгжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэхгүй бол ажлын байранд хүний нөөцийн хомсдол бий болох эрсдэл үүсэх. 	<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо нь “Мэргэжил олгох сургалт”, “Албаны бэлтгэл сургалт”, “Давтан, мэргэшүүлэх сургалт”, “Боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт” гэсэн хоорондоо харилцаа хамаарал бүхий дэд тогтолцооноос бүрдсэн бүтэцтэй байх нь оновчтой бөгөөд тус бүрийн дэд тогтолцоо бүхий сургалтуудыг холбосон үйл явцын дэс дарааллыг харах боломжтой юм. 	<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн байгууллага нь сургалт, судалгааг тусдаа авч хэрэгжүүлж байгаа нь сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, - Цагдаагийн алба хаагчийн сургалтад хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх нь хөгжих боломжийг хязгаарлах.

Тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын зохион байгуулалтын үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн **“SWOT”, “TOWS”** шинжилгээнээс үзэхэд хууль эрх зүйн орчин бүрдсэн, мэргэжлийн болон мэргэшүүлэх сургуулиудтай, удирдах албан тушаалтны сургалтын хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн, ур чадварыг нэмэгдүүлэх, дадлагад тулгуурласан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтад хамруулдаг нь давуу талтай байна.

Сургалтын талаарх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, алба хаагчийн сургалтын үйл ажиллагааны харилцан уялдаа сул, алба хаагчийг бүх түвшинд бэлдэх үзэл баримтлал байхгүй, мэргэжлийн индекс, ажлын байрны тодорхойлолт зөрүүтэй, тогтвор суурьшилтай ажилладаггүй, ажлын ачаалал ихтэй, ажлын байрны сургалт муу зэрэг сул талтай байна.

Боломжийг ашиглаж сул талаа арилгах, давуу талаараа аюулаас зайлсхийх, сул тал, аюул заналыг бууруулах боломжтой гэж үзэж байна.

Дээрх өгүүлснийг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Офицер бүрэлдэхүүний хувьд ажлын байрны тодорхойлолтоор ихэнх нь эрх зүйч мэргэжилтэй байх, зарим ажлын байрны онцлогоос хамаарч хос мэргэжилтэй байх хэрэгцээ тулгардаг бөгөөд өнөөгийн байдлаар эрх зүйч мэргэжлийн индекстэй алба хаагчийг төгсгөхгүй байгаа нь ажлын байрны шалгуурт нийцүүлэхгүй байгаа нэг хэлбэр юм.

Цагдаагийн төв байгууллагаас жил бүр цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлдэг хэдий ч хэрэгжүүлж буй сургалтын үйл ажиллагаа тогтворгүй, нэгдсэн стандартгүй, сэдэв, ангилал, хүрэх үр дүн тодорхойгүй байгаа нь жил бүрийн тайлан мэдээнээс ажиглагдаж байна.

Алба хаагчийг бэлтгэх, хөгжүүлэх сургалтын тогтолцоог алдаатай ангилсан нь сургалтуудын уялдаа холбоо, ялгаа заагийг тогтооход хүндрэл учруулж байгаа бөгөөд

цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог дүгнэхэд уялдаа хол буюу тус тусын сургалтын байгууллага тус тусдаа сургалтаа зохион байгуулж байна.

Анхан шатны буюу ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалт, тэдний элсүүлэх, сургах үйл ажиллагаа нь мэргэжил сургалтын чиглэлээр буюу богино хугацаанд өнгөц мэдлэг, ур чадварыг олгож байгаа бол бакалаврын түвшний сургалт нь хэд хэдэн мэргэшүүлэх хөтөлбөртэй ч жил бүр авч байгаа төгсөгчдийг мөшгөх судалгааны үр дүнгээр төгсөгчдийн чанар сул байгаа нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэж буй сургалтын байгууллага болон захиалагч байгууллагын уялдаа холбоо муу ажиллаж байгааг илтгэж байна.

Ахисан түвшний сургалт буюу магистр, докторын сургалтад хамрагдах боломж алба хаагчдад тэгш бус байдаг бөгөөд дарга, удирдлагын арга барил, алба хаагчдыг дэмжих бодлоготой холбоотой байна. Энэ нь тухайн алба хаагч өөрийгөө хөгжүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх чухал алхам хэдий ч ажлын ачаалал, бусад хувийн шинжтэй нөхцөл байдлуудаас шалтгаалан тэр бүр хамрагдаж чаддаггүй. Ингэснээр алба хаагч бүр тэгш боломжоор хангагдахгүй байгаа юм.

ХОЁР. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР СУДАЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн бүх төрлийн харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг бөгөөд энэ нь хөгжлийнхөө явцад хүмүүсийн ухамсар, хүсэл зоригийн дагуу бий болж, хамгаалагдаж, хангагдаж байдаг зан үйлийн горимын тогтолцоо болжээ.

Өөрөөр хэлбэл, нийгмийн хэм хэмжээ, түүнийг хэрэгжүүлэхэд функциональ үзэл санаа голлох бөгөөд Эмиль Дюркгеймийн бүтээлүүд нь нийгмийн дэг журмыг хэрхэн хэрэгжүүлэх, нийгэм хэрхэн тогтвортой байдгийг судалж байсан ба өдөр тутмын амьдралын микро түвшнээс илүүтэй нийгмийн бүтцийн макро түвшинд төвлөрдөг³ нь цагдаагийн байгууллагын чиг үүргийг тайлбарлахад хамааралтай юм.

Эндээс үзвэл, нийгмийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх чухал үүргийг аль ч улс оронд цагдаагийн байгууллага гүйцэтгэсээр ирсэн бөгөөд нийгэм, эдийн засаг, төрийн дэглэмийн онцлогоос хамаарч цагдааг тайлбарлах төрөл бүрийн онолын хандлагууд төлөвшин хөгжиж байна.

Хууль дээдлэх үзэл санаа, нийгмийн гэрээнээс төр үүссэн, улмаар төр нь хүний эрх, эрх чөлөөг зөрчих ёсгүй гэсэн жам ёсны эрх зүйн сургаал дээр үндэслэсэн гэдэг нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн. Философи талаас нь авч үзвэл, эртний Грекийн Аристотель, Платон, Цицерон, Локк, Монтескье, Кант зэрэг сэтгэгчид хууль дээдлэх ёсны үзэл санааг дэвшүүлж, хөгжүүлэх тодорхой алхмуудыг хийжээ. Харин хууль, эрх зүйн хувьд биеллээ олсон нь 1215 онд Англи Улсад гарсан Магна Хартын 38, 39 дүгээр зүйлүүдэд хууль дээдлэх ёсыг эрх зүйн байх ёстой зарчмуудын нэг гэж тодорхойлсон⁴ нь орчин үед ч байр сууриа хадгалсаар байна.

Хууль зүйн шинжлэх ухаан бол эрх зүйн мэдлэг гэдэг өвөрмөц бүтээгдэхүүн гаргадаг оюуны үйлдвэрлэлийн лаборатори⁵ гэж эрдэмтэд тайлбарласан бөгөөд хууль сахиулагч⁶ гэх нэршил нь хууль ёсыг мөрдүүлэгч гэсэн утгаар Монгол хэлний тайлбарт тусгагдсан. Бидний судалгааны ажилд цагдаагийн алба хаагчийг нэгэн төрлийн хууль сахиулагч гэх утгаар оруулж авч үзэх нь зүйтэй байна.

³ Durkheim, E. 1933. *Division of Labor in Society*. Glencoe, IL: Free Press.

⁴ Эрдэнэбаатар, Д. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны системчлэл. –Уб., 2017. 34 дэх тал.

⁵ Сэнгэдорж, Т. Хууль зүйн шинжлэх ухаан судалгааны арга зүй. –Уб., 2011. 8 дахь тал.

⁶ Монгол хэлний их тайлбар толь.- Уб., 2018.

2.1. Доктор, магистр, бакалаврын түвшинд судлагдсан байдал, дэвшүүлсэн асуудал, хэрэгжилт

Тээврийн цагдаагийн байгууллагын нийгэмд оршин байдаг зорилго, үүргийн талаар авч үзэхийн тулд хууль дээдлэх ёсыг авч үзэх хэрэгтэй болж байна⁷. Өөрөөр хэлбэл, төрийг төлөөлөх, хуулийг дээдлэх ёсны үүднээс нийгмийн хэм хэмжээг сахиулах, шаардах, албадах хөшүүрэг нь цагдаагийн байгууллага юм.

Үүнээс үзвэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал нь өргөн цар хүрээтэй судлагдахуун бөгөөд магистр, доктор, бакалаврын түвшинд олон чиглэлээр судлагдсан нь ажиглагдаж байна. Манай орны эрдэмтэн, судлаачид гадаад болон дотоодод энэ чиглэлээр чамгүй судалгаа хийж, бүтээл туурвижээ. Тухайлбал,

Докторын судалгааны түвшинд судлагдсан байдал, түүгээр дэвшүүлсэн асуудал, хэрэгжилт:

Хүснэгт 3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хамгаалсан докторын судалгааны ажлууд

№	Овог, нэр	Хамгаалсан зэргийн сэдэв	Сургууль	Чиглэл
Докторын судалгааны ажил				
1.	Гомбоцэдэн Ринчиндорж	“Ачааны автомашины тормозны системийн ажиллагаанд хийсэн судалгаа”	Москва 1981 он	Техникийн ухааны доктор (Ph.D)
2.	Шарав Бямбаа	“Спектр судалгааны аргаар цэргийн автомашины нөөц явалтыг тодотгож, тохируулах аргачлал боловсруулах”	ЦАТТА-д Ленинград 1986 он	Техникийн ухааны доктор (Ph.D)
		“Цэргийн автомашины найдварт ажиллагааны шинжлэх ухааны үндэс”	ЦАТТА-д Санкт-Петербург 1995 он	Шинжлэх ухааны доктор/Sc.D/
3.	Тазнаа Занашир	“Зам тээврийн ослын хар цэгийн судалгаа”	Эрхүүгийн ТИС Иркутск 2000 он	Техникийн ухааны доктор (Ph.D)
4.	Хяраадай Доржпалам	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал.	Улаанбаатар 2000 он	Хууль зүйн доктор (Ph.D)
5.	Чимэдцэрэн Жаргалсайхан	“Жолоодлогын тусгай талбай ашиглан жолооч бэлтгэх үйл ажиллагааг эрчимжүүлэх”	ШУТИС Улаанбаатар хот 2002 он	Техникийн ухааны доктор (Ph.D)
6.	Доржсүрэн Нямдорж	“Монголд Улсад хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн зөрчил, тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологийн шинж”	Москва 2009 он	Хууль зүйн доктор (Ph.D)
7.	Нямжав Ганбат	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зарим хүчин зүйлийн судалгаа”	ШУТИС Улаанбаатар 2018 он	Техникийн ухааны доктор (Ph.D)
8.	Магсар	“Зохицуулдаггүй явган хүний гарц дээр явган	ШУТИС	Техникийн ухааны

⁷ L.Green and other, Police innovation and police control., p.145.

Ариунболд	хүний аюулгүй байдлыг дээшлүүлэх”	Улаанбаатар 2021 он	доктор (Ph.D)
-----------	-----------------------------------	------------------------	---------------

Үүнээс үзвэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр манай орны судлаачид 1980-аад оноос ЗХУ, ОХУ-д эрдмийн зэрэг хамгаалж эхэлсэн байх ба 2000-аад оноос өөрийн орондоо эрдмийн зэрэг хамгаалж эхэлжээ. Энэ чиглэлээр хамгаалсан эрдмийн зэргийн 80% нь техникийн ухааны, 20% нь хууль зүйн ухааны мэргэшлээр бичигджээ.

Докторын судалгааны ажлын 50% нь автомашин, техникийн ашиглалт, түүнийг боловсронгуй болгох агуулгатай байгаа бол үлдсэн хэсэг нь аюулгүй байдлыг хангах асуудлыг ерөнхий байдлаар авч үзжээ.

Судалгааны ажлын үр дүнг хэрэгжүүлэлт харьцангуй сул байгаа нь ажиглалт, санал асуулгын дүнгээр илэрч байна. Учир нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь дан ганц судлаач, байгууллагын үйл ажиллагаа бус олон төрлийн салбарын хамтын ажиллагааг шаарддаг онцлогтой билээ.

Иймд энэ төрлийн докторын судалгааны ажил эрхэлж буй судалгааны байгууллага, төсөл, судалгаа, хувь судлаачдыг дэмжих урамшуулах, хамтын ажиллагааг хангах асуудлыг бодлогын түвшинд авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хүснэгт 4. Дотоод хэргийн их сургуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хамгаалсан магистрын ажлын жагсаалт

Магистрын судалгааны ажил		
2002 он		
1	Ц.Лувсан-Очир	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын зөрчилд хүлээлгэх захиргааны хариуцлага
2004 он		
2	Ц.Цэрэнбат	Монгол Улсад Авто тээврийн хэрэгслийг бүртгэх ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
2006 он		
3	Б.Батжаргал	Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн захиргааны зөрчил, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх зарим арга зам
2007 он		
4	Ц.Ариунболд	Замын цагдаагийн байгууллагын ажилтны ёс зүйн төлөвшилтийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа дүгнэлт түүнийг дээшлүүлэх боломж арга зам
2008 он		
5	Т.Баттөмөр	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд тавих захиргааны хяналт
6	Д.Батсайхан	Замын цагдаагийн албаны зохицуулагч цагдаагийн эрх зүйн байдлын зарим асуудлууд
2009 он		
7	Т.Төгсмаа	Тээврийн хэрэгслийн Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл
2010 он		
8	П.Борхүү	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг нотлох ажиллагаа
2011 он		
9	Б.Сүхбат	Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчлийн шийдвэрлэлтэнд хийсэн дүн шинжилгээ
2012 он		

10	Б.Батдэлгэр	Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх зугтаах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй криминологийн асуудал
11	Ц.Эрдэнэчимэг	Явган зорчигчийн зам тээврийн осолд өртөж буй шалтгаан нөхцөл урьдчилан сэргийлэх асуудал
2014 он		
12	Э.Батмөнх	Авто тээврийн хэрэгслийг авч зугтаах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй криминологийн тодорхойлолт
13	Ц.Гэрэлмаа	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
2015 он		
14	Ч.Батболд	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад техник хэрэгслийг ашиглах нь
15	Л.Эрдэнэбулган	Замын цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
16	Ж.Тамир	Автомашин зарим төрлийн эд ангийн мэдээллийн сан бүрдүүлж ашиглах онол арга зүйн асуудал
17	П.Ганхуяг	Зам тээврийн хэрэг ослын гаралтыг бууруулах ажлын удирдлага зохион байгуулалт
2016 он		
18	Б.Баттүвшин	Бүрэн бус тээврийн хэрэгслийг ажилд гаргах жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгчэл жолоодуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал
19	Г.Ган-Эрдэнэ	Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх онол практикийн зарим асуудал
20	А.Баярболд	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн газарт зарим төрлийн мөртэй ажиллах арга зүйг боловсронгуй болгох нь
21	В.Хундгаа	Авто замын хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагааны удирдлагыг боловсронгуй болгох зарим асуудал
2017 он		
22	Б.Батбаяр	Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал
23	Д.Гомбосүрэнжав	Тууш замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал
24	Ц.Чинзориг	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний актад хийсэн дүн шинжилгээ
25	Б.Эрдэнэхуяг	Замын нөхцөл байдал зам тээврийн осолд нөлөөлөх хүчин зүйл болох нь
26	Б.Энхболд	Монгол улс дахь жолооч бэлтгэх сургалтын эрх зүйн зохицуулалт түүнийг боловсронгуй болгох зарим асуудал
2018 он		
27	Б.Бадамсайхан	Тээврийн хэрэгслийн мөр судлалын шинжилгээнд тулгамдаж буй асуудал шийдвэрлэх арга зам
28	Г.Цэндсүрэн	Автомашин бүрэн бус байдал зам тээврийн осолд нөлөөлснийг авто техникийн шинжилгээгээр тогтоох онол арга зүйн асуудал
29	Н.Балжинням	Замын цагдаагийн алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын өнөөгийн байдал түүнд хийх шинжилгээ
30	Д.Энхтайван	Замын цагдаагийн алба хаагчийн сахилга ёс суртахууны асуудал
2019 он		
31	Б.Алтандөш	Бага насны хүүхэд замын хөдөлгөөнд оролцож буй өнөөгийн байдал тулгамдсан асуудал
32	Д.Түмэнбаяр	Замын хөдөлгөөнд мотоциклтой оролцогчдод тавих хяналтыг сайжруулах нь
33	Н.Цогтбаатар	Зам тээврийн осол зөрчлийг бууруулахад тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх асуудал
2020 он		

34	Э.Бямбажаргал	Замын цагдаагийн алба хаагчдын ажлаас хамаарах хам шинж: шалтгаан хүчин зүйл
35	Л.Батбуян	Цагдаагийн байгууллагын зам тээврийн ослын газраас зугтаах зөрчлийг шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал
36	Б.Зоригт	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоог сайжруулах асуудал
37	Д.Мөнгөн	Жолоочоос шалтгаалсан зам тээврийн осол, хэргийг бууруулах арга зам
38	Б.Оюунбаатар	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийн эрх зүйн зохицуулалт
39	Ч.Цогтбаяр	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцоо
2021 он		
40	М.Гарьд	Тээврийн цагдаагийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлтэд тулгамдаж буй асуудал, сайжруулах арга зам
41	Т.Анхбаяр	Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэж буй сургалтын шинжилгээ
2022 он		
42	Г.Ариунгэрэл	Орон нутгийн автозамд үйлдэгдэж буй зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам “Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын улсын чанартай автозамын жишээн дээр”
43	Д.Бат-Эрдэнэ	Замын цагдаагийн алба хаагчийн сахилга хариуцлага
44	Х.Мөнх-Эрдэнэ	Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэдээллийн технологийг ашиглах нь
45	Б.Зоригтбаатар	Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам “Гашуун сухайтын хилийн боомт жишээн дээр”

Дээрх бүтээлүүд нь судлаачдын байр сууринаас цаг хугацаанаас хамааруулан тухайн ажилладаг байсан салбартаа болон нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг хөндөж, дүгнэн гарах шийдэл арга замуудыг тодорхойлж байснаараа өөр хоорондоо ялгагдаж байжээ.

Магистрын зэрэг хамгаалсан судалгааны ажлуудын сэдвийн агуулгаар нь адилтган үзвэл хамгийн их буюу нийт ажлын 48%-ийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын талаар, 16%-ийг гэмт хэрэг, ослын криминологи шинж, урьдчилан сэргийлэх асуудал, 12%-ийг хууль, эрх зүйн хариуцлагыг бэхжүүлэх, 10%-ийг алба хаагч болон жолоочийг бэлтгэх сургалт, 6%-ийг техник ашиглалт, аюулгүй байдлын чиглэлээр судлагдсан сэдвүүд эзэлж байна.

Үүнээс үзвэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр харьцангуй олон талт судалгаа, үр дүн гарсан байх боломжтой байна. Судалгааны ажлуудын сэдвүүд нь анхаарал татахуйц, асуудлын шийдлийг эрэлхийлсэн нь их байх боловч магистрын судалгааны ажлын чанар сул, хэрэгжилт тааруу байдаг нь бодит үр дүн юм.

Хүснэгт 5. Бусад их, дээд сургуульд хамгаалагдсан магистрын судалгааны ажлуудын жагсаалт

№	Их дээд сургуулийн нэр	Нэр	Судалгааны ажлын чиглэл	Шинжлэх ухааны чиглэл	Он
ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ					
1	Их засаг Олон улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль	Цэрэндорж Улаанхүү	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн нотлох ажиллагаа	Хууль зүйн магистр	2019
2	Их засаг Олон улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль	Энхболд Батбилэг	“Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг”-ийн хэргийн газрын	Хууль зүйн магистр	2019

			үзлэг хийх онол арга зүйн асуудал		
3	Их засаг Олон улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль	Ёндонжамц Эрдэнэцэцэг	Тээврийн хэрэгслийн даатгалын эрсдэлийн үнэлгээ	Хууль зүйн магистр	2019
4	Их засаг Олон улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль	Э.Догмидцэрэн	Тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас учирсан гэмт хорын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал	Хууль зүйн магистр	2019
5	Их засаг Олон улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль	Дүгэрсэд Цэцэгсүрэн	Согтуугаар авто тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим асуудал	Хууль зүйн магистр	2018
6	Их засаг Олон улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль	Санжаасүрэн Нямсүрэн	Авто зогсоолын хүртээмжийн боломжийн судалгаа	Хууль зүйн магистр	2022
ОРХОН ИХ СУРГУУЛЬ					
7	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Сэндэгмаагийн Самьяа	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэмт хор түүний хууль зүйн үр дагавар	Хууль эрх зүйн магистр	2011
8	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Гомбын Амарсанаа	“Замын хөдөлгөөний аюулгүй байдалд тавих захиргааны хяналтын асуудал”	Хууль эрх зүйн магистр	2013
9	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Жигжидсүрэнгийн Баярсайхан	Хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчлийн шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ	Хууль эрх зүйн магистр	2013
10	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Батцагааны Очирбат	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нотолгооны асуудал, эрх зүйн зохицуулалт	Хууль эрх зүйн магистр	2013
11	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Даваасүрэн Мянгантуул	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд тавих захиргааны хяналтын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Хууль эрх зүйн магистр	2013
12	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Лхагвасүрэн Энхбаяр	Тээврийн хэрэгслийн мөрд хийх криминалистикийн онош зүйн шинжилгээ	Хууль эрх зүйн магистр	2014
13	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Баасанжавын Банзрагч	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн зарим асуудал	Хууль эрх зүйн магистр	2014
14	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Ядамсүрэнгийн Энхжаргал	“Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн эрх зүй, криминологийн зарим асуудал”	Хууль эрх зүйн магистр	2014

15	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Бат-Очирын Энхсанаа	“Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын асуудал”	Хууль эрх зүйн магистр	2016
16	Орхон их сургуулийн Хууль зүйн салбар сургууль	Үүрцайхын Оюун-Эрдэнэ	“Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын зөрчил, урьдчилан сэргийлэх зарим асуудал”	Хууль эрх зүйн магистр	2017
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХ ИХ СУРГУУЛЬ					
17	Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургууль	Б.Эрдэнэбат	Монголын агаарын тээврийн сүлжээнд Батлан хамгаалах ашиг сонирхолд хоёрдмол давхар үүрэгтэй авиацийн хэрэгслийг хэрэглэх техник- эдийн засгийн үнэлгээ.	Техник	2001
18	Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургууль	Б.Баяржаргал	Гамшиг, ослын аюулыг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга технологи, тогтолцоог боловсронгуй болгох нь	Цэргийн зэвсэглэл техник	2002
19	Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургууль	Ч.Жаргалсайхан	Жолоодлогыг тусгай талбай ашиглан жолооч бэлтгэх үндсэн үзүүлэлтүүдийг саадуудын онцлогоос хамааруулан онол, туршилтын судалгаа	Техник	2002
20	Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургууль	Л.Батсайхан	Цэргийн техникийн хөдөлгүүрийн тосны чанарыг тодорхойлох аргыг боловсронгуй болгох	Цэргийн зэвсэглэл, техник	2016
21	Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургууль	М.Ванчигмаа	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь иргэний нэхэмжлэл	Хууль зүйн ухаан	20220
22	Монгол Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургууль	Ганбаатар Амарбаясгалан	Замын хөдөлгөөний аюулгүй байдлаас бага насны хүүхдийг урьдчилан сэргийлэх арга замын судалгаа	Авто инженер хөтөлбөрөөр төгсөгч	2022
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ					
23	МУИС Эдийн засгийн сургууль	Б.Дөлгөөн	Нийтийн тээврийн үйлчилгээний зардлын бүртгэл, бүтээгдэхүүний өртөг	Нягтлан бодох бүртгэл	2011
24	МУИС математик компьютерын сургууль	Б.Болор	Жолоочийн хариуцлагын даатгалын систем	Мэдээллийн систем	2014
25	МУИС Олон улсын харилцаа нийтийн удирдлагын сургууль	С.Гаадамба	Зам тээврийн осол ба хүний амьд явах эрх	Олон улсын эрх зүй	2014
26	МУИС бизнесийн сургууль	Э.Баатархуяг	Жолоочийн хариуцлагын даатгалын үйлчилгээний чанарыг сайжруулах арга зам /Даатгалын шуурхай албаны жишээн дээр/	Бизнесийн удирдлага	2017
27	МУИС хууль зүйн	С.Батгэрэл	Зорчих эрхийг хязгаарлах ялын	Хууль зүй	2021

	сургууль		эрх зүйн зохицуулалт		
28	МУИС хууль зүйн дээд сургууль	Х.Доржпалам	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгтэй, тэмцэх эрүүгийн эрх зүйн криминологийн асуудал	Хууль зүй	2000
ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ					
29	Төмөр замын дээд сургууль	С.Анужин	Хот хоорондын нийтийн тээврийн төлөвлөлт зохион байгуулалт	Авто аж ахуй	2017
30	Төмөр замын дээд сургууль	Б.Гэрэлмаа	Хотын нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн нэвтрүүлэх үйлчилгээний үр ашгийг тооцох	Авто аж ахуй	2017
31	Төмөр замын дээд сургууль	Б.Ирээдүй	Гадна талбайн авто зогсоолын төлөвлөлт зохион байгуулалт	Авто аж ахуй	2017
32	Төмөр замын дээд сургууль	Г.Нандин-Эрдэнэ	Жолоочийн ажил амралтын дэглэмийг зохицуулах	Авто аж ахуй	2017
33	Төмөр замын дээд сургууль	Д.Отгонбаяр	Үндэсний болон олон улсын тээвэр логистикийн сүлжээг хөгжүүлэх	Авто аж ахуй	
34	Төмөр замын дээд сургууль	А.Сүхбаатар	Унадаг дугуй замын төлөвлөлт зохион байгуулалт	Авто аж ахуй	2017
35	Төмөр замын дээд сургууль	Б.Цогбадрах	Хотын хөдөлгөөн зохион байгуулалтын шийдэл	Авто аж ахуй	2017
36	Төмөр замын дээд сургууль	А.Чанцалням	Сургуулийн ойр орчмын хөдөлгөөний аюулгүй байдал, зохион байгуулалт	Авто аж ахуй	2017
37	Төмөр замын дээд сургууль	А.Гансүх	Улс хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах	Авто аж ахуй	2017
38	Төмөр замын дээд сургууль	Н.Азаяа	Нийслэлийн авто зогсоолын менежментийг боловсронгуй болгох	Авто аж ахуй	2018
39	Төмөр замын дээд сургууль	Э.Жаргалмаа	Төмөр замын гарамтай хэсэгт автомашин болон гарт тэрэгний хөдөлгөөний огтлолцуулан уялдуулах	Авто аж ахуй	2018
40	Төмөр замын дээд сургууль	Б.Отгонжаргал	Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний УБ-Архангай чиглэлийн төлөвлөлтийг сайжруулах	Авто аж ахуй	2018
41	Төмөр замын дээд сургууль	Л.Соднаран	Явган хүний хөдөлгөөний аюулгүй байдал	Авто аж ахуй	2018
42	Төмөр замын дээд сургууль	Ч.Цэндсүрэн	Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний УБ-Орхон чиглэлийн төлөвлөлтийг сайжруулах	Авто аж ахуй	2018
43	Төмөр замын дээд сургууль	Г.Цэрэндолгор	Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний УБ-	Авто аж ахуй	2018

			Баянхонгор чиглэлийн төлөвлөлтийг сайжруулах		
44	Төмөр замын дээд сургууль	А.Эрдэнэтуяа	Зам тээврийн хөдөлгөөний оновчтой зохион байгуулахад шинэ техник, технологийг нэвтрүүлэх	Авто аж ахуй	2018
45	Төмөр замын дээд сургууль	Ц.Лхагвасүрэн	Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах.	Авто аж ахуй	2018
46	Төмөр замын дээд сургууль	Б.Санчир	Москва хорооллын замын хөдөлгөөнийг шинээр өөр түвшний зам байгуулснаар түгжрэлийг бууруулах	Авто аж ахуй	2018
47	Төмөр замын дээд сургууль	А.Баянмандах	Төмөр замын гармын дохиог тээврийн хэрэгсэл зорчих уулзварын гэрлэн дохиотой уялдуулан хөдөлгөөнийг зохион байгуулах	Авто аж ахуй	2018
48	Төмөр замын дээд сургууль	О.Лхагвацэцэг	Сургууль орчмын бүсийн хөдөлгөөн зохион байгуулалтын сайжруулах	Авто аж ахуй	2018
49	Төмөр замын дээд сургууль	О.Номин	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан хүүхэд, унадаг дугуйгаар зорчигчдын замын хөдөлгөөнд оролцох аюулгүй байдлыг хангах шийдлүүдийг авто замын хийц төлөвлөлтөд тусгах	Авто аж ахуй	2018
50	Төмөр замын дээд сургууль	Н.Ану-Ужин	Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний УБ-Хэнтий чиглэлийн төлөвлөлтийг сайжруулах	Авто аж ахуй	
Механик, тээврийн сургууль					
51	Механик тээврийн сургууль	Б.Батдаваа, Т.Амармэнд, Н.Нямрагчаа	Жолоочийн самбаачлах хугацаанд бүхээгийн бичил орчны үзүүлэлт хамаарал	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
52	Механик тээврийн сургууль	Болд Доржсүрэн	Авто замын түгжрэлийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
53	Механик тээврийн сургууль	Үүрийнцолмон Наранжаргал	Авто замын дагуух тээврийн үйлчилгээний төв, түр зогсоолын сүлжээг хөгжүүлэх	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
54	Механик тээврийн сургууль	Талстболорын Цогтбаяр, Норинпилийн Отгондалай	ШУТИС-ийн уулзварт байгуулах явган зорчигчийн гарам	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
55	Механик тээврийн сургууль	Цогтбаяр Ганболд	Автомашин мөргөлдөх үед үүсэх хүчдэл, хэв гажилтын симуляци	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
56	Механик тээврийн сургууль	Энхтайван Мягмарбат	Улаанбаатар Дарханы автозамыг өргөтгөн шинэчлэх	Автомашин ашиглалт,	2017

			үндэслэл ач холбогдол	авто аж ахуй	
57	Механик тээврийн сургууль	Мурат Ардабек	Улаанбаатар хотын явган хүний гарц, гармын аюулгүй байдалд хийсэн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
58	Механик тээврийн сургууль	Ганхуяг Ууганбаатар	Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн гэрлийн тусгалыг өөрчлөх боломжтой судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
59	Механик тээврийн сургууль	Батхүрэл Батзаяа	Явган зорчигчийн зохицуулдаггүй гарц дээрх аюулгүй байдлыг дээшлүүлэх судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
60	Механик тээврийн сургууль	Д.Жавхланбаяр	Уулзвар хөдөлгөөн зохион байгуулах	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
61	Механик тээврийн сургууль	Б.Билэгт	Мотоциклийн худалдаа, засвар үйлчилгээний төвийн төсөл	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
62	Механик тээврийн сургууль	Б.Майдар	Жолоочийн замын хөдөлгөөнд соёлд хийсэн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
63	Механик тээврийн сургууль	И.Батболд	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын АУДИТ	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
64	Механик тээврийн сургууль	Л.Баасандорж	Автомашин жолооны систем, түүний хөгжлийн чиг хандлагын судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
65	Механик тээврийн сургууль	Пүрэвжав Батхүү	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд тээврийн хэрэгслийн техникийн байдлын нөлөөллийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2019
66	Механик тээврийн сургууль	Нямдаваа Бямбадорж	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох нь	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2019
67	Механик тээврийн сургууль	Батбаяр Баттүшиг	Жолоочийн ажил, амралтын горимыг зохицуулахад электрон Тахограф хэрэглэх	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2019
68	Механик тээврийн сургууль	Түвшинжаргал Одонхүү	Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож буй авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний горимын судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2019
69	Механик тээврийн сургууль	Эрдэнэжаргал Пүрэвжаргал	Зохицуулдаг явган зорчигчийн гарц дээрх явган зорчигчийн аюулгүй байдлын судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2019
70	Механик тээврийн сургууль	Г.Бямбадорж	Явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдлын хангах боломжийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2010
71	Механик тээврийн сургууль	Ч.Батбаяр	Улаанбаатар Багануур чиглэлийн замд гарч байгаа ослын шалтгааныг замаас	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2012

			хамааруулан судлал нь		
72	Механик тээврийн сургууль	О.Эрхэмболор	Замын хөдөлгөөний аюулгүй байдал гэрэлтүүлгийн системийн нөлөөллийн зарим асуудал	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2011
73	Механик тээврийн сургууль	Э.Даариймаа	Улаанбаатар хотод унадаг дугуй ашиглах боломжийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2011
74	Механик тээврийн сургууль	Ц.Алтан-Эрдэнэ	Арвайхээр хотын замын хөдөлгөөний аюулгүй байдал, осол хэргийг бууруулах менежмент	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2014
75	Механик тээврийн сургууль	Д.Олонбаяр	Баянзүрх дүүргээс Налайх дүүрэг хүртэлх авто замд гарсан зам тээврийн ослын судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2014
76	Механик тээврийн сургууль	Б.Ганзориг	Улаанбаатарт ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгслүүдийн статистик үзүүлэлтүүдийг тодорхойлох аргачлал боловсруулах	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2015
77	Механик тээврийн сургууль	Ч.Гансүлд	Явган зорчигчийн хөдөлгөөний нэвтрүүлэх чадварын хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2015
78	Механик тээврийн сургууль	Г.Золбоо	Явган зорчигчийн хөдөлгөөнөөс үүсэлтэй тээврийн хэрэгслийн хүлээлгийн хугацааг судалсан дүн	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2015
79	Механик тээврийн сургууль	Ч.Болдбаатар	Жолоочийн үзэгдэх орчныг тодорхойлсон судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2015
80	Механик тээврийн сургууль	Х.Аюуш	Улаанбаатар-Дарханы чиглэлийн хатуу хучилттай замын хөдөлгөөний аюулгүй байдлыг үнэлгээ	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2016
81	Механик тээврийн сургууль	Г.Батхуяг	Булган аймгийн хатуу хучилттай замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2017
82	Механик тээврийн сургууль	М.Мөнх-Эрдэнэ	Улаанбаатар хотын зарим уулзвар дээрх бөглөрлийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
83	Механик тээврийн сургууль	Г.Жаргал	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын оролцоо	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
84	Механик тээврийн сургууль	П.Пунсалдулам	Жолоочийн самбаачлах хугацаанд согтуурлын түвшний үзүүлэх нөлөөг тогтоох судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
85	Механик тээврийн	Б.Бат-Очир	Замын хөдөлгөөний зохион	Автомашин	2018

	сургууль		байгуулахад тулгарч буй асуудлууд	ашиглалт, авто аж ахуй	
86	Механик тээврийн сургууль	Э.Энх-Амар	Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн осол хэргийн шалтгаан нөхцөлийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
87	Механик тээврийн сургууль	У.Дэлгэрхишиг	Ерөнхий боловсролын сургууль орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэх	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
88	Механик тээврийн сургууль	Н.Болдбаатар	Улаанбаатар хотын гудамж замын сүлжээн дэх зохицуулгатай уулзварын хөдөлгөөн зохион байгуулалт	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
89	Механик тээврийн сургууль	Н.Намуу	Авто машины хар хайрцгийг зам тээврийн осол хэргийн шалтгааныг тогтооход ашиглах боломжийн судалгаа	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018
90	Механик тээврийн сургууль	Д.Мөнгөн	Байршил зүйн аргаар зам тээврийн осол хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох	Автомашин ашиглалт, авто аж ахуй	2018

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой сэдвээр магистрын судалгааны ажил хамгаалсан байдлыг бид Монгол Улсын их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Орхон их сургууль, Үндэсний батлан хамгаалах их сургууль, Төмөр замын дээд сургууль, Механик тээврийн сургуулиудын нийт 90 судалгааны сэдвийн хүрээнд авч үзлээ.

Үүнээс үзвэл, сургууль тус бүр сэдвийн чиглэл харилцан адилгүй бөгөөд мэргэжлийн чиглэлээс шалтгаалсан сэдвүүд зонхилж байна. Тухайлбал, Их засаг олон улсын их сургуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаасаа гэмт хэрэг, зөрчлийг нотлох ажиллагаа, урьдчилан сэргийлэх асуудал, эрх зүйн зохицуулалтыг түлхүү судалсан бол Орхон их сургуульд нийт хамгаалсан магистрын ажлын 90 орчим хувь нь эрх зүйн зохицуулалтын асуудал байна. Монгол Улсын их сургуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын сэдвүүдэд хувийн эрх зүйн салбарын асуудал буюу даатгал, татвар, зардлыг тооцох мөн хүний эрхийг хангах зэрэг агуулгуудыг түлхүү авч үзжээ. Харин Үндэсний батлан хамгаалах их сургууль, Төмөр замын дээд сургууль, Механик тээврийн сургуульд техник ашиглалтын аюулгүй байдал, тээвэр ложистик, төлөвлөлт менежмент, үйлчилгээний асуудлыг түлхүү авч үзжээ.

Бакалаврын түвшинд хууль зүй, техник, боловсролын болон бусад чиглэлээр судлагдсан байдал, түүгээр дэвшүүлсэн асуудал, хэрэгжилт

Судалгааны явцад хамгийн чухал хэсэг бол судаалчдын зүгээс бакалаврын зэргийн түвшний сургалтад нэлээд анхаарал хандуулах ёстойг цохон тэмдэглэж байсан.

Хүснэгт 6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр бакалаврын түвшинд судалсан сэдвийн жагсаалт

Бакалаврын дипломын ажил		
2022 он		
д/д	Овог нэр	Сэдэв
1	Аскерхан Асилбек	Замын хөдөлгөөний түгжрэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлд хийсэн судалгаа

2	Дүгэрсүрэн Балдандорж	Улаанбаатар хотын гэрлэн дохио замын тэмдэглэл хоорондын уялдаа холбогдолд хийсэн судалгаа
3	Нямбат Билгүүн	Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, түүнд хяналт тавих арга зүй, өнөөгийн нөхцөл байдал
4	Эрдэнэсүрэн Булгантамир	Тээврийн хэрэгслийн жолооч нар явган хүний гарц нэвтрэхэд гаргадаг зөрчил, түүнд тавих цагдаагийн хяналт
5	Баяраа Бямбадорж	Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэж буй эрх зүй зохицуулалт, өнөөгийн байдал
6	Бат-Эрдэнэ Гэрэлт- Од	10 хүртэлх насны хүүхэд, замын хөдөлгөөнд оролцож байгаа байдал, зам тээврийн ослоос урьдчилсан сэргийлэх арга, эрх зүйн зохицуулалт
7	Авирмэд Давааням	Уулзвар нэвтрүүлэх чадвар, замын хөдөлгөөний эрчмийн байдалд хийх судалгаа
8	Мөнхжаргал Дэлгэрбаяр	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хуулийн этгээдийн үүрэг, хариуцлага, өнөөгийн байдал”
9	Батжаргал Ёндонтүвшин	Улаанбаатар хотын замын тэмдэг, тэмдэглэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа
10	Намсрай Мөнхзолбоо	Зам тээврийн осолд өртсөн хүнд үзүүлэх анхан шатны тусламжийн талаар жолооч нарын мэдлэг, тусламж үзүүлсэн байдал
11	Гэрэлт-Од Марал-Эрдэнэ	Уулзварын хийц, загвар замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх нь
12	Бат-Эрдэнэ Отгонбат	Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл болох тэмдгийн гэрэл ойлгох чадвар нь стандартын шаардлага хангаж байгааг шалгах багаж хийх судалгаа
13	Ганхуяг Одбаяр	Тусгай дуут болон гэрлэн дохиог хэрэглэж байгаа байдал, түүнд тавигдах хяналт зөвшөөрлийн тогтолцоо
14	Мөнхтөр Оюунбат	Хөдөлгөөн эхлэх ба чиг өөрчлөх үйлдэл, замын тэмдэг тэмдэглэлийн уялдаа холбоо, цагдаагийн байгууллагын хяналт
15	Бямбацэрэн Сайнзаяа	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, түүнд хяналт тавих арга зам
16	Батсайхан Төмөрбат	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гар утас ашиглалтын байдал, түүнд тавих цагдаагийн хяналт
17	Баттулга Түмэнжаргал	Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн ашиглалтын байдалд хийсэн судалгаа
18	Эрдэнэчулуун Эрдэнэтогтох	/Баянзүрх дүүрэг болон Зуун мод сумын жишээн дээр/
19	Эрдэнэсүрэн Энхдөл	Замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарын хажуугийн болон хоорондын зайг барихад гаргадаг зөрчлийн, шалтгаан нөхцөл

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Замын цагдаагийн тэнхимийн дэргэд Тээврийн цагдаагийн албаны мэргэжилтэн бэлтгэх ажил Монгол улсын төрөөс Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын хүрээнд 2013 оноос хоёрдугаар дамжааны суралцагсдаас сонгон шалгаруулан суралцуулж анхны мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх ажил нэлээд үр дүнтэй алхам болсон юм.

ДХИС дээр 2022 онд 1+1 хөтөлбөрийг төгсөгчдөөс “Цагдаагийн ажил-Эрх зүй-Замын хөдөлгөөний аюулгүй байдал” мэргэжлээр төгссөн 19 сонсогчдыг практик, дадлагын хугацаанд тодорхой судалгааны ажилд татан оролцуулж, төгсөлтийн дипломын ажлыг сэдэв сонголтоор бичүүлсэн.

Энэ хөтөлбөрөөр төгссөн алба хаагчдыг Тээврийн цагдаагийн албанд нь томилуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах асуудлыг эргэж харах шаардлагатай юм.

Учир нь үндсэн хөтөлбөрийг боловсруулан тус албанд хүний нөөцийг хангаж эхлсэн хугацаа нь харьцангуй сүүлд эхэлсэн. Өнөөгийн байдлаар нийт алба хаагчдын дунд бусад албатай харьцуулахад харьцангуй бага хувийг эзэлж байгаа юм.

Дээр өгүүлснийг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Судалгааны хамрах хүрээний хугацаанд 1936-2022 оны хооронд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлаар тухайн салбартаа судалгаа, шинжилгээний ажил хийж Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Монгол орны төдийгүй, дэлхий нийтэд тулгамдаж байгаа түгжрэлийг багасгах чиглэлээр тодорхой судлах зүйлтэй, судалгааны арга зүйтэй болсон нь эерэг үзүүлэлт юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр манай орны судлаачид 1980-аад оноос ЗХУ, ОХУ-д эрдмийн зэрэг хамгаалж эхэлсэн байх ба 2000-аад оноос өөрийн орондоо эрдмийн зэрэг хамгаалж эхэлжээ. Энэ чиглэлээр хамгаалсан эрдмийн зэргийн 80% нь техникийн ухааны, 20% нь хууль зүйн ухааны мэргэшлээр бичигджээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь дан ганц судлаач, байгууллагын үйл ажиллагаа бус олон төрлийн салбарын хамтын ажиллагааг шаарддаг онцлогтой билээ.

Иймд энэ төрлийн докторын судалгааны ажил эрхэлж буй судалгааны байгууллага, төсөл, судалгаа, хувь судлаачдыг дэмжих урамшуулах, хамтын ажиллагааг хангах асуудлыг бодлогын түвшинд авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Уг судалгааны ажлын хүрээнд олон төрлийн ажил үүргийн нэгдлийн дүнд амжилт нь илрэн гардаг замын хөдөлгөөний оновчтой төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтад шийдэл, саналуудыг боловсруулан хэрэгжүүлэх асуудал юм.

Магистрын зэрэг хамгаалсан судалгааны ажлуудын сэдвийн агуулгаар нь адилтган үзвэл хамгийн их буюу нийт ажлын 48%-ийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын талаар, 16%-ийг гэмт хэрэг, ослын криминологи шинж, урьдчилан сэргийлэх асуудал, 12%-ийг хууль, эрх зүйн хариуцлагыг бэхжүүлэх, 10%-ийг алба хаагч болон жолоочийг бэлтгэх сургалт, 6%-ийг техник ашиглалт, аюулгүй байдлын чиглэлээр судлагдсан сэдвүүд эзэлж байна.

Үүнээс үзвэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр харьцангуй олон талт судалгаа, үр дүн гарсан байх боломжтой байна. Судалгааны ажлуудын сэдвүүд нь анхаарал татахуйц, асуудлын шийдлийг эрэлхийлсэн нь их байх боловч магистрын судалгааны ажлын чанар сул, хэрэгжилт тааруу байдаг нь бодит үр дүн юм.

Мөн судалгааны ажлын сэдэв, агуулга маш их давтагдаж байна. Энэ нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил, оюуны өмчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сул байгаа, нөгөөтээгүүр хуулбарлалтыг шалган тогтоох үйл ажиллагаа харьцангуй сүүлд нэвтэрч эхэлж буйтай холбоотой юм.

Бакалаврын түвшний судалгааны ажлуудын сэдвийг дахин нарийвчлан боловсруулах шаардлага бий болж байна. Учир нь сонгогдсон сэдвүүд өмнө нь судлагдсан хэт ерөнхий сэдвүүд байгаа нь учир дутагдалтай юм.

2.2.Цаашид судлах шаардлагатай хууль зүй, техник, боловсролын болон бусад чиглэлээр судалгааны сэдвийн томьёолол

Бидний амьдарч буй нийгэм бол техникийн хөгжлийн эрин үе бөгөөд дэлхий нийтийн шинжлэх ухаан ч үүнийг чиглүүлэн тодорхойлж байгаа билээ.

Монголын шинжлэх ухаан бас дэлхийн хөгжилд нэмэр хандив болох үүднээс техник, технологийн үр ашигтай санаа, бүтээлүүдийг судлан, авч ашиглан улмаар сайжруулахад оюун ухаанаа уралдуулах шаардлагатай.

Технологийн ололттой шийдлүүдийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл явцад өргөнөөр ашиглаж байгаагийн нэг нь хиймэл оюунаар замын хөдөлгөөнд хяналт тавьж, түүнийг зохицуулах үйл явц юм.

Монгол оронд энэ төрлийн шийдлүүдийг замын хөдөлгөөн зохицуулах, хяналт тавих үйл ажиллагаанд зайлшгүй ашиглах шаардлагатай болжээ.

Дээрх санаа шийдлүүдийг цаашид судлах шаардлагатай хууль зүй, техник, боловсролын болон бусад чиглэлээр магистрын судалгааны чиглэлд хандуулах хэрэгцээтэй байна.

Дараах байдлаар сэдвийн саналыг томьёолж байна. Үүнд:

1. Согтуугаар авто тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим асуудал олон улсын шийдэл;
2. Согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох үйлдэлд гадаадын зарим улсад хүлээлгэж буй хууль зүйн хариуцлага;
3. Улаанбаатар хотын авто зогсоолын хүртээмжийн судалгаа, эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ;
4. Хот хоорондын болон нийтийн тээврийн төлөвлөлт, зохион байгуулалтын удирдлагын эрх зүйн шинэчлэлт;
5. Улсын болон орон нутгийн чанартай авто замаар ачааны авто машинаар тээврийн үйл ажиллагаа явуулж буй жолоочийн ажил амралтын дэглэмийг зохицуулах нь;
6. Хот суурин газарт унадаг дугуй замын төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах, хэрэгцээ шаардлага;
7. Сургууль орчмын бүсийн хөдөлгөөний аюулгүй байдал, зохион байгуулалтын эрх зүйн орчны шинэчлэлт;
8. Явган зорчигчийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга зам;
9. Арав хүртэлх насны хүүхдийг зорчигч хэлбэрээр зам тээврийн осолд өртөж амь нас, эрүүл мэндээрэй хохирохоос урьдчилан сэргийлэх арга зам;
10. Арав хүртэлх насны хүүхдийг явган зорчигч хэлбэрээр зам тээврийн осолд өртөж амь нас, эрүүл мэнд хохирохоос урьдчилан сэргийлэх арга зам;
11. Улаанбаатар хотын замын түгжрэлийн шалтгаан, нөхцөл;
12. Улаанбаатар хотын явган хүний гарц, гармын аюулгүй байдалд хийсэн судалгаа;
13. Замын хөдөлгөөнд оролцогчийн соёл, сахилга батын байдалд хийсэн судалгаа;
14. Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулах;

15. Улсын болон орон нутгийн чанартай авто замын үзэгдэх орчин хязгаарлагдсан хэсгийн судалгааг гаргах замаар зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх арга зам. /аймгуудыг жишээ нь дээр хийж болно/;
16. Улсын болон орон нутгийн чанартай авто замын тэмдэг, тэмдэглэлийг сайжруулах замаар зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх арга зам;
17. Мотоциклыг хөдөлгөөний улмаас үүсэх зам тээврийн осол хэргийн бууруулах арга зам;
18. Орон нутгийн замд хурд хэтрүүлэх зөрчлийг бууруулах замаар зам тээврийн осол хэргийн бууруулах нь;
19. Улсын болон орон нутгийн чанартай авто замд мал, ан амьтан мөргөх зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх арга зам;
20. Тээврийн хэрэгслийн бүрэн, бүтэн байдалд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэх замаар зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх арга зам;
21. Замаас үүдэн гарах зам, тээврийн осол гэмт хэргийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ;
22. Замын хөдөлгөөн зохицуулах техник, хэрэгслийн байдалд хийсэн дүн шинжилгээ;
23. Зам тээврийн осол, хэргийн газарт үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эрх зүйн асуудал;
24. Замын хөдөлгөөнд ердийн хөсгөөр оролцох үеийн техник, эрх зүйн асуудал Швед улсын туршлагатай харьцуулсан судалгаа;
25. Замын хөдөлгөөнд унадаг дугуйгаар оролцогчийн эрх зүй байдал, түүнд хийсэн дүн шинжилгээ;
26. Нийтийн тээврийн үйлчилгээний хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт, зохицуулалт эрх зүйн зарим асуудал;
27. Замын хөдөлгөөнд оролцогчдод камераар хяналт тавих эрх зүйн зохицуулалт ба хүний эрх;
28. Замын хөдөлгөөнд ердийн хөсгөөр оролцогчийн боловсрол, сургалтын асуудал Норвеги улсын туршлагатай харьцуулсан судалгаа;
29. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шинжээч бэлтгэх эрх зүйн зохицуулалт, чиг хандлага;
30. Зам тээврийн осол, хэргийн шинжээчийн дүгнэлт гаргахад тулгамдаж буй асуудалд хийсэн дүн шинжилгээ;
31. Мэргэшсэн жолооч бэлтгэх үйл явц ба эрх зүйн асуудалд хийсэн судалгаа.

2.3. Сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага эрхлэн гаргасан байдал, түүний ашиглалт

Монгол Улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдал, авто тээврийн үйл ажиллагааг зохицуулахад хэрэгцээтэй сурах бичиг, ном, бүтээлийг он дарааллаар түүвэрлэн гаргаж, тэдгээр бүтээлүүдийн нийтлэг тал, онцлог, цаашид анхаарал хандуулах асуудлыг гаргахыг зорьж ажиллалаа.

Хүснэгт 7. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр бичигдсэн ном, бүтээлийн жагсаалт

Сурах бичиг, ном, бүтээлийн жагсаалт		
1.	Уурын машин тэрэгний хэргийг байцаах хэлтэс 1936 он	Улаанбаатар хотын гудамж зээлээр явах зорчих тухай дагаж гүйцэтгэх зааврууд
2.	Уурын машин тэрэгний хэргийг байцаах хэлтэс 1941 он	БНМАУ-ын хотын гудамжаар явах дүрэм
3.	Улсын авто тээврийн хэргийг шалган байцаах хэлтэс 1957 он	БНМАУ-ын хотуудын гудамж ба замын хөдөлгөөний дүрэм
4.	Улсын авто тээврийн хэргийг шалган байцаах хэлтэс 1960 он	БНМАУ-ын хотуудын гудамж ба замын хөдөлгөөний дүрэм
5.	Д.Цэрэндорж 1963 он	Автомашинны ашиглалт ба засвар
6.	Г.Ринчиндорж 1965 он	Автомашинны дугуй
7.	А.Д.Жабин 1966 он	Автомобилийн жолоодлого сургахад гарын авлага
8.	Г.Ринчиндорж 1971 он	Авто машины хөдөлгөөн
9.	Д.Дүгэрээ 1972 он	БНМАУ-ын хот суурингийн гудамж замын хөдөлгөөн
10.	Г.Ринчиндорж 1972 он	Хөдөлгөөний осол, хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох зарим арга
11.	Г.Ринчиндорж Д.Дүгэрээ 1973 он	Авто машин-хүүхэд санамж зөвлөмжүүд
12.	Г.Ринчиндорж 1973 он	Авто машины марк төрлийг тогтоох лавлах
13.	А.А.Сабинин, И.П.Плеханов, В.А.Чернейкин/орчуулга/1975он	2-р зэргийн жолоочийн сурах
14.	Н.А.Игнатов 1975 он	Жолоочийн хөдөлмөрийн сэтгэл зүй, физиологийн үндэс
15.	УАТХШБ газар 1976 он	Хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө
16.	Д.Дүгэрээ 1976 он	Сургуулийн сурагчид замын хөдөлгөөн заах аргачлал
17.	Г.Ринчиндорж 1977 он	Амрыг эрье
18.	Г.Ринчиндорж 1977 он	Миний нийслэл
19.	Д.Дүгэрээ 1978 он	Бага ангийн хүүхдүүдэд замын хөдөлгөөний дүрэм заах аргачлал
20.	Б.Дашбал 1979 он	Авто машин уран жолоодох арга барил
21.	Д.Дүгэрээ 1979 он	Хөдөлгөөний дүрэм судлагчдын гарын авлага
22.	Д.Дүгэрээ, н.Лувсанжав 1979 он	Монгол Улсад ашиглагдаж байгаа автомашинуудын явах ангийн зохион байгуулалт, түүнд тохиолдох гэмтлүүд
23.	Д.Дүгэрээ, А.Хурцбилэг 1980 он	БНМАУ-ын Замын хөдөлгөөний дүрэм
24.	УАТХШБ газар 1982 он	Сурагчдад замын хөдөлгөөний дүрэм заах хичээлийн программ, сэдэв
25.	Г.Ринчиндорж 1985 он	Замын хөдөлгөөний дүрмийг судлах иж бүрэн зурагт аргачлал
26.	Ж.Артөр, Д.Шинэнэмэх 1985 он	БНМАУ-ын Замын хөдөлгөөний дүрэм
27.	Д.Будрагчаа 1985 он	Замын хөдөлгөөний дүрмийн бодлогын хураамж

28.	Д.Цэгмэд 1986 он	Автомашины хөдөлгөөний аюулгүй байдал, хяналт шалгалтын холбогдолтой заавар, журмын эмхэтгэл
29.	Улсын авто тээврийн хэргийг шалган байцаах газар 1987 он	Улсын авто техникийн хэргийг шалган байцаах албаны дүрэм
30.	Зам тээврийн яам 1988 он	Тээврийн талаар гаргасан хуульчилсан актууд
31.	Ж.Сайнжаргал, Т.Даш 1988 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль эрхийн актуудын эмхэтгэл
32.	Д.Готов , М.Тайван 1990 он	Жолоочийн ур чадвар, шатахуун хэмнэлт
33.	Ч.Базарсад, Н.Цэрэндорж, О.Жүрмэд, Ш.Феликс 1990 он	1-р зэрэг жолоочийн сурах бичиг
34.	Р.Сүхбаатар, Ж.Оюунхүү 1992 он	Замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдлын толь
35.	Д.Дүгэрээ, Ж.Каукен 1992 он	Замын хөдөлгөөний аюулгүйн үндэс
36.	Замын цагдаагийн газар 1993 он	Замын хөдөлгөөний дүрэм
37.	Замын цагдаагийн газар 1996 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний тухай хууль, дүрэм
38.	Ж.Осорхүү 1997 он	Автомашины шасси-1
39.	Ж.Осорхүү, Д.Муунохой, Ж.Мягмаржав 1997 он	Автомашины хөдөлгүүр-1
40.	Ж.Осорхүү, Д.Муунохой, Ж.Мягмаржав 1997 он	Автомашины цахилгаан тоноглол-1
41.	С.Адъяа, О.Зориг 1998 он	Авто машин таны сонголт
42.	Ч.Жаргалсайхан, А.Энхболд, Б.Батбаяр 1999 он	Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн тайлбар
43.	Ш.Бямбаа, Ж.Осорхүү, Б.Батмөнх, Ж.Базарсүрэн, Ч.Жаргалсайхан 1999 он	Орчин үеийн автомашины хөдөлгүүрийн хийцийн онцлог
44.	Замын цагдаагийн газар 1999 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай
45.	А.Хурцбилэг, А.Энхболд, Я.Мөнхжаргал, Б.Батбаяр 2000 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын тест
46.	Д.Хүрэлбаатар, Ч.Жаргалсайхан , Ж.Оюунхүү 2000 он	Авто машин жолоодохуйн урлаг
47.	Ч.Жаргалсайхан, Т.Даш, Б.Баттулга 2000 он	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө ” онол практикийн бага хурлын материал
48.	Замын цагдаагийн газар 2001 он	Монголын замын цагдаа
49.	Н.Лувсандорж 2001 он	Улаанбаатар хотод гарч байгаа хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн байдал
50.	Д.Готов 2001 он	Автомашин Өчигдөр, Өнөөдөр, Маргааш
51.	А.Хурцбилэг, Я.Мөнхжаргал, Ж.Хашбат 2001 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын тестийн тайлбар
52.	Д.Готов 2001 он	Автомашин
53.	А.Хурцбилэг, А.Энхболд, Я.Мөнхжаргал, Б.Батбаяр 2002 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын тест
54.	Эрүүл мэндийн яам 2002 он	Осол, гэмтлээс сэргийлэх хөтөлбөр

55.	Ш.Судар 2002 он	Моторт хөлөгийг эзэгнэсэн морьтон монголчууд
56.	А.Хурцбилэг, Я.Мөнхжаргал, Ж.Хашбат 2002 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын тестийн тайлбар
57.	ГССЗКЭ, НЭМХ 1998-2003 он	Монгол Улсад тохиолдож байгаа осол, гэмтлийн байдал
58.	Замын цагдаагийн газар 2003 он	Нийслэлийн автозамын сүлжээн дэх хөдөлгөөн зохицуулалтын тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам зөвлөлгөөний материал
59.	А.Энхболд 2004 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, жолооч, зорчигчдын хөдөлгөөнд оролцох сахилга соёлыг дээшлүүлэхтэй холболдсон лекц, ярианы сэдвүүд
60.	Ж.Нансалмаа 2004 он	Осол, гэмтлийг бууруулахад иргэн таны оролцоо
61.	Ч.Жаргалсайхан, Б.Баярсайхан, Ж.Хашбат, И.Базаррагчаа, Ч.Ганбат 2004 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын тестийн хураамж
62.	М.Отгон , Р.Шагдарсүрэн 2004 он	“Аюулгүй зам осолгүй байхын үндэс” сэтгүүл
63.	Хууль зүй, дотоод хэргийн яам 2004 он	Замын хөдөлгөөн эрх зүйн баримт бичгийн эмхтгэл
64.	Замын цагдаагийн газар 2004 он	Хүүхэд ба замын хөдөлгөөний аюулгүй орчин
65.	Б.Лувсан 2004 он	Монгол Улсын авто замын сүлжээг хөгжүүлэхэд миний хувь нэмэр
66.	Замын хөдөлгөөн судлалын хүрээлэн 2004 он	Замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай конвенц
67.	Ж.Доожав 2005 он	Цэнхэр хязгаарын тээврийнхэн
68.	Т.Намжим, Д.Ёндонсүрэн 2005 он	Монгол Улсын Зам тээвэр
69.	А.Хурцбилэг, Я.Мөнхжаргал, С.Баяр 2005 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын тест
70.	Ж.Осорхүү 2005 он	Яагаад энэ хариулт зөв бэ?
71.	С.Отгонтэнгэр, Ш.Нансалмаа 2005 он	Осол гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламж
72.	Т.Намжил, Д.Ёндонсүрэн 2006 он	Монгол Улсын зам тээвэр
73.	Т.Даш, Ч.Гончигсайхан, Б.Баттулга 2006 он	Замын цагдаагийн албаны түүхэн тойм
74.	Э.Алтантулга 2006 он	Анхан шатны тусламж үзүүлж сурцгаая
75.	Ж.Болдбаатар 2006 он	Их Монгол Улсын зам харилцаа, өртөө
76.	Хүний эрхийн үндэсний комисс 2006 он	Замын цагдаагийн албан хаагч нарт зориулсан сургалтын гарын авлага
77.	Д.Дүгэрээ 2006 он	Замын хөдөлгөөний осолгүйн байдал, авто тээврийн экологи
78.	д/х Б.Дашдэндэв 2006 он	Орхон аймгийн Замын цагдаагийн тасаг
79.	А.Энхболд 2006 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдал хүн автомашин зам орчин

80.	Ч.Гончигсайхан, С.Энхтөр, Б.Баттулга, С.Энхбат 2006 он	Замын цагдаагийн алба 70 жил
81.	Ж.Отгонбаяр 2006 он	Зам тээврийн ослын улмаас автомашинд учрах эвдрэл, хохирлын судалгаа
82.	А.Энхболд 2006 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдал
83.	Т.Даш, Ч.Гончигсайхан, Б.Баттулга 2006 он	Замын цагдаагийн түүхэн тойм
84.	Замын цагдаагийн газрын Шуурхай албаны хэлтэс 2007 он	Зам тээврийн осол, хэргийн газарт үзлэг хийхэд Замын цагдаагийн албаны байцаагчийн ашиглах гарын авлага
85.	Чингэлтэй дүүрэг дэх замын цагдаагийн тасаг 2007 он	Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл
86.	Д.Батжаргал 2008 он	Vision zero буюу тэглэх зөн
87.	Б.Баярсайхан 2008 он	Авто сургууль, курсуудын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хичээлийн эмхэтгэл
88.	А.Хурцбилэг, Я.Мөнхжаргал 2008 он	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм
89.	А.Лхагва 2009 он	Их хотын зам
90.	Г.Ринчиндорж 2009 он	Туулсан зам мөр
91.	Ж.Сэрээтэр 2010 он	Авто тээвэр эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл
92.	Замын цагдаагийн газар 2010 он	Замын хөдөлгөөний сургалтын тоглоом
93.	Замын цагдаагийн газар 2010 он	Зам тээврийн ослын улмаас эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн лавлагаа
94.	Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар 2010 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд
95.	Монголын Мянганы сорилтын сан 2010 он	Зам тээврийн осол, хэргийн дүн шинжилгээ
96.	Монголын Мянганы сорилтын сан 2010 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх явган зорчигч, замын цагдаа нарын мэдлэг, хандлага, дадлагын судалгаа
97.	Ж.Мягмаржав, Ц.Цэвэгжав, Ж.Хашбат, А.Ганбат 2010 он	Автомашин эзэмшигчийн гарын авлага
98.	К.Эрдэнэчулуун, Т.Батцэцэг 2010 он	Авто тээврийн ажилтны гарын авлага
99.	Монголын Мянганы сорилтын сан 2011 он	Ерөнхий боловсролын сургууль орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлын судалгаа
100.	Замын цагдаагийн газар 2011 он	Замын цагдаагийн үйл ажиллагааны тайлан 2010 он
101.	Д.Гинжбаатар 2011 он	Автомашин жолоодож сурах гарын авлага
102.	С.Энхтөр, Г.Ринчиндорж, С.Энхтулга 2011 он	“Түүх төрсөн он цагууд” 1-р дэвтэр
103.	Эрүүл амьдрал-бидний сонголт Байгууллага 2011 он	Жолооч та юу мэдэх ёстой вэ?
104.	Ч.Эрдэнэбаатар, Ч.Ганбат, Б.Лхагвасүрэн 2011 он	Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн тайлбар

105.	Замын цагдаагийн газар 2011 он	Замын хөдөлгөөний дүрэм зөрчигсдөд хүлээлгэх захиргааны арга хэмжээ
106.	Ч.Жаргалсайхан, Д.Дүгэрээ, Ж.Сүхбаатар 2011 он	Замын тээврийн ослыг шинжлэн судлах аргууд
107.	Замын цагдаагийн газар 2011 он	Авто сэтгүүл
108.	Мэргэжлийн комисс 2011 он	Замын хөдөлгөөний дүрэм зөрчигсдөд хүлээлгэх захиргааны арга хэмжээ
109.	Замын цагдаагийн газар 2011 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө
110.	Замын цагдаагийн газар 2012 он	Замын цагдаагийн үйл ажиллагааны тайлан 2011 он
111.	Замын цагдаагийн газар 2012 он	Монгол Улсын замын хөдөлгөөн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл
112.	Замын цагдаагийн газар 2012 он	Авто сэтгүүл
113.	Замын цагдаагийн газар 2012 он	Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүлэг, түүний бүтэц, үүрэг, чиглэл
114.	Б.Лхагвасүрэн 2012 он	Жолоочийн товч лавлах
115.	Ц.Эрдэнэчимэг 2012 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл
116.	Авто сургуулиудын сургалт арга зүйн төв 2012 он	Замын хөдөлгөөний дүрмийн бодлогын хураамж Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгэмлэг
117.	Санхүүгийн зохицуулах хороо 2012 он	Жолоочийн даатгалын зохицуулалтын эрх зүйн актын эмхэтгэл
118.	Б.Лхагвасүрэн 2013 он	Замын хөдөлгөөн “эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл”
119.	Ц.Эрдэнэчимэг 2013 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
120.	Замын цагдаагийн газар 2013 он	Замын цагдаагийн үйл ажиллагааны тайлан 2012 он
121.	Ч.Ганбат 2013 он	Авто техникийн багшийн гарын авлага
122.	Матти Ройни, Ж.Дэмбэрэлсүрэн 2013 он	Авто замын аюултай цэгүүдэд авах арга хэмжээ
123.	Монголын мянганы сорилтын сан 2013 он	Зам тээврийн осолд хийх үзлэг
124.	Б.Лхагвасүрэн 2014 он	Мотоцикл ба хөдөлгөөний аюулгүй байдал
125.	Ц.Эрдэнэчимэг 2014 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
126.	Замын цагдаагийн газар 2014 он	Замын цагдаагийн үйл ажиллагааны тайлан 2013 он
127.	Ц.Эрдэнэчимэг 2015 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
128.	Т.Намжил, Д.Ёндонсүрэн, Д.Готов 2015 он	Монгол Улсын тээврийн салбарын замнал, хөгжил
129.	Замын цагдаагийн газар 2015 он	Замын цагдаагийн үйл ажиллагааны тайлан 2014 он
130.	Тээврийн яам 2015 он	Хятад Монголын олон Улсын авто тээврийн гарын авлага
131.	Тээврийн яам 2015 он	Хятад Монголын олон улсын авто тээвэрчдэд зориулсан гарын авлага

132.	Ц.Эрдэнэчимэг 2016 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
133.	Тээврийн яам 2016 он	Улс хоорондын авто тээврийн талаар хяналт, зохицуулалтын байгууллагуудад зориулсан гарын авлага
134.	Тээврийн яам 2016 он	Улс хоорондын тээврийн жолооч нарт зориулсан гарын авлага
135.	Р.Мөнхбаяр Э.Энхболд Д.Далайцэрэн 2016 он	Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмүүдийн эмхэтгэл
136.	Р.Мөнхбаяр, Э.Энхболд Д.Далайцэрэн 2016 он	Зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, ослын шалтгаан нөхцлийг тогтоох зарим арга зам
137.	Замын цагдаагийн алба 2016 он	Замын цагдаагийн үйл ажиллагааны тайлан 2015 он
138.	Ц.Эрдэнэчимэг 2017 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
139.	Замын цагдаагийн алба 2017 он	Замын цагдаагийн албаны үйл ажиллагааны тайлан 2016 он
140.	Ц.Эрдэнэчимэг 2018 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
141.	Тээврийн цагдаагийн алба 2018 он	Тээврийн цагдаагийн албаны үйл ажиллагааны тайлан 2017 он
142.	Тээврийн цагдаагийн алба 2019 он	Тээврийн цагдаагийн албаны үйл ажиллагааны тайлан 2018 он
143.	Ц.Эрдэнэчимэг 2019 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
144.	Р.Мөнхбаяр, Э.Энхболд, Д.Далайцэрэн, Б.Галсанжамц, Я.Соронзонболд 2019 он	Зам тээврийн ослыг шалгах ажиллагаа, ослын шалтгаан нөхцлийг тогтоох зарим арга зам, хууль, тогтоомжийн эмхэтгэл
145.	Тээврийн цагдаагийн алба 2020 он	Тээврийн цагдаагийн албаны үйл ажиллагааны тайлан 2019 он
146.	Ц.Эрдэнэчимэг 2020 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
147.	Тээврийн цагдаагийн алба 2021 он	Тээврийн цагдаагийн албаны үйл ажиллагааны тайлан 2020 он
148.	Ц.Эрдэнэчимэг 2021 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт
149.	Тээврийн цагдаагийн алба 2022 он	Тээврийн цагдаагийн албаны үйл ажиллагааны тайлан 2021 он
150.	Ц.Эрдэнэчимэг 2022 он	Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг авч үзсэн 150 бүтээлийн жагсаалтыг гаргалаа. Эдгээр бүтээлүүдийг нарийвчлан авч үзвэл, нэг сэдэвт бүтээл 34%, дүрэм, журмын эмхэтгэл 29%, статистик мэдээлэл бүхий эмхэтгэл 27%, гарын авлага 10%-ийг тус тус эзэлж байна.

Нийт бүтээлийн 60% нь 2000 оноос хойш бичигдсэн байгаа нь тухайн үеэс замын хөдөлгөөний асуудлыг тулгамдсан асуудалд тооцож, судлаачид өнөөгийн нийгмийн гол асуудлыг урьдчилан сэрэмжлүүлж эхэлж байсантай холбож үзэж болох юм.

1936-2000 он хүртэл бүтээгдсэн ном бүтээлийн сэдвийн агуулгыг ерөнхийлөн авч үзвэл дүрэм, журмын эмхэтгэлээс гадна замын хөдөлгөөний ойлголтыг түгээхийг зорьсон нэг сэдэвт бүтээл, орчуулгын бүтээлүүд зонхилж байна. Харин 2000 оноос хойш зам тээврийн осол, зөрчлийн статистик, дүн шинжилгээ хийсэн бүтээлүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Үүнээс үзвэл, зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стандарт, гадаадын орны туршлага зэргийг өргөн агуулгаар нь олон салбарын эрдэмтэн судлаачидтай хамтран туурвих шаардлага бий болжээ.

2.4. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, дэвшүүлсэн асуудал, хэрэгжилт

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрдэм шинжилгээний хурал олон зохион байгуулагддаг төдийгүй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд өгүүллүүд харьцангуй их нийтлэгддэг. Үүнээс тухайн асуудал нь нийгэмд хэр зэрэг тулгамдаж байгааг харж болох юм.

Бид замын хөдөлгөөний аюулгүй байдлын судалсан байдлыг гаргах үүднээс зарим хурлын илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлүүдийг түүвэрлэн авч үзлээ.

Хүснэгт 8. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хэлэлцүүлсэн илтгэл, өгүүллийн жагсаалт

2020 он Тээврийн прокурорын газрын “Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөл, түүнийг арилгах арга зам, цаашид анхаарах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл		
1	Б.Дэлгэрмаа	Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал
2	Г.Оюунболд	Замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт
3	Т.Мөнхцэцэг	Төмөр замын тээврийн осол, гэмтэлд нөлөөлж буй шалтгаан, түүнийг бууруулах арга зам
4	Х.Баярхүү	Ашиглагдаж байсан тээврийн хэрэгслийг импортлоход анхаарах асуудал
5	Б.Мөнхдорж	Зам тээврийн ослоос шалтгаалсан нас баралтыг бууруулах зарим асуудал
6	Э.Энх-Амар	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь
7	Д.Түмэнбаяр	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийн хамтын ажиллагааны байдал
8	Б.Тамир	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулж буй гадаад орнуудын хууль тогтоомж, эрх зүйн орчин
9	Н.Шинэбаатар	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түүнээс урьдчилан сэргийлэхэд төр, засгаас болон холбогдох байгууллагуудын зүгээс анхаарах асуудал
10	Ү.Оюун-Эрдэнэ	Монгол Улсад гарч байгаа зам тээврийн осол, гэмт хэрэгт нөлөөлж буй хүчин зүйлс, шалтгаан, нөхцөл
11	О.Гарьд	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах асуудал
12	Д.Ганзориг	Авто тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт
13	Э.Бямбажаргал	Замын цагдаагийн алба хаагчдын ажлаас халшрах хам шинж, шалтгаан, хүчин зүйл
Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн өгүүллүүд		
14	О.Батжаргал	Дэлхий нийтээр зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж буй бодлого, цаашдын зорилт 2010 №4
15	Б.Энхболд	Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал 2010 №4

16	Д.Нямдорж	<p>ОХУ-ын Шинжлэх ухаан боловсролын яамны дээд аттестатчллын комиссын сэтгүүлд дараах нийтлэлүүдийг хэвлүүлсэн. Үүнд:</p> <p>1. Доржсурэн Нямдорж. Некоторые криминологические оценки состояния и предупреждения дорожно-транспортных преступлений в Монголии /Вестник Московского университета МВД России. 2008. № 7 - 0,3 п.л./</p> <p>2. Доржсурэн Нямдорж. Проблемы предупреждения дорожно-транспортных преступлений в Монголии/ Криминологический журнал. 2007. №12-0,4 п.л./</p> <p>3. Доржсурэн Нямдорж. Анализ правовых актов Монголии в сфере дорожного движения: исторический аспект// Вопросы совершенствования правоохранительной деятельности органов внутренних дел: Материалы научно-практической конференции адъюнктов и соискателей Московского университета МВД России (Москва, 25 июня 2008 г.)-М.: Московский университет МВД России, 2008. - 0,3 п.л.</p> <p>4.Зам тээврийн осол, гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түүнийг бууруулах арга замууд 2011 №4</p>
----	-----------	---

Дээр дурдсанчлан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлийн эрдэмтэн судлаачид маань агуулгын хувьд хэт энгийн бөгөөд хуучинсаг сэдэвтэй илтгэл, өгүүлэл нийтлүүлсээр байгаа нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, орчин үеийн техник технологи, инновацын шийдлийг эрэлхийлсэн, нөгөөтээгүүр амьдралд шууд хэрэгжүүлэн үр дүнгээ өгөх гарц бүхий санааг дэвшүүлэн ажиллах хэрэгтэй байна. Үүний тулд онол, практик, статистик мэдээнд суурилсан өөрийн орны онцлог, иргэдийн ухамсар төлөвшилд тохирсон олон салбарын хамтын судалгаа нэн шаардлагатай юм.

Цаашид судлах шаардлагатай суурь болон хавсарга, бодлогын хууль зүй, техник, боловсролын болон бусад чиглэлээр судалгааны ажлын сэдвийн томъёолол:

- Хүнээс үүдэн гарах зам тээврийн осол, хэрэгт хийсэн дүн шинжилгээ
- Тээврийн хэрэгслийн насжилтаас үүдэн гарах зам тээврийн осол, хэрэгт хийсэн дүн шинжилгээ
- Механикжаагүй тээврийн хэрэгслээс үүдэн гарах зам тээврийн осол, хэрэгт хийсэн дүн шинжилгээ
- Механикжсан тээврийн хэрэгслээс үүдэн гарах зам тээврийн осол, хэрэгт хийсэн дүн шинжилгээ
- Мотоциклтой холбоотой зам тээврийн осолд хийсэн дүн шинжилгээ
- Замаас үүдэн гарах зам тээврийн осол, хэрэгт хийсэн дүн шинжилгээ
- Замын хөдөлгөөн зохион байгуулах техник, хэрэгслээс үүдэн гарах зам тээврийн осол, хэрэгт хийсэн дүн шинжилгээ
- Замын хөдөлгөөн зохион байгуулах техник, хэрэгслийн орчин үеийн боловсронгуй системийг судалгаа, түүнийг Монгол улсад нэвтрүүлэх боломжид хийсэн дүн шинжилгээ
- Монгол улсад замын хөдөлгөөнд оролцогчдын сургалтын нэгдсэн бодлогод хийсэн дүн шинжилгээ

- Хүүхэд өртсөн замын тээврийн осолд хийсэн дүн шинжилгээ
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг бууруулах чиглэлээр хийгдсэн олон улсын туршлага
- Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудал

Судалгааны ажлын хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар докторын 8, магистрын 135, бакалавр 19 ажил, 150 ном бүтээл, 20 илтгэл, өгүүлэлд харьцуулан дүн шинжилгээ хийж ажиллалаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр манай орны судлаачид 1980-аад оноос ЗХУ, ОХУ-д эрдмийн зэрэг хамгаалж эхэлсэн байх ба 2000-аад оноос өөрийн орондоо эрдмийн зэрэг хамгаалж эхэлжээ. Энэ чиглэлээр хамгаалсан эрдмийн зэргийн 80% нь техникийн ухааны, 20% нь хууль зүйн ухааны мэргэшлээр бичигджээ.

Судалгааны ажлын үр дүнг хэрэгжүүлэлт харьцангуй сул байгаа нь ажиглалт, санал асуулгын дүнгээр илэрч байна. Учир нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь дан ганц судлаач, байгууллагын үйл ажиллагаа бус олон төрлийн салбарын хамтын ажиллагааг шаарддаг онцлогтой билээ.

Иймд энэ төрлийн докторын судалгааны ажил эрхэлж буй судалгааны байгууллага, төсөл, судалгаа, хувь судлаачдыг дэмжих урамшуулах, хамтын ажиллагааг хангах асуудлыг бодлогын түвшинд авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой сэдвээр магистрын судалгааны ажил хамгаалсан байдлыг бид Монгол Улсын их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Орхон их сургууль, Үндэсний батлан хамгаалах их сургууль, Төмөр замын дээд сургууль, Механик тээврийн сургуулиудын хүрээнд авч үзлээ.

Үүнээс үзвэл, сургууль тус бүр сэдвийн чиглэл харилцан адилгүй бөгөөд мэргэжлийн чиглэлээс шалтгаалсан сэдвүүд зонхилж байна. Тухайлбал, Их засаг олон улсын их сургуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаасаа гэмт хэрэг, зөрчлийг нотлох ажиллагаа, урьдчилан сэргийлэх асуудал, эрх зүйн зохицуулалтыг түлхүү судалсан бол Орхон их сургуульд нийт хамгаалсан магистрын ажлын 90 орчим хувь нь эрх зүйн зохицуулалтын асуудал байна. Монгол Улсын их сургуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын сэдвүүдэд хувийн эрх зүйн салбарын асуудал буюу даатгал, татвар, зардлыг тооцох мөн хүний эрхийг хангах зэрэг агуулгуудыг түлхүү авч үзжээ. Харин Үндэсний батлан хамгаалах их сургууль, Төмөр замын дээд сургууль, Механик тээврийн сургуульд техник ашиглалтын аюулгүй байдал, тээвэр ложистик, төлөвлөлт менежмент, үйлчилгээний асуудлыг түлхүү авч үзжээ.

Үүнээс үзвэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр харьцангуй олон талт судалгаа, үр дүн гарсан байх боломжтой байна. Судалгааны ажлуудын сэдвүүд нь анхаарал татахуйц, асуудлын шийдлийг эрэлхийлсэн нь их байх боловч магистрын судалгааны ажлын чанар сул, хэрэгжилт тааруу байдаг нь бодит үр дүн юм.

Мөн судалгааны ажлын сэдэв, агуулга маш их давтагдаж байна. Энэ нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил, оюуны өмчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сул байгаа, нөгөөтээгүүр хуулбарлалтыг шалган тогтоох үйл ажиллагаа харьцангуй сүүлд нэвтэрч эхэлж буйтай холбоотой юм.

Бакалаврын түвшний судалгааны ажлуудын сэдвийг дахин нарийвчлан боловсруулах шаардлага бий болж байна. Учир нь сонгогдсон сэдвүүд өмнө нь судлагдсан хэт ерөнхий сэдвүүд байгаа нь учир дутагдалтай юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг авч үзсэн 150 бүтээлийн жагсаалтыг гаргалаа. Эдгээр бүтээлүүдийг нарийвчлан авч үзвэл, нэг сэдэвт бүтээл 34%, дүрэм, журмын эмхэтгэл 29%, статистик мэдээлэл бүхий эмхэтгэл 27%, гарын авлага 10%-ийг тус тус эзэлж байна.

Нийт бүтээлийн 60% нь 2000 оноос хойш бичигдсэн байгаа нь тухайн үеэс замын хөдөлгөөний асуудлыг тулгамдсан асуудалд тооцож, судлаачид өнөөгийн нийгмийн гол асуудлыг урьдчилан сэрэмжлүүлж эхэлж байсантай холбож үзэж болох юм.

1936-2000 он хүртэл бүтээгдсэн ном бүтээлийн сэдвийн агуулгыг ерөнхийлөн авч үзвэл дүрэм, журмын эмхэтгэлээс гадна замын хөдөлгөөний ойлголтыг түгээхийг зорьсон нэг сэдэвт бүтээл, орчуулгын бүтээлүүд зонхилж байна. Харин 2000 оноос хойш зам тээврийн осол, зөрчлийн статистик, дүн шинжилгээ хийсэн бүтээлүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Үүнээс үзвэл, зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стандарт, гадаадын орны туршлага зэргийг өргөн агуулгаар нь олон салбарын эрдэмтэн судлаачидтай хамтран туурвих шаардлага бий болжээ.

Эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэн судлаачид мэргэжлийн чиглэлээр ном бүтээл харьцангуй бага эрхлэн гаргаж байна гэж дүгнэлээ. Сургалтад хэрэглэж байгаа сурах бичиг, гарын авлага хэт хуучирсан бөгөөд бэлтгэгдэж буй алба хаагчидад унших судлах материал хомс зэрэг асуудлууд урган гарч болхоор байна.

ГУРАВ. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4-т “Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ⁸” гэж тусгасан нь энэхүү судалгааны ажлын үндэслэлийг тодорхойлсон.

Монгол Улсын тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн хэд хэдэн хууль тогтоомж Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ч Цагдаагийн албаны тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсролын тухай хуулиуд нь цагдаагийн алба хаагчдын сургалтын үйл ажиллагааны үндэс болж буй хэдий ч эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангаж чадахгүй байна. Үүнээс үндэслэн сургалтын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах үүднээс “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны журам” зэрэг системчилсэн актуудыг судалгаануудад түшиглэн, гадаадын зарим орны жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдөж эхлээд багагүй хугацаа өнгөрчээ.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 229 дугаар тогтоолоор Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийн үйл ажиллагааг нэгтгэн, Дотоод хэргийн их сургуулийг байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны тушаалаар “Дотоод хэргийн их сургуулийн хөгжлийн стратеги хөтөлбөр 2012-2021”-ийг баталсан.

Энэхүү хөтөлбөрийн I үе шат амжилттай хэрэгжиж, хяналт шинжилгээ хийгдсэн тухайн цаг үетэй зэрэгцэн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай Монгол Улсын хууль, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын бичиг баримт батлагдаж, Хууль зүйн сайдаас Их сургуулийн сургалтын арга, технологийг илүү боловсронгуй болгон өөрчлөх, зарим мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хөгжингүй орнуудын загвар туршлагаар шинэчлэх чиглэл өгсөн зэрэг нь “Хууль сахиулахын их сургуулийн хөгжлийн стратеги хөтөлбөр 2016-2025”-ийг боловсруулах үндсэн хүчин зүйл болж, Хууль зүйн сайдын 2016 оны А/169 дугаар тушаалаар батлагдсан байна.

Бид тээврийн цагдаагийн алба хаагчийг сургах, бэлтгэх чиглэлээр баримталж буй эрх зүйн зохицуулалтыг түүвэрлэн өнөөгийн байдлаар хэрхэн хэрэгжиж байгаа талаар болон тулгамдаж буй асуудлыг тогтоохоор дүн шинжилгээ хийлээ.

Тээврийн цагдаагийн алба хаагч нь төрийн тусгай чиг үүрэг бүхий субъект тул зөвхөн энэ чиглэлийн сургалтуудад хамаарах эрх зүйн зохицуулалтыг судлахаар зорилоо. Тээврийн цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалттай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтын талаар энэхүү дэд бүлэгт дараах 5 түвшинд авч үзлээ.

1. Олон улсын гэрээ, конвенц;
2. Монгол Улсын хууль;
3. Бодлогын баримт бичиг;

⁸ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4 дэх хэсэг.

4. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан эрх зүйн акт;
5. Үйл ажиллагааны журам, заавар, тушаал

3.1. Олон улсын гэрээ, конвенц:

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын дараах гэрээ, конвенц болон тунхаглалын холбогдох зүйл, заалтууд нь цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн харилцаатай холбоотой зохицуулалт гэж үзэж байна. Тухайлбал,:

➤ Хүний эрхийн түгээмэл тунхаглал⁹

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III тогтоолоор Парист батлагдсан. Энэхүү тунхаглал нь туршлагаас үүдэж "хүн бүхэнд төрөлх заяасан эрх бий" хэмээх санааг анх дэлхийн түвшинд гаргаж ирсэн болно. Нийт гучин зүйл ангиас бүрдсэн энэхүү тунхаглал нь олон улсын болон бүс нутгийн хэмжээний хүний эрхийн гэрээ, хуулиудын үндэс болсон бөгөөд хүн бүрийн сурч, боловсрох эрхийг хамруулан авч үзсэн нь цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, тэдний сурч, боловсрох нь эрх тэгш байх нөхцөлийг бүрдүүлж буй илрэл юм.

Тус тунхаглалд хүн бүр сурч боловсрох эрхтэй буюу наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байх, анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх, техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх талаар тусгасан.

Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-аас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой.

➤ Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд алагчлахгүй байх явдлыг гаргаж үл болох зарчмыг баталж, хүн бүр боловсрол эзэмших эрхтэй гэж тунхагласныг санан, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага нь дүрэмдээ заасан ёсоор хүний эрхийг хаана ч сахин хамгаалах, боловсрол олох тэгш эрхээр бүх нийтийг хангахын тулд улс үндэстнүүдийн хооронд хамтын ажиллагаа тогтоохын төлөө эрмэлздэгийг анхаарч, Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага нь улс гүрэн тус бүрийн боловсролын тогтолцоо нь өөр өөр байдгийг иш үндэс болгон боловсролын талаар аливаа алагчлалыг арилгах төдийгүй, энэ талаар бүх нийтийн тэгш бололцоо, тэгш харьцаатай байх явдлыг хөхиүлэн дэмжих ёстойг анхаарч, чуулганы хэлэлцэх хэргийн 17.1.4 дэх хэсэгт тусгасан асуудлаас үүдэлтэйгээр бий болж буй боловсрол дахь алагчлах төрөл бүрийн асуудлаарх саналыг хүлээн авч, гишүүн улсын зөвлөмжийг болон эл асуудал нь олон улсын конвенцын асуудалд тооцох нь зүйтэй гэсэн шийдвэр аравдугаар чуулганаас гарсныг анхаарч, 1960 оны 12 дугаар сарын 14-ний өдөр энэхүү Конвенцыг баталсан.

Энэ нь боловсролын тогтолцооны хувьд тэгш боломжийг хангах талаар манай улсын баримтлах бодлогыг тодорхойлж байгаа нь батлагдаж байна.

⁹ Төрийн мэдээлэл тусгай дугаар. 1-р боть. – Уб., 2004.

3.2. Монгол Улсын хууль, тогтоомж

➤ Монгол Улсын Үндсэн хууль¹⁰

Монгол Улсын Үндсэн Хуульд цагдаагийн байгууллагын чиг үүргийн үндэс болдог эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн болох талаар тусгаснаас гадна хүн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй гэж заасан.

Энэ нь НҮБ-аас гаргасан тунхаг бичгүүд, олон улсын конвенцод нийцэж байгааг илтгэж байна. Мөн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцаж, онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно гэдэг нь цагдаагийн байгууллагын чиг үүргийг тодотгож байна.

Гэхдээ энэ нь хүний эрхийг дээдлэх зарчмыг зөрчихгүй байхыг ч дурджээ. Монгол Улсын Үндсэн хуульд “нийгмийн хэв журам”¹¹, “нийгмийн дэг журам”¹² гэсэн нэр томьёо орсон бөгөөд нийгмийн дэг журам гэсэн ойлголтыг тайлбарласан тайлбар өнөөг хүртэл байхгүй байна.

Харин нийтийн хэв журмыг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-д “нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээ”¹³ хэмээн тодорхойлсон байна.

Нийгмийн хэв журам гэдэг нь өргөн утгаараа хүмүүсийн хоорондоо харилцах явцад хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх бололцоог хангах, төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой иргэний нийгмийн хэрэгцээт шаардлагатай нөхцөлдөн гарсан Монголын ард түмний эрх ашигт нийцэх зан заншил, уламжлал, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэл тогтолцоо мөн.¹⁴

Нийгмийн хэв журам сахиулах үүргийг Засгийн газар хүлээдэг бол энэхүү нийгмийн хэв журмын нэгж бүрдэл хэсэг болсон нийтийн хэв журам сахиулах үүргийг цагдаагийн байгууллага хүлээдэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “Нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн...” гэж заасан. Энэ нь төрийн бүх байгууллагад хамааралтай, төр болон төрийн захиргааны байгууллагуудын хамтын хүчин чармайлтаар хэрэгжих үйл явц юм.

¹⁰ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №1. -Уб., 1992.

¹¹ Монгол Улсын Үндсэн хууль. 16-р зүйлийн 17, 18, 18-р зүйлийн 5, 19-р зүйлийн 1, 38-р зүйлийн 7 дахь хэсэг.

¹² Монгол Улсын Үндсэн хууль. 11-р зүйлийн 1 дэх хэсэг.

¹³ ЦЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн а/44 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код 500.3-т тодорхойлсон.

¹⁴ Таванжин, Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. -Уб., 2006. 46 дахь тал.

Тиймдээ ч нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаа томоохон байр эзэлж болохыг үйл ажиллагааны цар хүрээ, хамтран ажиллах байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаанаас харж болох юм.

Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх¹⁵ нь Монгол Улсын Засгийн газрын нийтлэг чиг үүрэг, хэрэгжүүлэх бүрэн эрх болох талаар Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.7-д заажээ. Эндээс харахад эдгээр ойлголтууд нь хэрэгжүүлэх субъектээрээ ихээхэн ялгаатай төдийгүй нийгмийн хэв журам нь өргөн агуулгатай, харин нийтийн хэв журам нь түүний бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгож болно. Эдгээр заалтууд нь цагдаагийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг илэрхийлж байгаа бөгөөд Монгол Улсын иргэний сурч, боловсрох эрхийг хуулиар хамгаалсан нь судалгааны ажилд хамааралтай гэж дүгнэж байна.

➤ **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль¹⁶**

Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, эсхүл тодорхой чиглэлээр мэргэшүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамруулна” гэж заасан.

Мөн 21.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 21.1-д заасан сургалтыг дээд боловсролын сургалтын болон судалгаа, шинжилгээний байгууллага, эсхүл гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг түшиглэн зохион байгуулах бөгөөд дагнасан сургалтын төвийг нийслэл, түүнчлэн бүсийн төвд байгуулж болно” 21.3 дахь хэсэгт “Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сургах, бэлтгэхдээ тодорхой чиглэлээр мэргэшүүлэх, албан тушаалд томилохдоо мэргэшсэн чиглэлийг үндэслэл болгох зарчмыг баримтална” гэж тус тус заажээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд цагдаа, хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сургах, бэлтгэхдээ мэргэшүүлэх, мэргэшсэн чиглэлийг үндэслэл болгон албан тушаалд томилох зарчмын талаар эрх зүйн зохицуулалтыг суулгаж өгсөн нь үр дүнтэй заалт хэдий ч үүнийг хэрэгжүүлэх тал дээр практик учир дутагдалтай байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалтыг нэг мөр болгох, мэргэшсэн байдлыг харгалзан дэвшүүлэх талаар тодорхой санал дэвшүүлэх нь энэ судалгааны ажлын зорилгод хамаарч байгаа болно.

Энэ нь цагдаагийн алба хаагчийн сургалт, тэдний мэргэшсэн байдал болон албан тушаалын харилцаа, хамаарлыг нэгтгэн авч үзэх гол эрх зүйн эх сурвалж болох боломжтой хэдий ч практикт энэ байдал алдагдсан болох нь ажиглалтаар илэрч байна. Тухайлбал, цагдаагийн алба хаагчдыг томилоход сургалт, мэргэшсэн байдлыг голчлон авч үздэггүй болохыг алба хаагчидтай ярилцлага судалгааны явцад илэрхийлж байв.

➤ **Боловсролын ерөнхий хууль¹⁷**

Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18-д “цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага” гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг хэлнэ”, 34.3-т Цэрэг, цагдаагийн мэргэжлийн

¹⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. -Уб., 1992.

¹⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл. № 42. -Уб., 2019.

¹⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл. №19. -Уб., 2023.

болон дээд боловсролын сургалтын байгууллагад энэ хуулийн 34.1 дэх хэсэг хамаарахгүй бөгөөд чиг үүргийн онцлогт нийцсэн захиргааны зөвлөлтэй байна, 37.2.3-т цэрэг, цагдаагийн дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад төсвөөс санхүүжүүлсэн зардал, эрдэм шинжилгээний төсөлт ажлын санхүүжилттэй байхаар тус тус заасан.

Дээрх хуульд цэрэг, цагдаагийн чиглэлээр сургалтын тогтолцоо, зохион байгуулалтын асуудлыг зохицуулаагүй орхисон заалт тусгасан нь тухайн салбарын сургалтын асуудал ялгаатай, онцлог шинжтэй гэдгийг харуулж байна.

Гэхдээ цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн индекс ангиллыг тогтоох асуудал нь энэ хуулиар зохицуулагдаж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар бидний судалгааны гол асуудал нь үүнд оршиж байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчийг бакалаврын түвшинд бэлтгэж байгаа практикт “аюулгүй байдлын үйлчилгээ” индекстэй байгаа нь ЮНЕСКО-ийн зөвлөмжийн дагуу Боловсролын тухай хуулийг үндэслэн тогтоож буй ангилалд тулгуурлаж байгаа билээ. Иймээс тус хөтөлбөрийн агуулга, нийгмийн хэрэгцээ, шаардлага, албан тушаалын тодорхойлолт, өөрийн орны онцлогт тохируулж, цагдаагийн алба хаагчдыг бакалаврын түвшинд “эрх зүйч” индекстэй бэлтгэх боломжийг зохицуулах шаардлага бий болж байна.

➤ **Төрийн албаны тухай хууль**¹⁸

Төрийн албаны тухай хуулиар иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулах, тухайн сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулж, сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн тодорхойлохоор зохицуулсан. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөө нь энэ хуульд заасны дагуу бүрэн хэрэгжиж, түшмэлийн дэс дарааллын дагуу хөгжих боломжийг олгож байна.

Төрийн албаны хуульд төрийн байгууллага алба хаагчийн сургалтыг зохион байгуулах талаар нийтлэг заалтыг оруулж өгсөн нь цагдаагийн албаны сургалтыг зохион байгуулах бас нэгэн үндэслэл болж байна. Харин 29 дүгээр зүйлд заасан богино болон дунд хугацааны сургалт нь төрийн бусад албан хаагчийг хамруулан ойлгож, тухайн сургалтыг Удирдлагын академи зохион байгуулахаар зохицуулсан. Эдгээр сургалтын үр дүнд тулгуурлан түшмэлийн дэс дарааллын дагуу хөгжих боломжийг олгохыг хуулиар тогтоосон нь сургалтын ач холбогдлыг нэмэгдүүлсэн гэж дүгнэж байна. Үүний дагуу төрийн алба хаагчийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө үр дүнтэй хэрэгждэг бол Цагдаагийн албаны тухай хуульд энэ төрлийн хөшүүрэг заалт тусгагдаагүй нь сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг болох нь судалгааны үр дүнд нотлогдож байна. Мөн цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг нь Төрийн албаны тухай хуулийг үндэслэн хэд хэдэн зохицуулалтыг авсан байх боловч хэрэгжилт нь бодит байдалд илэрдэггүй сул талтай.

➤ **Цагдаагийн албаны тухай хууль**

Тус хуулийн 17 дугаар зүйлд “Цагдаагийн албаны сургалтын байгууллага”-ын талаар авч үзсэн бөгөөд 17.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно”

¹⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. -Уб., 2018.

гэж, 17.2 дахь хэсэгт “Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэж тус тус заажээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд цагдаагийн албаны сургалтын байгууллага гэж тодотгон авч үзсэн бөгөөд үүнд алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтыг хамруулсан байна. Харин галт зэвсгийн болон гэрээт харуул хамгаалалтын сургалтыг төлбөртэй зохион байгуулахаар заасан.

Мэргэжлийн бэлтгэл, давтан, албаны зэрэг сургалтын ангиллыг шинэчлэн өөрчлөх хэрэгцээ, шаардлага бий болсон нь эдгээр сургалтын хэрэгжилт, үр дүн сул байгаагаар илэрч байна.

Мөн 66 дугаар зүйлийн 66.3-д “Цагдаагийн байгууллага цагдаагийн алба хаагч бүрд мэргэжлээрээ суралцах, албан тушаал дэвших тэгш боломж, нөхцөл бүрдүүлнэ”, 66.8-д “Цагдаагийн төв байгууллага цагдаагийн албаны хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад захиалга өгнө” гэж тус тус заажээ.

Харин 67 дугаар зүйлийн 67.3-д “Цагдаагийн байгууллагад шаардлагатай нарийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор иргэнтэй гэрээ байгуулан дотоод, гадаадын боловсролын байгууллагад сурган, цагдаагийн албан тушаалд томилж болно” гэж заасан.

Үүнээс үзвэл, цагдаагийн алба хаагч бүр суралцах, албан тушаал дэвших тэгш боломжтой байхаар хуульчилсан нь практикт бүрэн хангагдахгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Тус хуулийн 66 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллага гэж тусгаж өгсөн нь Дотоод хэргийн их сургуультай хамтран ажиллах уялдаа холбоог хамааруулсан оновчтой заалт байна.

Нарийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор иргэнтэй гэрээ байгуулан дотоод, гадаадын боловсролын байгууллагад сургах талаар тусгасан нь практикт зөрүүтэй хэрэгжиж байгаа нь судалгаагаар тогтоогдож байна. Тухайлбал, нарийн мэргэжлийн чиглэлээр алба хаагчийг сургах, бэлтгэх чиглэлээр гэж тусгасан хэдий ч дотоодын бусад их, дээд сургууль, гадаадын боловсролын байгууллагад төгссөн иргэн цагдаагийн бусад үндсэн албадад ажиллаж байна.

Үүнээс гадна 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын дарга нь үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлгээний үр дүнг харгалзан цагдаагийн алба хаагчийг зохих шатны сургалтад хамруулах, цалингийн нэмэгдлийг тогтоох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ” гэж заажээ.

Энэхүү заалтад цагдаагийн алба хаагчийн сургалтын үр дүнг үнэлэх талаар тусгасан хэдий ч тухай бүр шийдвэрлэнэ гэсэн нь тэгш бус байдлыг үүсгэх шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл, алба хаагчийг зохих шатны сургалтад хамруулж, албан тушаал дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэх давтамж байхгүй, ямар төрлийн сургалтыг ямар албаны алба хаагчдад зохион байгуулах нь тодорхойгүй байгаа нь тул хуулийн заалт болон, үйл ажиллагааны журмаас илэрч байна.

Тус хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6-д “Энэ хуулийн 81.4.1, 81.4.2, 81.4.3, 81.4.4, 81.4.5-д заасан шийтгэл хүлээсэн алба хаагч тогтоосон хугацаанд хувийн зардлаар ёс зүйн сургалтад хамрагдах үүрэгтэй. Энэ хугацаанд байгууллага цалингүй чөлөө олгоно” гэж заасан ба 81.7-д “Энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан цагдаагийн албаны сургалтын байгууллага шийтгэл хүлээсэн алба хаагчийн хамрагдах ёс зүйн сургалтыг цагдаагийн төв байгууллагын даргын баталсан үнэлгээний дагуу төлбөртэй явуулна” гэжээ.

Цагдаагийн алба хаагчид сахилгын шийтгэл хүлээсэн тохиолдолд ёс зүйн төлбөртэй сургалтад хамрагдах талаар хуульчилсан нь агуулгын хувьд зохистой хэдий ч сургалтын нэгдсэн стандарт, сургалтад хамрагдаж буй алба хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцэх байдалд шинэчлэл хийх шаардлагатай болох нь практикт ажиглагдаж байна.

➤ **Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль**

Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт нь онолын, сургууль дээрх дадлага, үйлдвэрлэлийн дадлага гэсэн бүрэлдэхүүнтэй, сургалтын байгууллага болон ажлын байран дахь, хосмог, зайны болон цахим сургалтын хэлбэртэй байна” гэж заажээ.

Цагдаагийн анхан шатны сургалт буюу гэрчилгээ олгох, ахлагч бүрэлдэхүүний бэлтгэл сургалт нь өнөөгийн байдлаар ДХИС-ийн харьяа Ахлагчийн мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвд зохион байгуулагдаж байгаа. Энэ нь дээрх хуулийн дагуу сургалтын байгууллагын хэв шинжийг агуулж, тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж, сургалтын дагнасан хэлбэртэй байгаа тул үйл ажиллагааны хувьд оновчтой шийдэл мөн юм.

Дэлхийн зарим орнуудад ахлагч бие бүрэлдэхүүнийг практик байгууллага нь бэлтгэдэг нь тухайн орны эрх зүйн зохицуулалттай холбоотой бөгөөд манай орны хувьд боловсролын шинэчлэлийн хүрээнд энэ төрлийн сургалтын эрх зүйн зохицуулалт хангагдсан байгаа нь давуу тал бөгөөд элсүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд практик байгууллага нягт хамтран ажиллах шаардлагатай.

3.3. Бодлогын баримт бичиг

➤ **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого¹⁹**

Энэхүү бодлогын баримт бичгийн 7.4 дэх зорилтод “Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ” гэж заажээ.

Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, салбарын алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлсэн байна.

➤ **Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд**

Харин тус үзэл баримтлалын 4.1.2-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлд шаардлагатай эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ”, 4.1.4-д “Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ”,

¹⁹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.

4.2.1-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ”²⁰ гэж заажээ.

Үүнээс үзвэл, төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллага болох цагдаагийн байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлтэй бөгөөд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлд шаардлагатай эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ гэж үзэл баримтлалд тусгасан нь бидний судалгааны ажлын агуулгатай уялдаж байна.

➤ **Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг**

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ын дагуу жил бүр нэмэгдэх орон тоогоор байгууллагын хүний нөөцийн эрэлтийг тодорхойлдог. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан журмыг баримтлан Дотоод хэргийн их сургуулийн өдөр, эчнээ анги, гадаад улсын цагдаагийн сургуульд суралцуулах иргэн, алба хаагчийн захиалгыг жил бүр шинэчлэх, суралцагч нарыг элсүүлэхдээ гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан эсэх, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн болон бусад тусгайлсан шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг үнэлэх, Дотоод хэргийн их сургууль, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагатай хамтран судалж, суралцагчтай гурвалсан гэрээ байгуулах, гэрээнд сургууль төгссөний дараа төрийн тусгай албан тушаалын нөөцөд бүртгэж, тэргүүн ээлжид ажлын байраар хангах, суралцсан хугацаагаар цагдаагийн байгууллагад тогтвортой ажиллах, ажиллаагүй тохиолдолд сургалтын болон дүрэмт хувцасны төлбөр, сургалттай холбогдон улсаас гарсан бусад зардлыг нөхөн төлүүлэх талаар тус тус авч үзжээ.

Мөн гадаад улсын их, дээд сургуульд боловсролын зэрэг олгох болон гадаад хэлний сургалтад өөрийн зардлаар суралцахад хууль, журамд нийцүүлэн дэмжлэг үзүүлэх, тухайн алба хаагчтай сургалтын гэрээ байгуулж, сургалтын үр дүнг үндэслэн ажлын байранд томилох, цагдаагийн байгууллагад шаардлагатай байгаа нарийн мэргэжил, мэргэшил /цэргийн техник, эмч, бага эмч, мэдээлэл, холбоо технологи, радио холбоо, программ хангамж, пиротехникийн мэргэжилтэн, хими, физик, уул уурхай, мэргэн буудагч/-ийн жагсаалтыг гаргаж, энэ чиглэлээр бусад их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, захиалга өгөх, сургалтын гэрээ хийх, амжилттай төгссөний дараа шаардлагатай албан тушаалд томилох зэргийг тусгажээ.

Албан тушаал дэвших тогтолцооны хувьд Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ын дагуу албан тушаалд шатлан дэвшүүлэх багц сургалтад хамруулан шалгалт авч, тэнцсэн тохиолдолд нөөцөд бүртгэхээр зохицуулсан боловч энэ шаардлагыг албан тушаал ахих гол шалгуурт авч үздэггүй нь сул тал болж байна. Өөрөөр хэлбэл, алба хаагч өөрийн мэдлэг, чадварыг

²⁰ <https://legalinfo.mn/>

хөгжүүлэх нь ирээдүйд өсөн дэвших боломж гэж үзэхгүй байгаа нь албан тушаалын томилгоо сургалт, ур чадварыг хөгжүүлсэн байдалд үндэслэхгүй байгаатай шууд холбоотой.

Албан тушаал дэвшүүлэхдээ иргэн, алба хаагчийн эзэмшсэн мэргэжил, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тодорхой чиглэлээр мэргэшсэн байдал, албан тушаалын тодорхойлолтод заагдсан тусгай шаардлага, удирдахуйн болон мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан эсэхийг харгалзан:

а/Алба хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ гурван удаа дараалан “А” буюу “Маш сайн” үнэлэгдсэн байх;

б/Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийг үнэлэх эрх бүхий албан тушаалтны үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналд албан тушаалд дэвшүүлэх зорилгоор багц сургалтад хамруулах санал тусгагдсан байх;

в/Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаагүй, холбогдон шалгагдсан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1-д заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон байх;

г/Сахилга, ёс зүйн хэм хэмжээ зөрчиж байгаагүй, зөрчил гаргасан боловч сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрсөн эсхүл шийтгэлгүйд тооцогдсон байх;

д/Ахлагчийн албан тушаалд 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа алба хаагчийг офицерын, цагдаагийн албан тушаалд томилогдоод 5-аас доошгүй жил, үүнээс офицерын албан тушаалд 2-оос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан алба хаагчийг ахлахын, цагдаагийн албан тушаалд томилогдоод 8-аас доошгүй жил, үүнээс ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын чиглэлийн ахлахын болон хэсэг, тасгийн даргын албан тушаалд;

е/Цагдаагийн албан тушаалд томилогдоод 12-оос доошгүй жил ажилласан үүнээс чиглэлийн ахлах, хэсэг, тасгийн даргын болон түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг хэлтсийн даргын, цагдаагийн албан тушаалд томилогдоод 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс хэлтсийн дарга, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг газрын болон албаны даргын албан тушаалд томилохоор тус тус зохицуулжээ.

Удирдах албан тушаалтныг томилохдоо цагдаагийн албанд ажилласан жил, ажлын туршлага, боловсрол, мэдлэг чадвар, харилцааны ур чадвар, ёс зүйн төлөвшил, манлайлал, нөөцөд бүртгэгдсэн эсэх, шалгалтын оноо зэрэг тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хамгийн их хангаж байгаа алба хаагчийг сонгон томилохоор тусгажээ.

Бид энэ зохицуулалтад үндэслэн тогтолцооны загвар болон сургалтад баримтлах үзэл баримтлал, сургалтын давтамж, ахиж, дэвших боломж, шалгууруудыг санал болгож байгаа билээ. Тэдгээр шалгуурын гол үндэслэх шинж чанар нь алба хаагч өөрийгөө хөгжүүлэх, мөн албадлагаар сургалтад хамруулах үзэгдлийг багасгах талаар зохицуулалтыг тусгасан.

3.4. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан эрх зүйн акт:

➤ “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”²¹

Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл бусад онцлогийг харгалзан Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны болон автомашин, тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативыг баталсан. Уг тогтоолын дагуу 4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч, 15000 хүн ам тутамд 2-оос доошгүй хэв журмын эргүүл, 350 тээврийн хэрэгсэл тутамд 1-ээс доошгүй замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагч, 150 км тутамд 1-ээс доошгүй орон нутаг дахь замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух цагдаагийн хяналтын цэг, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд үүрэг бүхий алба хаагч нийт орон тооны 75-аас доошгүй хувийг эзэлнэ, хөдөлгөөнт эргүүлд 15000 хүн ам тутамд 1-ээс доошгүй, сум дахь цагдаагийн алба хаагчид 1-ээс доошгүй автомашин байхаар тус тус заасан боловч улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалан цагдаагийн байгууллагын одоогийн бүтэц, орон тоо, ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн тоо энэхүү жишиг нормативд хүрэхгүй, 4000 орчим орон тоогоор бага байгаа нь алба хаагчдын хөдөлмөрлөх эрх зөрчигдөх, эрүүл мэндээр хохирох нөхцөлийг бий болгож байгаа талаар Хүний эрхийн үндэсний комиссоос Улсын Их Хуралд хүргүүлсэн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлд дурдсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална” гэж заасныг үндэслэн дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг харгалзан Цагдаагийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Алсын хараа-2050”-д нийцүүлэн “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан бөгөөд цагдаагийн байгууллагын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, удирдах албан тушаалтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийх замаар үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй, дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэхэд чиглэсэн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлсон бодлогын баримт бичиг юм.

Энэхүү хөтөлбөрийн зорилгод Монгол Улсын цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, ур чадвар, чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар авч үзсэн бол дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Бидний судалгааны ажилд хамаарах хэд хэдэн зорилтуудыг дэвшүүлсэн хэдий ч үр дүн нь төдийлөн биелээгүй байх нийтлэг ажиглагдлаа. Тухайлбал, хүний нөөцийн үйл ажиллагаа, эрх зүйн актуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн баталж, мөрдүүлэх, цагдаагийн байгууллагад анх орох иргэнээс авах сонгон шалгаруулалт (ерөнхий шалгалт)-ын үйл ажиллагаанд судалгааны болон техник, технологийн

²¹ Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоол

дэвшилтэт арга аргачлалыг нэвтрүүлэх, хүний нөөц, сургалт хариуцсан албан тушаалтнуудыг мэргэшүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, байнга хөгжүүлэх, хүний нөөцийн мэдээллийн цахим системийг боловсронгуй болгож, ашиглах, сургалтын шинэ тогтолцоог нэвтрүүлж, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэх, сургалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, бүсчилсэн сургалтын 2 төвийг шинээр байгуулах, албаны сургалтын агуулга, технологийг шинэчилж, чадамжид суурилсан сургалтын үйл ажиллагаа явуулах, мэргэжлийн өндөр ур чадвартай, заах арга зүй эзэмшсэн сургагч багшийг бэлтгэж, ажиллуулах, алба хаагчийн сэтгэл зүйн бэлтгэл, бие бялдрын хөгжлийг сайжруулж, дасан зохицох, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зэргийг дурдаж болно.

Засгийн газраас цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг баталсан бөгөөд хөтөлбөрийн нэг зорилтод цагдаагийн байгууллагын алба хаагчийг хөгжүүлэх, ур чадварыг ахиулах, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх талаар тусгасан нь цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдлыг сайжруулах хэрэгцээ, шаардлага бий болсныг илтгэнэ.

Мөн ажлын байрны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байгаа алба хаагч, ажилтныг тогтвортой ажиллах, дэвших боломжоор хангаж, цагдаагийн албанд төрийн албаны чадахуйн (мерит) тогтолцоог төлөвшүүлэх нь сургалт, түүнтэй холбогдох бусад үйл ажиллагааг боловсронгуй болгох гол шалтгаан юм.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт цагдаагийн алба хаагчийн сургалт, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр таван заалт байгааг бид түүвэрлэн авч хэрэгжилтэд ажиглалт хийж дүгнэлээ.

Хүний нөөцийн харьцааны хувьд офицер, ахлагч бүрэлдэхүүний дунд ажлын байрны сул орон тоо их байгаа нь түүнийг нөхөн хангах, шинээр ажиллах алба хаагчдын ачаалалд шууд нөлөөлж байна.

Цагдаагийн алба хаагчийн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрүүд агуулгын давхцалтай, тус тусдаа бүрэлдэхүүн сургуультай, давтан сургах, мэргэшүүлэх сургалт нь сургалтын нэгдсэн хөтөлбөргүй байгаа нь судалгаагаар батлагдаж байна.

Удирхал албан тушаалтныг бэлтгэх, ажилтан, алба хаагчийн тогтвортой ажиллах, дэвших боломж нь сургалтын үр дүнтэй уялддаггүй зэрэг нөхцөл байдал нь цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн дээрх заалтуудыг хэрэгжилтийг ямар түшинд байгааг хангалттай илтгэж байна.

3.5. Үйл ажиллагааны журам, заавар, тушаал

Цагдаагийн алба хаагчийн сургалт, түүнтэй холбогдох үйл ажиллагааны журам, заавар, тушаалыг Хууль зүй дотоод хэргийн сайд, ЦЕГ-ын дарга, ДХИС-ийн захирал дангаар болон хамтарсан байдлаар батлан хэрэгжүүлж байгаа нь практикт ашиглагдаж байна. Эдгээр эрх зүйн актуудаас түүвэрлэн хэрэгжиж буй байдлаар нь авч үзлээ.

Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх, галт зэвсэг хэрэглэх, харуул, хамгаалалтын үйл ажиллагааг гүйцэтгэх үйл ажиллагаа нь өдөр тутмын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой төдийгүй алба хаагч бүрийн тогтмол дадал олох чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай сургалтын чиглэл гэж үзэж болох юм.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын үйл ажиллагааг нэлээдгүй журмаар зохицуулж, хэм хэмжээний хувьд тусгалаа олсон ч хэрэгжилт дутмаг байгаа нь ажиглагдаж байна.

Хүснэгт 9. Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон хамтран баталсан эрх зүйн акт

1	“Олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах зардлын тооцоо” ЦЕГ-ын даргын 2014 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 485 дугаар тушаал
2	“Ёс зүйн төлбөртэй сургалтын хөтөлбөр баталж, төлбөрийн жишиг хэмжээг тогтоох тухай” ЦЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/99 дүгээр тушаал
3	“Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журам” ЦЕГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/210 дугаар тушаал
4	“Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам” ЦЕГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/211 дүгээр тушаал
5	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай”

Хүснэгт 10. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын жагсаалт

1	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /код 118/ журам”
2	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/262 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх /код 239/ журам”
3	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/267 дугаар тушаалаар баталсан “Албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамруулах, шалгалт авах, нөөцөд бүртгэх, дэвшүүлэн томилох /код 909/ журам”
4	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/157 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн мэргэжлийн сургуулийн сонсогчийн дадлагын /код 945/ журам”
5	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчийг мэргэжлийн зэргийн сургалтад хамруулах, шалгалт авах /код 948/ журам”
6	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах /код 951/ журам”
7	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам”
8	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Сургагч-багшийг бэлтгэх, чадавхижуулах, үнэлэх /код 950/ журам”

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, сургах үйл ажиллагаатай холбоотой журмуудаас онцлох заалтуудыг түүвэрлэн авч, эрх зүйн зохицуулалтыг товч тайлбарлах нь хууль, бусад эрх зүйн актуудын давхардал, хийдэл, үл зохицол байгаа эсэх, хэрэгжилтийн түвшнийг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаас сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалт явуулах үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилготой гэж журамласан ба Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/211 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн

мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам”, мөн даргын 2017 оны А/99 дүгээр тушаалаар батлагдсан “Ёс зүйн төлбөртэй сургалтын хөтөлбөр” болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

Энэхүү журам нь дараах үндсэн чиглэлүүдтэй:

а/хүний нөөцийн сургалт, хөгжлийн урт, богино хугацааны стратеги, бодлого, чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх;

б/иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, харуул, хамгаалалтын ажилтан бэлтгэх, олон нийтийн цагдаа бэлтгэх анхан болон давтан сургалтын стандарт, хөтөлбөрийг баталж, мөрдүүлэх;

в/цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн дээд /бакалавр/ боловсролтой, мэдлэг, ур чадвартай алба хаагчийг гадаад, дотоодын мэргэжлийн сургалтын байгууллагад захиалгаар бэлтгэх, сургалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

г/гадаад, дотоодын их, дээд сургуулийн бакалавр, магистр, доктор, адъюнктур, удирдах ажилтныг бэлтгэх сургалтад алба хаагчдыг суралцуулж, хөгжүүлэх;

д/гадаад, дотоодын тэтгэлэгт болон мэргэшүүлэх сургалтад алба хаагчийг суралцуулж, боловсролын зэргийг нь дээшлүүлж, хөгжүүлэх;

е/алба хаагчийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх бүтээлч санаачилгыг дэмжиж, тэдний өөрийгөө хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх.

Үүнээс үзвэл, энэхүү журам нь тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг хангах гол эрх зүйн акт бөгөөд хамрах хүрээндээ бүх шатны сургалт, бодлого, чиглэл, удирдлага, зохион байгуулалтыг авч үзсэн.

Мэргэжлийн боловсролын сургалт буюу анхан шатны сургалтыг цагдаагийн төв байгууллагын захиалгаар цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу өдрийн хэлбэрээр 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар зохион байгуулдаг.

Бакалаврын зэргийн боловсролтой алба хаагчийг цагдаагийн төв байгууллагын захиалгаар цагдаагийн ажилтан, төрийн тусгай чиг үүрэг бүхий алба хаагчийг бэлтгэх сургалтын тусгай зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын их, дээд сургууль, академид бэлтгэнэ гэж заасан нь Цагдаагийн албаны тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дах хэсэгт “Цагдаагийн байгууллагад шаардлагатай нарийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор иргэнтэй гэрээ байгуулан дотоод, гадаадын боловсролын байгууллагад сурган, цагдаагийн албан тушаалд томилж болно” гэсэн заалттай агуулгаараа нийцэж байгаа хэдий ч тус хуульд зөвхөн нарийн мэргэжлийн гэж тодотгосон нь журмаас зөрүүтэй байгаа юм.

Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж нь цагдаагийн мэргэжлийн бакалаврын боловсролтой алба хаагчийн ажиллах ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусгагдсан мэдлэг, ур чадвар, хандлагад тавигдах шаардлагыг

харгалзан захиалгаар бэлтгүүлэх мэргэжлийн чиглэл, индексийн талаар холбогдох байгууллагад санал өгөх, мэргэжлийн тодорхойлолтыг сургалтын байгууллагатай хамтран боловсруулах, сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох саналаа холбогдох сургалтын байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ гэж журамд заасан хэдий ч хэрэгжилт нь тааруу байгааг судалгаагаар тогтоосон.

Тухайлбал, цагдаагийн мэргэжлийн бакалаврын хөтөлбөр, индекс, мэргэжлийн нэршил хэд хэдэн удаа өөрчлөгдсөн бөгөөд өнөөгийн байдлаар БШУЯ-наас баталсан үндсэн индекс нь аюулгүй байдлын бакалаврын чиглэлээр суралцуулж, бэлтгэж байна. Өмнө нь 2016-2018 онуудад хууль сахиулагч гэсэн мэргэжлийн нэршилээр төгссөсөн нь цагдаагийн байгууллагын ажлын байрны тодорхойлолттой нийцэхгүй байсан нь тогтоогдож байна.

Тус журмын 118.6.6-д “Өмнөх боловсролын зэргийн сургалт төгссөнөөс хойш 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, суралцах эрхийн бичиг авсан цагдаагийн алба хаагчийг гадаад, дотоодын их, дээд сургууль, академийн магистр, докторантур, адъюнктурт элсүүлэн суралцуулна” гэж заасан нь Цагдаагийн албаны тухай хуулийн 66.3.Цагдаагийн байгууллага цагдаагийн алба хаагч бүрд мэргэжлээрээ суралцах, албан тушаал дэвших тэгш боломж, нөхцөл бүрдүүлнэ гэсэн заалттай зөрчилдөж байна.

Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллагын сургалтын бодлогыг боловсруулах, мөрдүүлэх, алба хаагч, ажилтныг сургаж, бэлтгэх, байгууллагын соёл, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана гэж журамд заасан хэдий ч цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллагаас удирдлага, зохион байгуулалтын хувьд тус тусдаа бие даасан шинжтэй байна.

Цагдаагийн төв байгууллагын ”Сургалт арга зүйн зөвлөл”-ийг Иргэний зөвлөлийн гишүүн, Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын төлөөлөл болон Мэдээлэл нэгтгэн боловсруулах ажил хариуцсан нэгж, Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж, цагдаа, дотоодын цэргийн сургалт хариуцсан нэгжийн дарга нар болон бусад алба хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулж, үйл ажиллагаа явуулах талаар заасан боловч практикт тийм ч үр дүнтэй хэрэгжихгүй байна.

Цагдаа, дотоодын цэргийн сургалт хариуцсан нэгж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага бүр цагдаагийн мэргэжлийн бэлтгэл, албаны сургалтын явц, үр дүнгийн тайлан, алба хаагчдын мэдлэг, ур чадварын түвшнийг тогтоосон мэдээг хагас, бүтэн жилээр цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгжид хүргүүлнэ. Эндээс үзэхэд сургалтын үйл ажиллагааны үр дүнг дүгнэх бус тодорхой тайлан мэдээнд тохируулан гүйцэтгэлийг үнэлдэг нь холбогдох журам, албаны тайлан мэдээгээр нотлогдож байна.

Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх журам нь их, дээд болон Ахлагчийн мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв, дамжаа төгсөж, шинээр томилогдсон алба хаагчдад мэргэжлийн ур чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгдсэн ажлын байрны сургалтыг зохион байгуулах дэг горимыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

Шинээр томилогдсон алба хаагчид 16-аас доошгүй долоо хоногийн ажлын байрны сургалтыг амжилттай төгссөн байх ёстой. Өөрийн ажиллаж байсан албан тушаалаас өөр мэргэшил шаардсан албан тушаалд шилжсэн алба хаагчид зориулсан сургалтын хугацааг тухайн алба хаагчийн ажлын гүйцэтгэл, туршлагын түвшнээс хамаарч 8-аас доошгүй 7 хоногоор явуулдаг.

Албан тушаал дэвшүүлэн томилох алба хаагчдын сургалтыг албан тушаал дэвшүүлэн томилох алба хаагчдын материалыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор нөөцийн сангийн дэд бүтэц, төрөл, ангиллын дагуу хуваарилж, зайны болон танхимын сургалтын хэлбэрээр зохион байгуулах бөгөөд сургалтын нийт үргэлжлэх хугацаа 3 хоногоос хэтрэхгүй байна.

Цагдаагийн сургуулийн болон мэргэжлийн сургалтад хамрагдаж буй сонсогчдын дадлагын сургалтыг их, дээд сургууль болон цагдаагийн төв байгууллагын хамтарсан дадлагын удирдамжаар зохицуулдаг.

Алба хаагчийг мэргэжлийн зэргийн сургалтад хамруулах, шалгалт авах журам нь цагдаагийн алба хаагчийн хууль эрх зүйн мэдлэг, цахим сан, хэрэглээний программ хангамжийн ашиглалт, сэтгэн бодох чадвар, оновчтой шийдвэр гаргах ур чадвар, бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлт, түүнтэй холбогдох зохицуулалтыг авч үзсэн боловч сургалтын үйл ажиллагаа огт тусгагдаагүй тул тус журмын нэршлийг өөрчлөх шаардлагатай.

Алба хаагчийн үргэлжилсэн сургалтын журамд цагдаагийн алба хаагчийн жил бүр хангах шаардлагатай сургалтын төрөл, багц цагийг нарийвчлан тогтоосон хэдий ч давхардал, зөрүү ихтэй байна.

Хүснэгт 11. ДХИС-ийн үйл ажиллагааны зарим журам

1	Сургалтын хөтөлбөр батлах журам Ж.201.01
2	Хичээлийн хөтөлбөр батлах журам Ж.201.02
3	Ахлагчийн сургуулийн элсэлт зохион байгуулах журам Ж.202.01
4	Бакалаврын сургалтын элсэлт зохион байгуулах журам Ж.202.02
5	Магистр, докторын элсэлт зохион байгуулах журам Ж.202.03
6	Мэргэжлийн сургалт зохион байгуулах журам Ж.203.01
7	Бакалаврын боловсролын сургалт зохион байгуулах журам Ж.203.02
8	Магистр, докторын сургалт зохион байгуулах журам Ж.203.03
9	Дадлагын сургалт зохион байгуулах журам Ж.203.04
10	Шалгалт зохион байгуулах журам Ж.203.05
11	Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл ажиллах журам Ж.203.06
12	Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл ажиллах журам Ж.203.07
13	Захиалгат сургалт зохион байгуулах журам Ж.203.09
14	Цахим сургалт зохион байгуулах журам Ж.203.10
15	Багшлах эрхийн сургалт зохион байгуулах журам Ж.203.12
16	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах журам Ж.203.13

Дотоод хэргийн их сургуулийн сургалтын үйл ажиллагааны зохицуулалт

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх сургалтын холбогдох эрх зүйн актад ДХИС-ийн сургалтын үйл ажиллагаатай холбоотой журмууд зүй ёсоор орно.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага батлах тухай А/174 дүгээр тушаалын дагуу мөн сайдын 2014 оны “Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” А/370 дугаар тушаалын дагуу нийтлэг шаардлагад тус тус нийцүүлдэг.

Хичээлийн хөтөлбөр гэж тухайн хичээлээр оюутны мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг эзэмшүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжүүлэх багш, үнэлэх арга зүй, хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон баримт бичиг юм. Цагдаагийн алба хаагчийг аль ч түвшинд бэлтгэх сургалт нь ДХИС-ийн харьяанд бий. Тус сургуулийн журмаар хичээлийн хөтөлбөрийг бүрэлдэхүүн сургууль, тэнхим хариуцан бэлтгэж, хөтөлбөрийн дэд хороо үнэлгээ хийж, бүрэлдэхүүн сургуулийн захирал батлахаар зохицуулсан.

Ахлагчийн сургуулийн элсэлтийн хувьд ЦЕГ-ын төрийн албаны салбар зөвлөлөөс цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын байрны орон тоон дээр ажиллуулахаар зарлагдсан сонгон шалгаруулалтад тэнцэж, ЦЕГ-ын даргын тушаалаар баталгаажуулан нэр бүртгэгдсэн иргэдийг ДХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж, мэргэжлийн сургалтад хамруулдаг.

Бакалаврын сургалтын элсэлтийг тухайн хөтөлбөрийн эрэлт, захиалагч байгууллагын захиалгын хүрээнд их сургуулийн захирлын тушаалаар баталсан хяналтын тооны хүрээнд зохион байгуулдаг.

Магистр, докторын сургалтын элсэлтийн хувьд бүрэлдэхүүн сургуулийн захирал тухайн хөтөлбөрт элсүүлэн суралцах суралцагчийн хяналтын тооны саналаа элсэлтийн комисст хүргүүлдэг. Үүний дагуу элсэгчид шалгалтад хамрагддаг.

Мэргэжлийн, бакалаврын, магистр, докторын сургалтыг их сургуулийн баталсан журмын дагуу зохион байгуулдаг бөгөөд сургалтын арга зүй, хөтөлбөр, төлөвлөгөөг тэнхим хариуцдаг.

Үүнээс үзвэл, захиалагч байгууллага буюу ЦЕГ-тай тухайн байгууллагын сул орон тооны захиалгад үндэслэн элсэлт зохион байгуулах, дадлагын сургалтыг хамтран зохион байгуулах, төгсөгчдийг хүлээлгэн өгч, томилолт хийх зэрэгт практик байгууллага, сургалтын байгууллагын хамтын ажиллагаа хэрэгжиж байгаа бол сургалтын үйл ажиллагаа, төлөвлөлт, хэрэгжилтэд зөвхөн бүрэлдэхүүн сургууль, тэнхим дангаар хариуцан ажиллаж байна.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллагаас цагдаагийн алба хаагчийн сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж буй хууль, эрх зүйн актуудыг сургалтын түвшний ангиллаар ангилж авч үзлээ.

Хүснэгт 12. Цагдаагийн анхан шатны сургалтад хэрэглэж буй хууль, эрх зүйн актууд

№	Субъект	Хууль, эрх зүйн акт
1	УИХ	Төрийн албаны тухай хууль 2017
2		Цагдаагийн албаны тухай хууль
3	МУЕЗ	Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд 2019

4	БШУЯ	Боловсролын ерөнхий хууль
5	ХЗДХЯ	Дотоод хэргийн их сургуулийн дүрэм
6	ХНХЯ	Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль
7	ДХИС	Сургалтын үйл ажиллагааны журам

Цагдаагийн анхан шатны сургалт буюу мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, ДХИС-ийн дүрэм, үйл ажиллагааны журам гэсэн хууль, эрх зүйн баримт бичгүүд үйлчилж, сургалтын үйл ажиллагааг зохицуулж байна.

Энэ сургалт нь мэргэжлийн диплом олгодог тул мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулагддагаараа онцлогтой. Цагдаагийн байгууллагын нийт алба хаагчдын 50 хувь буюу 5043 алба хаагч ахлагч бүрэлдэхүүнд ажиллаж байгаа нь энэ сургалт ямар их ач холбогдолтойг бататгаж байна. Учир нь нийт алба хаагчдын тал хэсгийг бүрдүүлэхэд тус сургалт хувь нэмрээ оруулж байгаа нь цаашлаад цагдаагийн байгууллагыг үнэлэх үнэлэмжид нөлөөлөх нөлөө их болохыг харуулж байна.

Хүснэгт 13. Бакалаврын шатны сургалтад хэрэглэж буй хууль, эрх зүйн актууд

№	Субъект	Хууль, эрх зүйн акт
1	УИХ	Боловсролын ерөнхий хууль
2		Дээд боловсролын тухай хууль
3	ХЗДХЯ	Дотоод хэргийн их сургуулийн дүрэм
4	ДХИС	Сургалтын үйл ажиллагааны журам
5		Сургалтын хөтөлбөр батлах журам
6		Хичээлийн хөтөлбөр батлах журам
7		Бакалаврын сургалтын элсэлт зохион байгуулах журам
8		Бакалаврын боловсролын сургалт зохион байгуулах журам
9		Дадлага сургалт зохион байгуулах журам
10		Клиник сургалт зохион байгуулах журам
11		Шалгалт зохион байгуулах журам
12		Цахим сургалт зохион байгуулах журам
13		Цэргийн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах журам
14		Төгсөлтийн бичиг баримт бүрдүүлэх журам

Цагдаагийн дээд боловсролтой алба хаагчдыг бэлтгэж буй сургалт бол ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн хэрэгжүүлж буй сургалт юм. Тус сургалтыг Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хуулиас гадна ДХИС-ийн дүрэм, Сургалтын үйл ажиллагааны журам, Сургалтын хөтөлбөр батлах журам, Хичээлийн хөтөлбөр батлах журам, Бакалаврын сургалтын элсэлт зохион байгуулах журам, Бакалаврын боловсролын сургалт зохион байгуулах журам, Дадлага сургалт зохион байгуулах журам, Клиник сургалт зохион байгуулах

журам, Шалгалт зохион байгуулах журам, Цахим сургалт зохион байгуулах журам, Цэргийн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах журам гэсэн хууль, эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулж байна.

Хүснэгт 14. Магистр, докторын шатны сургалтад хэрэглэж буй хууль, эрх зүйн актууд

№	Субъект	Хууль, эрх зүйн акт
1	УИХ	Боловсролын ерөнхий хууль
2		Дээд боловсролын тухай хууль
3	БШУЯ	Магистр, докторын сургалтын нийтлэг журам
4	ХЗДХЯ	Дотоод хэргийн их сургуулийн дүрэм
5	ДХИС	Сургалтын үйл ажиллагааны журам
6		Сургалтын хөтөлбөр батлах журам
7		Хичээлийн хөтөлбөр батлах журам
8		Магистр, докторын элсэлт зохион байгуулах журам
9		Магистр, докторын сургалт зохион байгуулах журам
10		Цахим сургалт зохион байгуулах журам
11		Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл ажиллах журам
12		Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл ажиллах журам
13		Шалгалт зохион байгуулах журам

Цагдаагийн алба хаагчийн магистр, докторын шатны сургалт нь албан сургалт биш боловч тодорхой зарим албан тушаалд магистрын зэрэг шаарддаг нөгөөтээгүүр алба хаагчид өөрсдийгөө хөгжүүлэх, мэдлэг, боловсролын түвшнийг дээшлүүлэхэд анхаарч байгаа нь цагдаагийн байгууллагын хүний нөөцийг чанаржуулахад чухал ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж нь Цагдаагийн байгууллагын захиалгаар цагдаагийн мэргэжлийн сургалт болон гадаад, дотоодын их, дээд сургууль, академийн дээд мэргэжлийн боловсрол /бакалавр, магистр, доктор, удирдах ажилтан бэлтгэх/-ын зэргийн сургалтад суралцаж байгаа иргэн, алба хаагчтай сургалтын гэрээ байгуулан, суралцуулж, төгсөгчдийг ажлын байраар хангана гэж заасан. Энэ нь цагдаагийн алба хаагчдын магистр, докторын сургалт зөвхөн тус их сургуулиар хязгаарлагдахгүйг илтгэж байна.

Хүснэгт 15. Цагдаагийн албаны болон давтан мэргэшүүлэх сургалтад хэрэглэж буй хууль, эрх зүйн акт

№	Субъект	Хууль, эрх зүйн акт
1	УИХ	Төрийн албаны тухай хууль
2		Цагдаагийн албаны тухай хууль
3	ЦЕГ	Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх журам
4		Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх журам
5		Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах журам
6		Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам

Цагдаагийн алба хаагчийн ажлын байрны болон албаны үйл ажиллагаа, ур чадварыг нэмэгдүүлэх, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэхэд албаны болон давтан мэргэшүүлэх сургалт чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тус сургалтын үйл ажиллагааг Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх журам, Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх журам,

Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах журам, Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам зэрэг хууль, эрх зүйн баримт бичгүүд зохицуулж байна.

Тогтвортой хөгжил, тасралтгүй боловсролын зарчмыг баримтлахад энэ сургалт нь хамгийн өндөр ач холбогдолтой. Цагдаагийн алба хаагчид төрөл бүрийн алба, нэгжид хуваарилагдан ажиллах, шилжин томилогдох, албан тушаал ахих зэрэгт түүндээ мэргэших, түргэн хугацаанд дасан зохицох, хууль, дүрэм, журмын биелэлтийг хангах, сахиулах нь төрийн албаны үйл ажиллагааны чанарт шууд нөлөөтэй.

Цагдаагийн алба хаагчийг гадаадын их, дээд сургуульд бэлтгэдэг нэг хүчин зүйл нь Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөр, хамтын ажиллагаатай шууд холбоотой байдаг. Тухайлбал, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6-д “Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын мэргэжил, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, сургалтын материаллаг баазыг сайжруулах арга хэмжээ авна” хэмээн заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 45 тоот тушаалаар батлагдсан “Гадаадын их, дээд сургуульд цэрэг, цагдаагийн алба хаагчийг сонгон шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2009-2010 оны хичээлийн жилд ЦЕГ, ПШГЕГ, ПШПҮХ-ээс ОХУ-ын Дотоод явдлын яамны харьяа их, дээд сургуульд суралцах сонсогчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 53 суралцагч элсүүлсэн байна.²² Сүүлийн жилүүдэд энэ тоо улам өсөх хандлагатай байна.

Үүнээс үзвэл, цагдаагийн алба хаагчийн сургалтын чиглэлээр тус тусдаа хөгжүүлэх алхмуудыг хийж байгаа байдал илэрч байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалтын хувьд маш олон хэм хэмжээг бүрдүүлсэн боловч хэрэгжилт дутмаг байна.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын чиглэлээр эрх зүйн хэм хэмжээний актуудаас түүвэрлэн авч, тэдгээрийн хэрэгжилт, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог харуулахаар зорьсон.

Хүний эрх түгээмэл тунхаглал, НҮБ-аас баримталдаг бодлого конвенц, түүний үзэл баримтлалд манай орны Үндсэн Хуульд нийцсэн байдаг нь боловсролын тэгш хүртээмж, алагчлахгүй байх зэрэг ойлголтыг тусгасан зэргээс харж болно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд бидний судалгааны сэдвийн хүрээнд сурч боловсрох эрх болон цагдаагийн байгууллагын чиг үүргийн үндсийг тусгасан байдаг.

Харин Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль зэрэг боловсролын талаарх эрх зүйн хэм хэмжээг тогтоосон хууль тогтоомжид цагдаагийн алба хаагчийн дээд боловсролын сургалтыг үнэ төлбөргүй байхаар зааснаас гадна сургалтыг зохион байгуулах байгууллага, бүтэц, тогтолцооны талаар нээлттэй буюу салбар хуулиар зохицуулахаар тусгажээ.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын хувьд мэргэжил олгох, боловсролын зэрэг дээшлүүлэх, албаны буюу ажлын байрны, давтан мэргэшүүлэх сургалтууд нь тус тус хууль, эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичгийн хүрээнд зохион байгуулагдаж байна.

²² Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

Эдгээр сургалтууд нь Боловсролын ерөнхий хуульд тулгуурлан ерөнхий чанар, стандартыг хангах шаардлагатайгаас гадна цагдаагийн байгууллагаас тавих ажил, үүргийн шаардлагад давхар нийцэх шаардлагатай юм.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулагчийг тогтмол сургалтад хамруулж, тэдгээрийн мэргэшсэн чиглэлийг үндэслэл болгон ахиж дэвших байдлыг хангах талаар зохицуулсан нь бидний судалгааны сэдвийн хүрээнд хамаарах гол заалт юм.

Үүний нэгэн адил Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагч бүрийг суралцах, хөгжих боломжоор хангаж, тэдний ахиж дэвших үзүүлэлт нь мэдлэг, чадвар байх зохицуулалтыг тусгасан байгаа нь ижил буюу давхацсан шинжтэй боловч практикт хэрэгжилт сул, ахиж, дэвшсэн байдлыг үнэлэх үнэлгээ, хяналтын тогтолцоо хөгжөөгүй нь цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Үүний учир шалтгааныг судалж үзвэл, цагдаагийн алба хаагчид мэргэжил олгох сургалт нь нэг талаасаа практик байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцсэн төгсөгчийг бэлтгэхээс гадна нөгөө талаасаа мэргэжлийн боловсролын зэрэг эзэмшихдээ боловсролын чанар, стандартад нийцсэн сургалтад хамрагдах хэрэгтэй. Энэ нь аль аль талын стандартад нийцэхдээ нэг нэгнээ үгүйсгэх, зөрчилдөх магадлалтай юм. Тухайлбал, цагдаагийн алба хаагчийг бакалаврын түвшинд эрх зүйч мэргэжлээр бэлтгэх нь практик байгууллагын хэрэгцээнд нийцэж байгаа боловч ЮНЕСКО-ийн зөвлөмж, түүнд нийцүүлж гаргасан мэргэжлийн индексийн ангилалд тохирохгүй байгаа юм.

Төрийн албаны тухай хуулиар төрийн алба хаагчийн сургалт, дараа дараагийн эрэмбэ, шатлалаар дээд түвшний түшмэлийн зэргийн болзлыг хангах талаар нэгдсэн зохицуулалттай төдийгүй Засгийн газрын агентлаг сургалтыг хариуцан явуулж байна. Энэ нь тухайн алба хаагчийн хэрхэн мэдлэг, чадвар, хандлагаа ахиулсныг хянах, үнэлэх жишгийг тогтоон хэрэгжүүлж байгаа тод жишээ төдийгүй цагдаагийн байгууллага нь төрийн тусгай байгууллага тул алба хаагчдын сургалтыг зохион байгуулах, үр дүнг үнэлж, байгууллагын чанарт ахиц, дэвшил нэвтрүүлэх шаардлага бий болсон.

Нөгөөтээгүүр Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн сургалтын байгууллага, сургалтын ангилал, тогтолцоог ойлгомжгүй байдлаар тусгаж, сургалтын нэгж гэхээс илүү төвүүд байгуулж болно гэж заасан нь учир дутагдалтай байна.

Үүнээс улбаалан цагдаагийн алба хаагчийн сургалтыг зохицуулж буй журмууд хэт олон бөгөөд ойлгомжгүй, практикт хэрэгжиж үр дүнгээ өгдөггүй зохицуулалтууд маш олон байна. Тухайлбал, мэргэжлийн бэлтгэл, давтан, мэргэшүүлэх сургалт нь дотроо ойролцоо утга бүхий маш олон сургалтуудыг агуулсан боловч хэрхэн зохион байгуулагддаг талаар авч үзээгүй нь сул тал болж байна.

Цаашид Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлого, Хөгжлийн хөтөлбөр зэргийг үндэслэл болгон хууль, эрх зүйн шинэчлэлд анхаарч, давхардал, хийдлийг арилган, сургалтын үйл ажиллагааны нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж, түүний дагуу алба хаагчийн сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох,

байгууллагуудын харилцан үйл ажиллагааг хангах, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх нь гол шийдэл болно гэж үзлээ.

Дээрх өгүүлснийг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Боловсролын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоод хэргийн их сургуулийн захирал дангаар болон хамтарсан байдлаар батлан хэрэгжүүлж байгаа эрх зүйн актууд нь цагдаагийн алба хаагчийн сургалт, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулж байна.

Үүнээс үзвэл, тээврийн цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх талаар алба хаагчийн сургалтын тогтолцоо, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн эх сурвалж, баримт бичиг, хууль тогтоомжууд хангалттай мэт байгаа боловч нэгдсэн тогтолцоог бүрдүүлээгүй, сургалтууд нь зөвхөн тухайн нэг үе шатны боловсролыг олгоход чиглэж байгаа нь хоорондын уялдаа, залгамж холбоог хангахгүй байх гол нөхцөл болж байна.

Тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалт, хүний нөөцийн бодлого, холбогдох дүрэм, журмуудын заалтууд агуулгын зөрчилтэй, хэрэгжилтийн зөрчилтэй байгаа нь эрх зүйн зохицуулалтын өнөөгийн нөхцөлд хийсэн дүн шинжилгээгээр тогтоогдож байна.

Иймд Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтууд, холбогдох журмын зарим зохицуулалтыг Төрийн албаны тухай хууль болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуультай нийцүүлэн өөрчилж, холбогдох журмуудад шинэчлэл хийх шаардлага тулгарч байна.

ДӨРӨВ. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТЫГ ЧАНАРЖУУЛАХ, СУДАЛГААНЫ АЖЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1. Тээврийн цагдаагийн алба хаагчдаас авсан санал асуулгын үр дүн

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хамгийн чухал үүрэг гүйцэтгэх алба хаагчид бол Замын цагдаагийн зохицуулагч, цагдаа зохицуулагч юм.

Тээврийн цагдаагийн албаны хэмжээнд өнөөдрийн байдлаар зохицуулагч, цагдаа зохицуулагч албан тушаалтай 331 алба хаагчтай.

Мөн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын замын цагдаагийн хэлтэс, тасаг, хэсэгт нийт 727 алба хаагчийн орон тоотойгоос сургуулийн чөлөө, ээлжийн амралт, өвчтэй чөлөөтэйг тооцохгүйгээр нийт 596 алба хаагчид гудамж замд хяналт шалгалт, хөдөлгөөн зохицуулалтын үүрэг гүйцэтгэж байна.


Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд үр дүнтэй, оновчтой зохион байгуулахад нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зохицуулагч, цагдаа зохицуулагч нар чухал үүрэг гүйцэтгэдэг.

Иймд гудамж замд үүрэг гүйцэтгэж буй замын цагдаагийн алба хаагч нараас “Google form” программыг ашиглаж дараах асуултуудаар алба хаагчдын мэргэжил, төгссөн сургууль, мэргэшлийн талаарх судалгааг хийсний үр дүнг танилцуулъя. Судалгаанд нийт 544 алба хаагч хамрагдсан.

График 6. Асуулт: Та тээврийн цагдаагийн албаны аль харьяалалд үүрэг гүйцэтгэдэг вэ?

Судалгаанд орон нутаг дахь Замын цагдаагийн тасгийн 266, дүүрэг дэх Цагдаагийн газрын замын цагдаагийн хэлтсээс 151, Тээврийн цагдаагийн албанаас 108 алба хаагч буюу зохицуулагч, цагдаа зохицуулагч албан тушаалын орон тоон дээр үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид хамрагдсан.

Та хаана ажилладаг вэ?
525 хариулт



Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 49 буюу 9.3 хувь нь 18-23, 90 буюу 17.1 хувь 24-28, 128 буюу 24.3 хувь нь 29-33, 165 буюу 31.4 хувь нь 33-38, 94 буюу 17.9 хувь нь 39-өөс дээш настай байна.

График 7. Асуулт: Алба хаагчийн насны ангилал

Та хэдэн настай вэ?
526 хариулт




График 8. Асуулт: Та зохицуулагчаар хэдэн жил ажиллаж байна вэ?

Замын цагдаагийн зохицуулагч, цагдаа зохицуулагчаар ажилласан хугацааны хувьд 134 буюу 25.9 хувь 0-1 жил ажилласан алба хаагчид байна.

Энэ нь 4 алба хаагч тутмын 1 нь туршлага багатай шинэ алба хаагчид гудамж талбай үүрэг гүйцэтгэж байна гэж дүгнэхээр байна.

Та зохицуулагч албан тушаалт томилогдоод хэдэн жил болж байгаа вэ?
518 хариулт





График 9. Асуулт: Та ямар албан тушаал эрхэлдэг вэ?

Алба хаагчдын албан тушаалын хувьд 267 буюу 51.2 хувь нь цагдаа зохицуулагч, 212 буюу 40.7 хувь зохицуулагч албан тушаалтай байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдсан 541 алба хаагчдын 90 гаруй хувь нь гудамж талбайд үүрэг гүйцэтгэж байгаа зохицуулагч, цагдаа зохицуулагч нар хамрагдсан байна.

Таны албан тушаал
521 хариулт



Замын цагдаагаар ажиллаж байгаа судалгаанд хамрагдсан 541 алба хаагчдаас 290 буюу 55.3 хувь нь эрх зүйч мэргэжилтэй, 82 буюу 15.6 хувь авто инженер мэргэжилтэй, 192 буюу 36.6 хувь бусад мэргэжилтэй алба хаагчид гудамж зам үүрэг гүйцэтгэж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд жолооч нарт хүргэж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/154 дугаартай албан тушаалын тодорхойлолтод зохицуулагч албан тушаалд эрх зүйч эсхүл авто инженер мэргэжилтэй алба хаагчдыг томилон ажиллуулна гэж заасан.


Гэтэл гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа зохицуулагч, цагдаа зохицуулагч нарын нарын 36 хувь нь дээрх шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна. Мөн цагдаа зохицуулагч албан тушаалын тодорхойлолтод эрх зүйч эсвэл авто инженер гэсэн босго тавьж өгөөгүй нь хяналт шалгалтын ажлыг сул явуулах, иргэдтэй зөрчилдөөн үүсгэх, цагдаагийн байгууллага, албаны нэр төрийг иргэд олон нийтэд сөрөг байдлаар харуулахад нөлөөлөх эрсдэлтэй.

График 10. Асуулт: Таны боловсролын зэрэг?

Судалгаанд хамрагдсан 541 алба хаагч бэлдсэн асуултад хариулсан байна.

Нийт алба хаагчдын 383 буюу 88 хувь нь бакалавр, 51 буюу 11.7 хувь нь магистрын зэрэг хамгаалж судалгааны ажил хийсэн байна.

Боловсролын зэрэг
435 хариулт



Цагдаагийн алба хаагч нар мэргэжил, мэдлэгээ дээшлүүлж магистр доктор болсноор мэргэшсэн алба хаагчид нэмэгдэж, албаны үйл ажиллагаатай холбоотой судалгааны ажил нэмэгдэх ёстой. Дээрх магистрын боловсролтой алба хаагчдын дунд дахин судалгаа хийлгэж магистрын ажлын судалгааны ажил нь тээврийн цагдаагийн албаны үйл ажиллагаанд ач холбогдолтой эсэхийг үзэж шаардлагатай судалгааг албаны үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай гэж үзэж байна.

График 11. Асуулт: Та ямар сургууль төгссөн бэ?

Судалгаанд хамрагдсан 541 алба хаагчдаас 194 буюу 42.3 хувь нь Дотоод хэргийн их сургууль /Хууль сахиулахын их сургууль, цагдаагийн академи/, 31 буюу 6.8 хувь Шинжлэх ухаан технологийн их сургуулийг, 216 буюу 49.5 хувь бусад сургуулийг тус тус төгссөн.

Таны төгссөн сургууль?
459 хариулт



Мэргэшсэн алба хаагч буюу замын цагдаагийн зохицуулагч албан тушаалтанд мэдвэл зохих мэдлэг, онол зүйн хичээл сургалтыг ДХИС, ШУТИС-д тодорхой хэмжээнд хязгаарлагдмал зааж бэлтгэдэг бол нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 2 хүн тутмын 1 нь хувийн сургууль төгссөн нь замын цагдаагаар ажиллаж байгаа алба хаагч нарын дунд мэргэшсэн алба хаагч дутагдалтай байгааг илтгэж байна.

График 12. Асуулт: Та ямар хэлбэрээр сургуулиа дүүргэсэн бэ?

Нийт судалгаанд хариулт өгсөн 541 алба хаагчдын 306 буюу 63.2 хувь өдрөөр, 157 буюу 32.4 хувь нь эчнээгээр, 21 буюу 4.3 хувь цахимаар буюу зайн сургалтад хамрагдаж замын цагдаагийн албанд ажиллаж байна.

Сургууль төгссөн хэлбэр?
484 хариулт





График 13. Асуулт: Танд замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс сэдвээр хичээл орж байсан уу?

Нутаг дэвсгэрт хариуцсан цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа замын цагдаагийн зохицуулагч, цагдаа зохицуулагч албан тушаалтай алба хаагчдын 38.6 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс сэдвээр хичээл сургалтад огт хамрагдаж байгаагүй гэсэн хариулт өгсөн байна.

Таныг сургуульд сурах үед замын хөдөлгөөний аюулгүй байдал үндэс сэдвээр хичээл сургалт орж байсан уу?
515 хариулт



Энэ нь гудамж талбайд үүрэг гүйцэтгэж байгаа 3 алба хаагч тутмын 1 нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, “Хүн, Автомашин, Зам, Орчин” бүхий системийн аюулгүй байдлын талаар онолын ямар нэгэн ойлголтгүй ажилладаг гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Судалгаанд хамрагдсан 541 алба хаагчдаас 515 алба хаагч нь энэхүү судалгааны асуултад хариулт өгсөн байна.

Зохицуулагч, цагдаа зохицуулагчаар бэлтгэгдэх үедээ техник, замын зохион байгуулалт, зам, замын байгууламжийн талаар огт сургалтад хамрагдаагүй 278 алба хаагч байна.

Нийт алба хаагчдын 54 хувь нь техник замын тухай мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй учир зам тээврийн ослын 97.8 хувь зөвхөн жолоочийн буруутай үйлдлээс болсон гэдэг дүгнэлт гаргах гол шалтгаан болж байгаа гэж дүгнэхээр байна.

АНУ-д зам тээврийн ослын 35 хувь, Европын улсуудад 28 хувь нь тус тус замын нөхцөл байдлаас шалтгаалдаг байхад манай улсад 0.2 хувь шалтгаалж байна.

Тэр тусмаа хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирсан зам тээврийн осол бүртгэгддэг улсын болон олон улсын чанартай авто замд, замын тэмдэг, тэмдэглэл, хайс хашлага, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэлд тавих хяналт бага, зам дээр үүссэн эвдрэлийг хариуцсан АЗЗА ТӨК-д албан мэдэгдэл хүргүүлж хариуцлага тооцож чадахгүй байгаагаас замын нөхцөл байдлаас шалтгаалсан зам тээврийн осолд жолоочийг буруутгасаар байна.

АЗЗА ТӨК-д хяналт тавьж зам засварын ажил хийлгэж чаддаггүй хамгийн энгийн жишээ: Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.5.5 “Зам, замын байгууламжийн засвар арчлалтыг стандартын дагуу хийгээгүйгээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад саад учруулж зам тээврийн осол, зөрчил гаргах нөхцөлийг бүрдүүлсэн, эсхүл зам тээврийн осол, зөрчил гарсан бол холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаар учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн хуулийн заалтын ашиглаж зам дээр үүссэн эвдрэлийг засаагүй байгууллагад арга хэмжээ тооцож байсан зохицуулагч огт байхгүй.

Иймд зохицуулагч албан тушаалтай алба хаагчдад мэргэшүүлэх сургалт орж замын зохион байгуулалт, зам, замын байгууламжид байх стандартуудыг судлуулж, зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тогтооход зам нөхцөл байдал нөлөөлсөн эсэхэд анхаардаг болгох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шалтгаан нөхцөлийг нарийн гаргах зорилгоор криминологи судалгааг алба хаагчид өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэрт хамгийн багадаа улиралд 1 удаа хийх ёстой.

Ингэснээр хариуцсан нутаг дэвсгэрийн аль замд, ямар цаг хугацаанд зам тээврийн осол гардаг, ихэвчлэн ямар хэлбэрээр зам тээврийн осол гарч байгаа, осолд холбогдсон жолооч нарын туршлага, нас, биеийн байдал, хүйс, осол гарсан өдөр зэргийн нарийн тогтоож, дараагийн саруудад тухайн зам дээр гарч болох зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ёстой хэдий ч анхаардаггүй.

Алба хаагчид эдгээр зүйлийг бүгд мэддэг юм шиг хэлээд яриад байдаг хэр нь ослын бүртгэлээ хараад тоо баримтаар нь график гаргаж, мэдээ боловсруулж дүгнэлт хийсэн баримт нотолгоо байхгүй тэгдэг, ингэдэг хэмээн ярих нь байдаг.

“Статистик худлаа хэлдэггүй” гэсэн үг байдаг. Иймд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага бүр криминологи судалгааг сайтар хийж сурах шаардлагатай байна.


Харамсалтай нь судалгаанд хамрагдсан алба хаагчдын 72.6 хувь нь криминологи судалгааг хийж байгаагүй гэсэн хариулт өгсөн байна.

Дээрх судалгааны асуултын хариулт нь хэдэн ч хариулт сонгох боломжтой байдлаар авсан.

Алба хаагчдын дунд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиож байгаа ажил арга хэмжээ нь цахим орчин мэдээлэл түгээх байдлаар 70.3 хувь, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах 35.8 хувь, жолооч нарт сурталчилгааны материал тараах ажлыг 56.8 хувь, зурагт хуудас, самбар байрлуулахыг 45.3 хувь, хяналт шалгалтыг эрчимжүүлэхийг 53.2 хувь, осол ихээр үйлдэж буй газарт хяналт шалгалт хийхийг 48.7 хувь, хурд хэмжиж ажиллахыг 54.1 хувь, замын аюултай хэсэгт тэмдэг тэмдэглэл тавих, замын эвдрэлийг засахыг 40.7 хувь хийж байна гэсэн хариултаудыг өгсөн байна.

График 14. Асуулт: Та зохицуулагчаар ажиллаж байх хугацаандаа мэргэшүүлэх сургалтад хэдэн удаа хамрагдсан бэ?

Зохицуулагчаар ажиллаж байх хугацаанд мэргэшүүлэх сургалтад хэдэн удаа хамрагдсан бэ?
503 хариулт



Зохицуулагч, цагдаагийн зохицуулагч албан тушаалаар ажиллаж байгаа алба хаагчид албан тушаалын тодорхойлолтоор мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх ёстой.

Гэвч судалгаанд хамрагдсан 503 алба хаагчдын 131 буюу 30 хувь нь огт мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байгаагүй, 141 буюу 28 хувь нэг удаа мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байсан гэх мэдээллийг өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас тээврийн хэрэгсэлд системчилсэн үзлэг хийх талаар 190 алба хаагч, зөрчил шалгалт ажиллагааны талаар 180, урьдчилан сэргийлэх чиглэлээр 167, зам, замын байгууламж техник хэрэгслийн ашиглалт стандартын талаар 169, гадаад хэлний сургалт 160 алба хаагч сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар шинээр гарч байгаа эрх зүйн хэм хэмжээ бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шинэчлэх шаардлагатай дүрэм журам, заавар зэргийг боловсронгуй болгох түүнийг жолооч бүр дагаж мөрдөх нөхцөл бололцоог хангах вакуум систем бий болгох талаар сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

4.2. Тээврийн цагдаагийн алба хаагчдын сургалтад нөлөөлж буй хүчин зүйлс

Дотоод хэргийн их сургуулийн 2021-2025 оны Хөгжлийн стратегийн хөтөлбөрийн “Нийгмийн болон захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн үүрэг гүйцэтгэх бүрэн чадамжтай эх оронч, бүтээлч, ёс зүйтэй мэргэжилтэн, судлаачийг бэлтгэнэ. Хүний эрх, шударга ёс, хуулийг дээдлэх хандлагыг суралцагч бүрд төлөвшүүлж, хууль сахиулах салбарын дэвшилд бодитой хувь нэмэр оруулах бүтээлч сэтгэлгээтэй, мэргэжлийн өндөр ёс зүй, чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ” гэсэн зорилтод тусгагдсан үндсэн агуулгыг дэмжин хэрэгжүүлэхийг зорьсон болно.

Тээврийн цагдаагийн алба хаагчийн мэдлэг, чадвар, хандлага нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид ямар хамааралтайгаар нөлөөлж байгааг илрүүлэх, цагдаагийн байгууллагын алба хаагчдаас тэдний мэдлэг, чадвар, хандлага нь албаны сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид ямар хамааралтайгаар нөлөөлж байгааг илрүүлэхээр нийгмийн шинжлэх ухаан болох боловсролын суурь онол, олон улсын судлаачдын судалгааны үр дүнд тулгуурлан судалгааны ажлын таамаглал, загвараа гаргасан.

Судалгаанд Цагдаагийн байгууллагын нийт 3240 алба хаагч, Цагдаагийн сургуулийн I-IV дамжааны 205 сонсогч, Ахлагчийн сургуулийн 86 сонсогч цахимаар оролцсон нь ангилан судлах, зарим үр дүнг харьцуулан судлах боломжийг бүрдүүлж өгсөн. Бид чанарын судалгааны SMART PLS-3.0 программыг ашиглан хэмжил зүйн, хамаарлын, олон хүчин зүйлийн, замын шинжилгээ хийхдээ Цагдаагийн алба хаагч, сонсогчдын хүрээнд өөрсдийн суралцах явцын үйл ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлсэд багтсан агуулгын дагуу сонсогч өөрийгөө үнэлэх байдлаар тухайн хүчин зүйлийн хувьсагчид сургалтын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, ямар хамааралтайг нотлох оролдлого хийж, үр дүнг нэгтгэлээ.


Өмнөх бүлгүүдэд авч үзсэн сургалтын үйл ажиллагаа, түүний онолын үзэл баримтлалд тулгуурлан түүнд нөлөөлөх хүчин зүйлийн уялдаа, хамаарлыг илтгэх загвар боловсруулж, судалгааны ажлын таамаглалд үндэслэн загварыг дараах байдлаар гаргав.

Таамаглал-а: Мэдлэг нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө.

Таамаглал-б: Ур чадвар нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө.

Таамаглал-в: Хандлага нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө.

Сонсогч, суралцагчдаас авсан судалгаа



Эхний судалгаанд Цагдаагийн сургуулийн 206 сонсогч, ахлагчийн сургуулийн 86 сонсогчийг хамруулсан ба чанарын судалгаагаар, хүчин зүйн шинжилгээ, хэмжил зүйн шинжилгээ, хамаарлын шинжилгээ, замын шинжилгээний боловсруулалт хийн үр дүнг гаргасан. Үүнд:

Зураг 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Тайлбар: know-мэдлэгийн менежмент; Skill-ур чадвар; Com-Хандлага; Tr ас-сургалтын үйл

ажиллагааны үнэлэмж

Хэмжилзүйн шинжилгээний үр дүн нь энэхүү судалгааны ажлын хамгийн чухал хэсэг бөгөөд судалгааны үр дүнг боловсруулах, харьцуулан шинжлэх, бататгах, дүгнэх хэсэг юм. Уг шинжилгээгээр далд хувьсагч бүр манлайлалд хэрхэн нөлөөлж байгааг харуулах ба, хүчин зүйл тус бүрийн үр дүнг гаргасан болно. Кронбах альфа буюу тогтвортой байдал нь далд хувьсагчдын багц үзүүлэлт хоорондоо хэрхэн уялдаатай байгааг илэрхийлнэ. Найдвартай байдлын хэмжүүрийг дараах томъёогоор тодорхойлон үр дүнг гаргасан.

$$\text{Томъёо №1.} \quad \alpha = \frac{N\bar{e}}{\bar{v} + (N-1)\bar{e}}$$

Томъёоны тайлбар: N -далд хувьсагчийн тоо, \bar{v} -дундаж дисперс, \bar{e} -дундаж ковариаци
Хүснэгт 16. Хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Ур чадвар	Skill-1	0.735	0.869	0.902	0.605
	Skill-2	0.789			
	Skill-3	0.754			
	Skill-4	0.785			
	Skill-5	0.808			
	Skill-6	0.792			
Мэдлэг	Know-1	0.797	0.858	0.894	0.587
	Know-2	0.837			
	Know-3	0.731			
	Know-4	0.655			
	Know-5	0.696			
	Know-6	0.860			
Хандлага	Com-1	0.855	0.943	0.955	0.780
	Com-2	0.851			
	Com-3	0.944			
	Com-4	0.867			
	Com-5	0.907			
	Com-6	0.870			
Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	Tr ac-1	0.867	0.958	0.967	0.829
	Tr ac-2	0.856			
	Tr ac-3	0.937			
	Tr ac-4	0.929			
	Tr ac-5	0.951			
	Tr ac-6	0.917			

Тайлбар: know-мэдлэгийн менежмент; Cog-танин мэдэхүй; Skill-ур чадвар; Com-дадал, арга, барил; Tr ac-сургалтын үйл ажиллагааны үнэлэмж

Бидний судалгааны ажлын хувьд далд хувьсагчдын хүчин зүйлийн болон хамаарлын шинжилгээг 4 хувьсагчаар 3 замаар таамаглал дэвшүүлэн батлах оролдлогоор шинжилгээ хийсэн. Үүнд:

“Мэдлэг”-ийг 6 асуултаар сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн 0.655-0.860 хооронд хэлбэлзэж байна.

“Ур чадвар”-ийг 6 асуултаар сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн 0.735-0.808 хооронд хэлбэлзэж байна.

“Хандлага”-ыг 6 асуултаар сургалтын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн 0.851-0.944 хооронд хэлбэлзэж байна.

“Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж”-ийг 6 далд хувьсагчаар судалж үзэхэд үр дүн 0.856-0.951 хооронд хэлбэлзэж байна.

Кронбах альфа утгын үр дүнг харахад мэдлэг 0.858; ур чадвар 0.869; хандлага 0.943; сургалтын үйл ажиллагааны үнэлэмж 0.958 байгаагаас мэдлэгийн үр дүн бага байсан.

Нийлмэл найдвартай байдлын хувьд мэдлэг 0.894; ур чадвар 0.902; хандлага 0.955; сургалтын үйл ажиллагааны үнэлэмж 0.967 байгаа нь найдвартай байдал сайн байгааг илтгэнэ.

Дундаж утгын хувьд, мэдлэг 0.587; ур чадвар 0.605; хандлага 0.780; сургалтын үйл ажиллагааны үнэлэмж 0.829 байгаа нь дундаж утга тогтвортой байгааг илтгэж байна.

Хүснэгт 17. Судалгааны загвар дахь замын шинжилгээний үр дүн

№	Таамаглалууд	Дундаж утга	Стандарт хазайлт	T Статистик	П үнэ цэнэ	Үр дүн
1	Мэдлэг → Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	0.329	0.135	2.434	0.015	батлагдсан
2	Ур чадвар → Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	0.264	0.167	1.582	0.114	батлагдаагүй
3	Хандлага → Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	0.233	0.112	2.090	0.037	батлагдсан

Энэхүү судалгааны ажилд замын шинжилгээг нэг хувилбараар шинжлэн 3 таамаглалаас үр дүнг гаргахад 2 таамаглал батлагдаж, 1 таамаглал батлагдаагүй. /Хүснэгт № 33/

Мэдлэг нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн T статистик утга 2.434, П үнэ цэнэ 0.015, хандлага нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн T статистик утга 2.090 гарч, П үнэ цэнэ 0.037 утгатай тус тус гарч таамаглал батлагдлаа.


Харин ур чадвар нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн T статистик утга 1.582, П үнэ цэнэ 0.114 утгатай гарч таамаглал батлагдсангүй.

Эндээс Цагдаагийн сургуулийн сонсогчдын сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид шууд нөлөөлөх хувьсагч буюу ур чадварын далд хувьсагчдад сөрөг үр дүнг илэрхийлэх асуудал агуулж байгааг илтгэсэн.

Мэдлэг нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн T статистик утга 1.381, П үнэ цэнэ 0.168, хандлага нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн T статистик утга 1.432 гарч, П үнэ цэнэ 0.153 утгатай, ур чадвар нь сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн T статистик утга 1.354, П үнэ цэнэ 0.176 утгатай гарч таамаглал батлагдсангүй.

Судалгаанд 3240 цагдаагийн алба хаагчийг хамруулсан ба чанарын судалгаагаар, хүчин зүйлсийн шинжилгээ, хэмжил зүйн шинжилгээ, хамаарлын шинжилгээ, замын шинжилгээний боловсруулалт хийн үр дүнг гаргасан. Үүнд:

Зураг 2. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн



Тайлбар: know-мэдлэгийн менежмент; Skill-ур чадвар; Com-Хандлага; Tr ас-сургалтын үйл ажиллагааны үнэлэмж

Хэмжил зүйн шинжилгээний үр дүн нь энэхүү судалгааны ажлын хамгийн чухал хэсэг бөгөөд судалгааны үр дүнг боловсруулах, харьцуулан шинжлэх, бататгах, дүгнэх хэсэг юм. Уг шинжилгээгээр далд хувьсагч бүр манлайлалд хэрхэн нөлөөлж байгааг харуулах ба, хүчин зүйл тус бүрийн үр дүнг гаргасан болно. Кронбах альфа буюу тогтвортой байдал нь далд хувьсагчдын багц үзүүлэлт хоорондоо хэрхэн уялдаатай байгааг илэрхийлнэ. Найдвартай байдлын хэмжүүрийг дараах томъёогоор тодорхойлон үр дүнг гаргасан.

Хүснэгт 18. Хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Ур чадвар	Skill-1	0.837	0.954	0.944	0.774
	Skill-2	0.837			
	Skill-3	0.903			
	Skill-4	0.827			
	Skill-5	0.984			
Мэдлэг	Know-1	0.718	0.948	0.921	0.702
	Know-2	0.903			
	Know-3	0.725			
	Know-4	0.861			
	Know-5	0.955			
Хандлага	Com-1	0.890	0.946	0.958	0.822
	Com-2	0.946			
	Com-3	0.943			
	Com-4	0.917			
	Com-5	0.832			
Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	Tr ас-1	0.748	0.941	0.956	0.814
	Tr ас-2	0.923			
	Tr ас-3	0.948			
	Tr ас-4	0.940			
	Tr ас-5	0.935			

Тайлбар: know-мэдлэгийн менежмент; Cog-танин мэдэхүй; Skill-ур чадвар; Com-дадал, арга, барил; Tr ас-сургалтын үйл ажиллагааны үнэлэмж

Бидний судалгааны ажлын хувьд далд хувьсагчдын хүчин зүйлийн болон хамаарлын шинжилгээг 4 хувьсагчаар 3 замаар таамаглал дэвшүүлэн батлах оролдлогоор шинжилгээ хийсэн. Үүнд:

“Мэдлэг”-ийг 5 асуултаар сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.718-0.955** хооронд хэлбэлзэж байна.

“Ур чадвар”-ийг 5 асуултаар сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.827-0.984** хооронд хэлбэлзэж байна.

“Хандлага”-ыг 5 асуултаар сургалтын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.832-0.946** хооронд хэлбэлзэж байна.

“Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж”-ийг 5 далд хувьсагчаар судалж үзэхэд үр дүн **0.748-0.948** хооронд хэлбэлзэж байна.

Кронбах альфа утгын үр дүнг харахад мэдлэг **0.948**; ур чадвар **0.954**; хандлага **0.946**; сургалтын үйл ажиллагааны үнэлэмж **0.941** байгаагаас сургалтын үнэлэмжийн үр дүн бага байсан.

Нийлмэл найдвартай байдлын хувьд мэдлэг **0.921**; ур чадвар **0.944**; хандлага **0.958**; сургалтын үйл ажиллагааны үнэлэмж **0.956** байгаа нь найдвартай байдал сайн байгааг илтгэнэ.

Дундаж утгын хувьд, мэдлэг **0.702**; ур чадвар **0.774**; хандлага **0.822**; сургалтын үйл ажиллагааны үнэлэмж **0.814** байгаа нь дундаж утга тогтвортой байгааг илтгэж байна.

Хүснэгт 19. Судалгааны загвар дахь замын шинжилгээний үр дүн

№	Таамаглалууд	Дундаж утга	Стандарт хазайлт	T Статистик	П үнэ цэнэ	Үр дүн
1	Мэдлэг → Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	0.313	0.226	1.381	0.015	батлагдсан
2	Ур чадвар → Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	0.322	0.238	1.354	0.024	батлагдсан
3	Хандлага → Сургалтын үйл ажиллагааны үнэлэмж	0.149	0.104	1.432	0.037	батлагдсан

Үүнээс дүгнэхэд, цагдаагийн байгууллагын алба хаагчдыг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх сургалтын зохион байгуулалт, менежмент, тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр цагдаагийн байгууллагын алба хаагчдын төлөөлөл, цагдаагийн сургууль, ахлагчийн сургуулийн сонсогчдын төлөөлөл, эрдэмтэн, судлаачдаас социологийн судалгаа, хэрэгжилтэд өгөх үнэлгээний судалгаа авч, өнөөгийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хөгжүүлэх асуудлыг дэвшүүлэхээр анкет асуулгын аргаар 3500 цагдаагийн алба хаагч, сонсогч, суралцагчдаас улсын хэмжээнд судалгааг авч, асуулгын чанар хангасан 3472 анкетыг математик статистикийн SPSS.23 программ дээр шивж оруулан үр дүнг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийв.

Санал асуулгад оролцсон алба хаагчдын насны ангилал, ажилласан жил, боловсролын зэрэг, мэргэжил, албан тушаал, цолны зэрэглэлийн ангиллыг авч үзэхэд тэгш оролцоог хангасан гэж дүгнэж байна.

Цагдаагийн албанд орж ажиллах хүсэл, сургалтын үйл ажиллагаагаа, эрх зүйн зохицуулалт болон тогтолцооны талаар сонсогч, суралцагч болон цагдаагийн алба хаагчдаас авсан судалгааны үр дүнг харьцуулахад сонсогч, суралцагчдын хариултууд илүү эерэг байсан бол цагдаагийн алба хаагчид сөрөг буюу буурсан үр дүнг харуулж байгаа нь алба хаагчид дээрх асуудлуудад шүүмжлэлтэй хандаж байгааг илтгэж байна.

Мөн сургалтыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт, дүрэм, журам ойлгомжгүй, уялдаа холбоогүй, шинэчлэх дахин зохион байгуулах шаардлагатай болохыг судалгааны үр дүнгээс харж болно.

Цагдаагийн сургуулийн сонсогч, суралцагч, цагдаагийн алба хаагчдын сургалтын үйл ажиллагааны үнэлэмжид нөлөөлж буй хүчин зүйлийг онол, арга зүйн үндэслэлтэйгээр, олон улсын эрдэмтдийн судалгааны ажлын таамаглалыг дэмжин судлахын тулд шууд нөлөөлөлтэй 3 таамаглал бүхий загвар санал болгож, таамаглалыг батлах оролдлогыг энэхүү судалгааны ажлаар хийлээ.

Судалгаанд Цагдаагийн сургуулийн нийт 205 сонсогч, Ахлагчийн сургуулийн 86 сонсогч, 3240 цагдаагийн алба хаагч оролцсоноос алба хаагчдын хувьд нас, хүйс, ажилласан жил, албан тушаал, цол, зэрэглэл, сонсогч суралцагчдын курс, дамжааны ангилал зэргээс үзвэл оролцоог тэгш хангасан тул үр дүн тэнцвэртэй бодитой гарсан болохыг илтгэнэ.

Бид энэхүү судалгааны ажлаар сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөх хувьсагчийн талаар илүү дэлгэрүүлэн судлах, дараа дараагийн судлаачдын судалгааны ажлын суурь судалгаа болгох, сургалт хэрхэн хэрэгжиж байгааг хянан судалсан. Судалгааны ажлын хэмжил зүй, хүчин зүйлсийн шинжилгээг хийхдээ сөрөг гарсан далд хувьсагчийг тайлбарлах байдлаар бичсэн нь судалгааны ажлын ач холбогдлыг харуулсан гэж дүгнэж байна.

Эдгээрээс үзвэл, цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан бэлтгэх сургалтын тогтолцоог загварчлах, тус тусын буюу өөр хоорондоо захиалга төдий өгөх байдлаар харилцаж буй агентлаг байгууллагуудын үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагаанд хамтрах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилан урт болон богино хугацааны сургалтуудын эрэмбэ, дараалал, ажлын байранд нь шаардагдах сургалтуудыг журамлан зохион байгуулах үндсэн загваруудыг бий болгох шаардлагатай. Түүний дараа тухайн үйл ажиллагаанд тохирсон хууль, эрх зүйн орчинд нэмэлт, өөрчлөлт хийх нь зүйтэй талаар санал дэвшүүлэв.

Цагдаагийн алба хаагчид, сонсогч, суралцагчдаас авсан судалгааны үр дүнд цагдаагийн алба хаагчийн сургалтад тулгамдаж буй асуудлуудыг дараах байдлаар жагсаалт болгон гаргаж байна. Үүнд:

- *Онол, үзэл баримтлалын хувьд холимог шинжтэй бөгөөд цагдаагийн алба хаагчийн сургалтын хэв шинж тогтоогүй;*
- *Ажлын байрны тодорхойлолт, бэлтгэж буй мэргэжлийн индекс зөрүүтэй;*
- *Ажлын байранд сул орон тоо их гардаг нь чанаргүй бөгөөд их хэмжээгээр алба хаагчдыг бэлтгэх шалтгааныг үүсгэж байна;*
- *Тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагаа хангалтгүй;*
- *Гадаадад төгссөн, мэргэжил дээшлүүлсэн алба хаагчид ажлын байрандаа тогтвортой ажиллахгүй байна;*

- *Сонгон шалгаруулалтын чанар алдагдсан;*
- *Бүх түвшинд шинээр томилогдоход дасан зохицох сургалт зайлиггүй шаардагдаж байна;*
- *Сургалтын үе шаттай хөгжих тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай;*
- *Алба хаагчийг бэлтгэх болон ажлын байрны давтан, мэргэшүүлэх сургалтын уялдаа алдагдсан;*
- *Сургалттай холбоотой эрх зүйн зохицуулалтуудын хэрэгжилт хангагддаггүй;*
- *Ажлын ачааллаас шалтгаалж, суралцах, хөгжих боломж тааруу зэрэг асуудлууд тулгамдаж байна.*

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэхжүүлэх, ур чадварлаг алба хаагчдыг бэлтгэх, албаны болон давтан мэргэшүүлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнгийн дагуу урамшуулах, дэвшүүлэх зохицуулалтыг нэвтрүүлэх нь дан ганц алба хаагчид бус цагдаагийн байгууллагын хөгжилд үнэтэй хувь нэмэр болно гэж дүгнэж байна.

Дээрх өгүүлсэн нөхцөлийг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

Цагдаагийн алба хаагч, сонсогч, суралцагчдын төлөөллөөс авсан судалгааны үр дүнд сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтад мэргэжлийн индексийн зөрүү, ажлын байранд сул орон тоо их учир их хэмжээний чанаргүй алба хаагчдыг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй, сонгон шалгаруулалт сул, сургалтын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт сул, сургалтуудын уялдаа холбоо сул, ажлын ачааллаас шалтгаалж суралцах, хөгжих боломж муу байдаг нь өнөөгийн тулгамдаж буй гол асуудлууд болж байна.

Цагдаагийн алба хаагч, сонсогч суралцагчдаас авсан судалгаагаар сургалтын тогтолцоо, зохион байгуулалт, үе шат, ангилал, хэрэгжүүлэлтийг сайжруулах, боловсронгуй болгох нь алба хаагчийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг илэрхийлж байна.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан бэлтгэх сургалтын тогтолцоог загварчлах, тус тусын буюу өөр хоорондоо захиалга төдий өгөх байдлаар харилцаж буй агентлаг байгууллагуудын үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагаанд хамтрах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилан урт болон богино хугацааны сургалтуудын эрэмбэ, дараалал, ажлын байранд нь шаардагдах сургалтуудыг журамлан зохион байгуулах үндсэн загваруудыг бий болгох шаардлагатай. Түүний дараа тухайн үйл ажиллагаанд тохирсон хууль, эрх зүйн орчинд нэмэлт, өөрчлөлт хийх нь зөв зүйтэй.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэхжүүлэх, ур чадварлаг алба хаагчдыг бэлтгэх, албаны болон давтан мэргэшүүлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнгийн дагуу урамшуулах, дэвшүүлэх зохицуулалтыг нэвтрүүлэх нь дан ганц алба хаагчид бус цагдаагийн байгууллагын хөгжилд үнэтэй хувь нэмэр болно гэж дүгнэж байна.

4.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр сургалтын байгууллагуудын тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох шийдэл

Тогтолцоо буюу системийн онолоор бүхэллэг чанар нь элементүүдийн хоорондын харилцан хамаарлыг илэрхийлнэ. Элементүүд хоорондоо шалтгаант холбоо, чиг үүргийн хамаарал, зохицуулах холбоостой байна.

Шалтгаант холбоо нь тогтолцооны нэг хэсгийг нөгөө хэсэгтэй нөхцөлдүүлж байдаг. Чиг үүргийн хамаарал нь шалтгаант холбоогоор дам илрэх бөгөөд нэг элементийн өөрчлөлт бусдаас хамаарах буюу тогтолцооны хөгжилд нөлөөлдөг шинжийг илэрхийлнэ. Хооронд нь байдаг зохицуулах холбоос нь тогтолцооны тогтвортой байдал, шатлалын тэнцвэржүүлэгч юм. Алба хаагчийг сургах, бэлтгэх тогтолцоо бол нийгмийн амьд организм бөгөөд өргөн хүрээг хамарч дотроо олон дэд тогтолцоонуудыг агуулна.

Ийм тогтолцооны тогтвортой чанарыг “орц”, “гарц”-ын мэдээ сэлтийн хооронд тохироо үүссэн байдлаар нь судалж болно. Үүнд гадаад орчин ба бусад нөхцөл байдлын нөлөөгөөр “орох”, “гарах” мэдээллийн хооронд зөрөө үүсвэл тогтолцооны горим алдагдсан, “орц”, “гарц”-ын хэмжигдэхүүнүүдийн хоорондын хамаарал нь хөтөлбөрийн дагуу инвариант байвал тогтолцоог хэвийн гэж үзнэ²³.

Үүнээс үзвэл, орц, гарцын хэмжигдэхүүний хоорондын хамаарал дундаа тасалдаж байвал тогтолцоо нэгдмэл бус байна гэж үзэх боломжтой гэж дүгнэв.

Харьцуулсан судалгаагаар олж авсан шинжилгээний үндсэн дээр тухайн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх хөтөлбөрийг гаргах нь менежментийн чухал зарчим болно.

Орц-үйл явц-гарц гэсэн системийн ерөнхий онолын бүтцийн хувьд цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны ойлголт нь дэд тогтолцоо бүрд орц буюу сонгон шалгаруулж, элсүүлэх, сургалтын үйл ажиллагаа, гарц буюу сургалтыг дуусгах гэсэн үе шатуудаас бүрдэнэ гэж ойлгож болно. Мөн сургалт бүрд гадаад, дотоод орчны нөлөө бий гэж онолын үүднээс дүгнэж, сургалтын тогтолцооны загваруудыг гаргахдаа ашиглав.

Бид энэхүү судалгаандаа цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллага, цагдаагийн төв байгууллага сургалтыг ямар эрэмбэ дараалал бүхий тогтолцоотой хэрэгжүүлэх талаар авч үзэхийг чухалчилсан юм.

Өөрөөр хэлбэл, доктор Ц.Наранчимэгийн дэвшүүлсэн цагдаагийн алба хаагчийн тасралтгүй боловсрол, доктор П.Алгаагийн дэвшүүлсэн сургалтын тогтолцоо гэсэн ойлголтуудаас үндэслэн цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо нь хэд хэдэн тодорхой үе шаттай, байгууллагуудын хамтарсан буюу эрэмбэ, дараалал бүхий зохион байгуулалттай байх шаардлагатай гэж дүгнэлээ.

Өмнөх бүлгүүдэд авч үзсэнчлэн өнөөгийн байдлаар цагдаагийн алба хаагчийн сургалтын нэгдсэн тогтолцоо хангагдахгүй байгаа нь байгууллагууд харилцан уялдаатай ажилладаггүйгээс улбаатай бөгөөд үүний үр дүнд хүний нөөцийн хөгжих боломж, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн чадвар, чансаа буурч байгаа болох нь харагдана.

²³ Алгаа, П. Зэвсэгт хүчний офицер бэлтгэх сургалтын тогтолцоо. -Уб., 2003. 11 дэх тал

Тээврийн цагдаагийн алба хаагчийг анхан шатанд 3 сар, бакалаврын шатанд 4 жилийн хугацаанд бэлтгэн гаргах нь тухайн алба хаагчийг үүрэг гүйцэтгэх хугацааны турш хангалттай мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлж чадахгүй бөгөөд тасралтгүй хөгжих боломжийг албаны, давтан, мэргэшүүлэх сургалтууд олгож байж орчин үеийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангах нь мэдээжийн хэрэг юм.

Гадаадын ихэнх орны туршлагаас авч үзвэл анхан шатны буюу мэргэжил олгох сургалт нь харьцангуй богино хугацаанд зохион байгуулагдаж, практикт ажиллаж байх хугацаанд байнгын мэргэшүүлэх сургалтад хамруулдаг жишигтэй байна. Мөн алба хаагч өөрөө сонгон шалгаруулалтад бэлдэж, цааш цаашдын дээд боловсрол, боловсролын зэрэг дээшлүүлэх сургалтад хамрагдах боломжоо бүрдүүлдэг тогтолцоотой байна.

Мөн тээврийн цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий их сургуулийн хувьд алба хаагчдын боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт буюу магистр, докторын түвшний сургалтуудыг зохион байгуулж буй бөгөөд холбогдох эрх зүйн зохицуулалтаар суралцах боломж нээлттэй хэдий ч ажлын ачаалал, удирдах албан тушаалтнуудын хандлагаас шалтгаалж алба хаагчид тэр бүр хамрагдах боломжгүй байдаг нь санал асуулгын судалгаагаар тогтоогдсон.

Харин цагдаагийн төв байгууллагаас алба хаагчид руу чиглэсэн албаны, давтан, мэргэшүүлэх сургалтын хувьд тодорхой ангилал, үйл ажиллагааны жигдэрсэн тогтолцоо сул бөгөөд сургалтын үнэлгээ, ач холбогдол нь анх алба хаагчдыг бэлтгэж буй тогтолцоотой уялдаа холбоо, хамаарал сул байгаа нь мөн судалгаагаар тогтоогдлоо.

Үүнээс үзвэл, сургалтуудын төрөл, ангиллаар дээрх байгууллагууд тус тусад нь хэрэгжүүлж, тусдаа бодлого төлөвлөгөө гарган ажиллаж байгаа нь үүний нэг шалтгаан мөн боловч зохион байгуулах тогтолцооны хувьд нэгдсэн нэг загварт оруулах боломж байгаа гэж үзэж байна.

Ийнхүү алба хаагчийг сургах, бэлтгэх үйл ажиллагаа нь “бүтээгдэхүүн”-ий чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн эргэх холбоо бүхий цогц тогтолцоонд захирагддаг төдийгүй, төрийн захиргааны төв байгууллага, хэрэглэгч, захиалагч, үйлчлүүлэгчдийн үнэлгээгээр зорилт чиг үүрэг нь засварлагдан технологи нь улам боловсронгуй болж байдаг амьд хөдөлмөр болох нь тодорхой юм.

Тээврийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь хамгийн энгийнээсээ эхлээд удирдах шат хүртэл тодорхой хугацааны сургалт зайлшгүй шаардах бөгөөд тодорхой нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авах, дадлагажиж хэвшил болтлоо чадваржсан байхыг шаарддаг. Түүнээс гадна орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололтын үр дүнд бий болсон ба зохион байгуулалт, дэг журам, эрэмбэ журамлалаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай болдог.

Иймд тээврийн цагдаагийн хүний нөөцийг бэлтгэх үйл ажиллагаа нь шаталсан сургалтын тогтолцоо бүхий “бэлтгэх”, “хөгжүүлэх” сургалтаар зохион байгуулагдана.

Үүнээс үзэхэд тээврийн цагдаагийн алба хаагч нь албан тушаал ахихын тулд тодорхой түвшинд сурч бэлтгэгдсэн ажлын туршлага, үйл ажиллагааны ур чадвар заавал эзэмшсэн байх

шаардлагатай болдог учир сургалтын систем нь шаталсан тогтолцоотой байдаг зүй тогтолтой байна.

Эрдэмтэн З.Мөнхдалай²⁴ орчин үеийн дээд боловсролын байгууллагын 4 хэв шинжийг тодорхойлсон байна. Үүнд:

“А” гадаад орчны нөлөөллөөс ангид ихээхэн бие даасан шинжтэй өөрийн зохицуулалт бүхий нээлттэй байгууллага. Үүнд АНУ, Канад, Австрали, Их Британийн коллеж, их сургуулиуд орох бөгөөд тэдгээрийн бие даасан бүрэн зохицуулалт бүхий байгууллага.

“Б” илүү чөлөөтэй, өөрийгөө зохицуулах тал руу нь чиглүүлсэн, өөрчлөлтийн бодлогыг төр засгаас нь аль хэдийнээ тунхаглаж, дээд боловсролын байгууллагуудтай хамтарч нэлээд зүйлийг хэрэгжүүлж буй орны байгууллага түүнд умард европын орнууд болон Сингапур, Филиппин, Нигери, Алжир зэрэг хэд хэдэн орнууд багтах ба тэдгээрийг “өөрийгөө зохицуулах төлөвт шилжиж буй байгууллага” гэж үздэг.

“В” төр засгаас нь өөрчлөлтийн бодлогыг нь тунхагласан боловч түүнийг хэрэгжүүлэх шатандаа янз бүрийн асуудал, бэрхшээлтэй тулгарч буй орны байгууллага, тэдгээрт Латин Америк, Дорнод Европын орнуудын сургуулиуд багтана.

Эдгээр орнуудын дээд сургуулиудад байгууллагын бие даасан байдалд шилжих, үнэлгээ стратегийн төлөвлөлт хийх хүрээнд зарим эхлэлүүд тавигдаж байгаа боловч бүхэлд нь авч үзвэл өөрийн зохицуулалт бүхий төлөвт шилжихэд ихээхэн хүндрэлтэй байгаа юм. Иймд энэ орны дээд сургуулиудыг өөрийн зохицуулалт бүхий төлөвт шилжихэд хүндрэлтэй байгаа байгууллага гэж үздэг.

“Г” олон тооны хөгжиж буй орнууд болон Европын эх газрын зарим орнуудын (Франц, Итали, Австри, Герман г.м) төвлөрсөн төлөвлөгөөтэй төрийн хяналт бүхий боловсролын байгууллага энэ хүрээнд улсын төвлөрсөн тогтолцоог байгууллагын өөрийгөө зохицуулах чадвартай хослуулан хөгжүүлэх чиглэлийг барьж байна.

Тээврийн цагдаагийн алба хаагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг зөвхөн мэргэжил олгох сургалтын хугацаанд эзэмших боломжгүй бөгөөд үүсэх нөхцөл байдал, нийгмийн болон технологийн хөгжлийг дагаад зогсолтгүй хөгжиж байх шаардлага тулгарна. Энэ нь өмнө дурдсанчлан цагдаагийн алба хаагчийн сургалт нь насан туршийн буюу тасралтгүй шинжийг агуулж байгаагийн тод илрэл юм.

Сүүлийн жилүүдэд хийсэн төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ур чадварт иргэдийн зүгээс үнэлж буй судалгааны үр дүнгээс авч үзвэл цагдаагийн алба хаагчдыг үнэлэх үнэлэмж, тэдний ур, чадвар, хандлагыг дийлэнх нь сул, тааруу гэж үнэлж байна.

Цагдаагийн байгууллагын ажил олгогчдоос авсан судалгаагаар ч шинээр төгсөгчдийн 40-50 хувь нь мэдлэг, ур чадварын хувьд хангалтгүй байгаа талаар санал, сэтгэгдлээ илэрхийлдэг нь нууц биш юм.

²⁴ Алгаа, П. Зэвсэгт хүчний офицер бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох нь. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон диссертац. –Уб., 2003. 29 дэх тал.

Үүнийг бид цагдаагийн алба хаагчийн бэлтгэгдэх хугацаа болон ажлын байрандаа шууд ажиллах мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн олж авах талаар түүхэн эх сурвалж, гадаад орнуудын туршлага зэргээс харьцуулан судалж, дүгнэж болно.

Тээврийн цагдаагийн алба хаагчийг шатлан сургаж боловсролыг нь ахиулах тогтолцоо нь дундаа тасалдал ихтэй, албан тушаалын ба мэргэжил дээшлүүлэх дамжаа богино хугацаанд явагдаж байна. Албаны сургалтын үр дүн сул, ахисан шатны сургалтад хамрагдах боломжоор үл хангадаг, сургалтын тодорхой шалгуураар алба хаагчийг ахиж дэвших боломж бага, өөрөөр хэлбэл, танил талын томилгоо шууд хийгдэх тохиолдол их бөгөөд алба хаагчийн ажлын байранд сургах сургалт, дадлагажуулах үйл ажиллагаа хангалттай биш байна.

Цагдаагийн байгууллага буюу цагдаагийн алба хаагчдад албаны, давтан, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах чиг үүрэгтэй байгууллагад албан ёсоор дээрх төрлийн багш байхгүй бөгөөд сургагч багш нарыг богино хугацаанд бэлдэж, алба хаагчдад сургалт зохион байгуулах үйл ажиллагааг тайланд тусгах байдлаар үр дүнг тооцож байгаа нь хамгийн сөрөг тал болж байна.

Зарим улс оронд цагдаагийн коллеж буюу энэ чиглэлийн ерөнхий боловсролын тусгай сургуулийг байгуулж, улмаар иргэний боловсролын сургуульд тусгай анги нээх замаар, ирээдүйн цагдаагийн мэргэжилтнүүдийг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх алхмыг хэрэгжүүлж байна.

Тээврийн цагдаагийн алба хаагчийг бэлтгэх тогтолцоо нь мэргэжлийн боловсрол олгож, мэргэжил эзэмшүүлэх; мэргэжил дээшлүүлэх; ажлын байран дээр нь дадлагажуулах гэсэн үйл ажиллагааны 3 үндсэн дэд тогтолцоонуудыг агуулж байдаг.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын олон улсын жишиг Монгол Улсын хуульд нийцэж байгаа боловч сургалтуудын интеграцчилал, дифференциалчлал, стандартжуулах асуудлыг сургалтын чанарыг хангах гол хүчин зүйл гэж үзэж байна.

Дэлхий дахинд нийгмийн аливаа үзэгдэл, нийгэм, техник, технологи хөгжихтэй зэрэгцэн цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоонд шинэ арга барил нэвтрэх, цагдаагийн алба хаагчийн сурах, боловсролын хэрэгцээ тасралтгүй буюу насан туршийн шинжтэй болж, зөвхөн бэлтгэж практикт нийлүүлэхээс гадна албаны сургалтууд нь байнгын үйл ажиллагааг хангахад чиглэх шаардлага тулгарч байна.


Боловсролын тогтолцоог систем талаас нь авч үзвэл зорилго, хөтөлбөр, багш, орчин, чанарын үнэлгээ, эрх зүйн орчин²⁵ гэсэн элементүүдээс бүрдэх бөгөөд энэ нь бидний судалгааны ажилд дэвшүүлэхийг зорьж буй сургалтын тогтолцоо дахь орц хэсгийг бүрдүүлж байна.

Үйл явцын хэсэг буюу сургалтын процесс ажиллагаанд мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх, ажлын байрны сургалт, давтан болон мэргэшүүлэх сургалтын үе шатуудыг авч үзэх боломжтой ба эдгээр нь сургалтын тогтолцоог системийн онолын үүднээс бүрдүүлж байна гэж үзэж болно.

²⁵ Кузьмина (Головко-Гаршина) Н.В. (2002) Предмет акмеологии. СПб.: Политехника.

Харин үр дүн буюу сургалтын үйл ажиллагааны гарц нь албан тушаал, ажлын байранд тохирсон мэдлэг чадвар, хандлага бүхий алба хаагч байх юм.

Бүдүүвч 3. Тээврийн цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагаас хэрэгжүүлэх сургалтын тогтолцооны загвар



Тээврийн цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллагын хувьд өнөөгийн байдлаар мэргэжлийн боловсрол олгох сургалт буюу цагдаагийн анхан шатны алба хаагчид болох ахлагч бэлтгэх, дээд боловсрол олгох буюу бакалаврын сургалт, боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт буюу магистр, докторын сургалтыг зохион байгуулахад түлхүү анхаарч, гурван хэсэгт авч үзэж байна гэж дүгнэсэн.

Эдгээр сургалтууд нь цагдаагийн албанд орж ажиллах сонсогчдыг бэлтгэдэг төдийгүй сургалтын агуулга, үйл ажиллагааны хувьд нэг нэгэнтэйгээ уялдаатай байх шаардлагатай юм. Гадаадын ихэнх орны туршлагаас авч үзвэл эхлээд заавал анхан шатны сургалтад хамрагдсан алба хаагч тодорхой хугацаанд албан үүрэг гүйцэтгэж байж, дээд боловсрол эзэмших боломжтой болдог тогтолцоотой байна.

Манай орны хувьд аль ч сургалтын элсэлт холимог буюу алтернатив шинжийг агуулж байна. Тухайлбал, бакалаврын сургалтыг өдрийн, эчнээ, их дээд сургууль төгссөн элсэгчдийн гэх мэт төрөл бүрийн хөтөлбөрөөр элсэх боломжтой бөгөөд ахлагч буюу цагдаад ажиллаж байгаа алба хаагчдыг ч элсүүлэх боломжтой байна.

Харин боловсролын зэрэг дээшлүүлэх сургалтын хувьд зөвхөн цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллагаар хязгаарлагдахгүй бөгөөд бусад их, дээд сургуульд суралцах боломж нээлттэй хэвээр байна.

Мөн гадаадын их, дээд сургууль, академид суралцуулах, харилцан оюутан солилцох зэрэг нь нээлттэй бөгөөд эдгээрийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт харьцангуй ерөнхий байгаа нь өнөөгийн холимог шинж, нөхцөл бүрдэхэд хүргэжээ.

Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар зохицуулагдсан тогтолцоог судалгаанд суурилан засаж, сайжруулах, илүү боловсронгуй болгох нэн шаардлагатай байна.

Одоо хэрэгжиж байгаа журмаар цагдаагийн төв байгууллагаас мэргэжлийн бэлтгэл, давтан сургалт, албаны сургалт гэсэн 3 ангиллын сургалт байгаа бөгөөд дотроо хэд хэдэн төрөлтэй. Тухайлбал, мэргэжлийн бэлтгэл сургалтад мэргэшүүлэх, ур чадварын, чадавхжуулах, ёс зүйн, албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын гэсэн төрлүүд байгаа бол албаны сургалтад ажлын байрны, алба хаагчийн үргэлжилсэн, ажлын байран дээрх албаны сургалт гэсэн төрлүүд байгаа бол давтан сургалтыг мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт гэж тодорхойлсон байна.

Үүнээс үзвэл, энэ ангилал, тогтолцоо нь агуулгын хувьд давхардал ихтэй, тодорхойгүй хэд хэдэн төрлүүд байгаа бөгөөд аль сургалтыг ямар алба хаагчдын дунд зохион байгуулах нь тодорхойгүй, сургалтын үр дүнг үнэлэх, хянах тогтолцоогүй зэрэг алдаа, дутагдал их байна. Энэ нь алба хаагчдад ч ойлгомжгүй байдаг нь судалгаагаар тогтоогдсон. Жишээлбэл, ур чадварын болон чадавхжуулах сургалт, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх гэсэн сургалтууд агуулгын давхцалтай, ажлын байрны, ажлын байран дээрх албаны сургалтууд мөн адил давхцалтай байна.

Мөн тус сургалтуудыг ямар хугацаанд, ямар алба хаагчдад зохион байгуулах, хүрэх үр дүн, зорилго, хөтөлбөр, төлөвлөгөө байдаггүй, мэргэжлийн сургагч багш байдаггүй зэрэг нь практик ажиллаж буй алба хаагчдын хэвийн суралцах нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Иймээс өмнөх бүлгүүдэд хийгдсэн судалгаанд үндэслэн цагдаагийн төв байгууллагаас зохион байгуулдаг сургалтын тогтолцоог дараах байдлаар дахин боловсруулах шаардлагатай гэж үзлээ.

Юуны өмнө цагдаагийн алба хаагчдын дунд зохион байгуулах сургалтын ерөнхий зорилгуудыг тодорхойлох шаардлагатай юм. Хамгийн чухал гэсэн гурван зорилгын хүрээнд бусад бүх төрлийн сургалтууд ангилагдах боломжтой гэж дүгнэлээ.

1. Ажлын байрны сургалт

Энэ нь хуучнаар албаны сургалтын шинжийг агуулах бөгөөд тухайн ажиллаж буй бүс, нутгийн онцлогт тохируулан томилогдсон албаны чиглэлтэй холбоотойг шаталсан хэлбэрээр явагдах зүй тогтол бүхий хэлбэртэй сургалтууд байх юм. Тухайлбал, ажлын байранд дасан зохицох, албаны бэлэн байдал, бэлтгэл, хууль, эрх зүйн зохицуулалтыг хэрэглэх гэх мэт байнгын хэрэгцээ шаардлагад тулгуурласан хамгийн өргөн хүрээний сургалтын төрөл байх шаардлагатай.

Энэ ангилалд багтаж буй сургалтууд нь хамгийн ерөнхий агуулгатай бөгөөд дадал олгох, биеийн хүчний болон, эрх зүйн мэдлэгийг олгох, албан тушаалын онцлогийг судлах зэргээс бүрдэж байх нь чухал юм.

2. Мэргэшүүлэх сургалт

Энэхүү сургалт нь тухайн алба хаагч өөрийн ур, чадвар, ажлын үзүүлэлт нь дараа дараагийн албан тушаал, цол ахих боломжийг хангаж байгаа тохиолдолд дэвших шатны сургалт байх юм. Энэ нь албан тушаал ахих буюу цол нэмэх, цагдаагийн төрөл, мэргэжлийн албадын дотор залгамж халааг зөв зүйтэй бэлтгэх, ахлах болон удирдах албан тушаалтны манлайллыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нөгөө талаасаа ил, тод, шударга зарчмаар ахиж, дэвших боломжийг бүрдүүлэх төдийгүй сургалтын чанар, үр дүнгээс шууд хамаарч ахиж дэвших эрх нээгдэх нь цагдаагийн алба хаагчдыг мэргэшихэд идэвхжүүлэх нөлөө үзүүлнэ.

Энэ төрлийн сургалтын төрөлд албан тушаалын, цол, зэрэг дэвийн, ур чадварын гэх зэрэг төрлүүдээр элсэх боломжийг хангасан алба хаагчдыг хамруулан үр дүнг хэрэгжих байдлаар нь зохион байгуулах нь оновчтой. Ингэснээр ажилласан хугацаагаар эсвэл танил талын дэмжлэгээр албан тушаал, цол ахих зэрэг сөрөг үзэгдэл багасна.

3. Давтан сургалт

Алба хаагч тодорхой албан тушаалд дэвших нөөцөд бүртгэгдээгүй, ажлын үр дүнгээ гаргаж чадахгүй байгаа, эсвэл алдаа дутагдал гаргасан тохиолдолд давтан сургалтыг зохион байгуулна. Өмнө хэрэгжүүлж байсан төлбөрт ёс зүйн сургалтыг ч энэ ангилалд хамруулан оруулна.

Үүнээс гадна цагдаагийн алба хаагчдын дээрх 3 ангиллын сургалтын цахим сан үүсгэж, холбогдох сургалтуудад өөрийн хүсэлтээр хамрагдах боломжийг бүрдүүлэх нь илүү үр дүнтэй.

Мөн дээрх сургалтуудыг үр дүнтэй зохион байгуулсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхийн тулд тодорхой шалгалт, баталгаажуулалт хийх нь зүй ёсны хэрэг юм. Тухайн сургалтуудад хамрагдсан алба хаагчдыг шалгалтад хамруулж, үр дүнг тооцох нь сургалтын зохион байгуулалтад чухал нөлөөтэй юм. Харин өнөөгийн байдлаар зөвхөн хэдэн алба хаагчдад ямар сэдвээр сургалт орсон эсэхийг тайлагнаж байгаа нь сургалтын үр дүнг тодорхойлох боломжгүй байгаа хэлбэр юм.

Цагдаагийн алба хаагчийн бүх шатны мэргэжлийн алба хаагчийг сургах, бэлтгэх сургалт, цагдаагийн албаны сургалт хэдий тусдаа зохион байгуулагддаг боловч агуулгын хувьд харилцан хамааралтай, өмнөх сургалтын үр дүнд тулгуурлан хэрэгжих зүй тогтолтой байх шаардлагатай юм. Гэвч бодит байдалд энэ чанар огт хангагдахгүй байгаа нь өмнөх бүлгүүдэд дурдагдсан.

Цагдаагийн алба хаагчийг сурган бэлтгэх чиглэлээр үндсэндээ хоёр байгууллага хариуцан сургалтыг зохион байгуулж байна.

Энэ нь манай орны хууль сахиулах байгууллага тэр дундаа цагдаагийн байгууллагын сургалтын нэгж, алба хаагчдыг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллага нь тусдаа агентлаг бүхий тогтолцооноос бүрддэгтэй холбоотой.

Өөрөөр хэлбэл, алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгон хангаж буй байгууллага, практик байгууллага хоёр тусдаа үйл ажиллагаа явуулдаг нь уялдаа холбоо сулрах нэг нөхцөл бүрдэж байна.

Дэлхийн бусад оронд ихэвчлэн цагдаагийн байгууллага нь дотроо цагдаагийн алба хаагчдыг анхан шатны түвшинд сурган бэлтгэх нэгжтэй байдаг ба бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэг олгох сургалтыг энэ төрлийн их, дээд сургуулийг түшиглэн зохион байгуулдаг.

Харин манай орны хувьд бусад хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэх нэгдсэн их сургуулийн тогтолцоонд шилжсэн нь шинэлэг, өөр улсад байхгүй өвөрмөц тогтолцоог бүрдүүлж байна.

Энэ нь хууль сахиулах салбарын хувьд бусад агентлаг байгууллагын хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр харилцан туршлага солилцох, нэг дор үйл ажиллагаа явуулах зэргээр давуу талтай.

Гэвч практик байгууллага дахь албаны сургалтыг зохион байгуулж буй нэгжтэй үйл ажиллагаа уялдуулах нэн чухал шаардлагатайг мартаж болохгүй. Ингэснээр алба хаагчдыг тасралтгүй боловсрох, сургалтын тогтолцоог интеграци хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

Бид энэхүү судалгааны үр дүнд үндэслэн дээр дурдсан салангид сургалтын тогтолцоог нэгтгэн цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны загварыг боловсрууллаа.

Монгол хэлний тайлбар тольд²⁶ системчлэх гэснийг аливаа юмны тодорхой горим, тогтолцоонд оруулах, хамруулах гэж тайлбарласан бол ОХУ-ын эрдэмтэн Т.В.Кашанина “ямар нэгэн зүйлийг тодорхой эмх журамд оруулах” гэсэн байна.


Академич С.Нарангэрэл “төрөлжүүлсэн нэгтгэлт²⁷” гэж тодорхойлсон бол судлаач Б.Жамьян “системчлэл гэдэг нь ямар нэг зүйлд хамаарагдах өөрийн эхлэл, төгсгөлтэй, утга санааны хувьд хоорондоо нягт авцалдсан хатуу дэс дараалалтай бүрэлдэхүүний хэсгүүдийн нэгдмэл цогц гэсэн утгатай юм. Зохион байгуулалтын энэ зарчим дээр үндэслэж, материалын цуглуулга хийж, сонгон авсан материалаа ангилал схемийн дагуу байрлуулж, боловсруулалт, судалгаа шинжилгээ хийх замаар системчлэлийг бүтээдэг²⁸ гэжээ.

Эдгээр үзэл санаанд тулгуурлан цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог түвшнээр нь ангилж, тэдгээрийн уялдааг хангах байдлаар буюу нэг нэгнээсээ хамаарах нөхцөлийг бүрдүүлэн системчлэхийг зорьсон.

²⁶ Монгол хэлний их тайлбар толь. ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн. –Уб., 2015.

²⁷ Нарангэрэл, С. Хууль зүйн Ангил-Монгол эх толь. 50000 орчим нэр томъёо, хэллэг. –Уб., 2017. 120 дахь тал.

²⁸ Жамьян, Б. Бүгд Найрамдах Монгол Ард Улсад эрх хэм хэмжээ тогтоосон актуудыг ангилах ба эмхлэн цэгцлэх тухай зарим асуудалд. –Уб., 1967. 6 дахь тал.



Мөн дээрх загвараас тус бүрийн дэд тогтолцоо бүхий сургалтуудыг холбосон үйл явцын дэс дарааллыг харах боломжтой юм.

“Мэргэжлийн боловсрол олгох сургалт” гэж цагдаагийн алба хаагчийн бэлтгэх чиг үүрэг бүхий сургалтын байгууллагаас явуулах цагдаагийн байгууллагад ажиллуулах иргэдэд анхан шатны боловсрол олгох сургалтыг хэлнэ.

“Бакалаврын сургалт” гэж гэж цагдаагийн алба хаагчийн бэлтгэх чиг үүрэг бүхий сургалтын байгууллагаас явуулах цагдаагийн байгууллагад ажиллуулах иргэдэд дээд боловсрол олгох сургалтыг хэлнэ.

“Боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт” гэж цагдаагийн байгууллагад ажиллаж буй алба хаагчдыг ахисан түвшний буюу магистр, докторын зэрэг олгох сургалтыг ойлгоно.

“Ажлын байрны сургалт” гэж цагдаагийн алба хаагчид цагдаагийн төв байгууллагаас зохион байгуулах албандаа дасан зохицох, өдөр тутмын үйл ажиллагааг судлах, мэргэжлийн онцлогийг дадал болгож нэвтрүүлэх, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах онцлог зэргийг хамруулсан сургалтыг ойлгоно.

“Мэргэшүүлэх сургалт” гэж цагдаагийн байгууллагын шат дараалсан албан тушаалд дэвших, нөөцөд бүртгэгдсэн албан хаагчийг тухайн албан тушаалын онцлогт нийцүүлсэн мэргэшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг ойлгоно.

“Давтан сургалт” гэж алба хаагч тодорхой албан тушаалд дэвших нөөцөд бүртгэгдээгүй, ажлын үр дүнгээ гаргаж чадахгүй байгаа тохиолдолд эсвэл сахилгын шийтгэл,

бусад алдаа дутагдал гаргасан тохиолдолд засаж, сайжруулах чиглэлээр зохион байгуулах сургалтыг ойлгоно.

Ингэснээр зөвхөн зохион байгуулалт, дэс дараалал бүхий хэсэг байснаар сургалтын нэгдсэн байдлыг хангахгүй бөгөөд холбогдох хууль, дүрэм, журмыг өөрчлөн шинэчлэх хэрэгцээ, шаардлага ч бий болох юм.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, албаны сургалтууд нь цагдаагийн алба хаагчийн хүрээнд авч үзэх ойлголт тул цагдаагийн байгууллагын сургалт бус цагдаагийн алба хаагчийн сургалт гэж нэрлэх нь оновчтой байна. Нөгөө талаасаа цагдаагийн байгууллагын сургалт нь зөвхөн цагдаагийн байгууллагаас зохион байгуулах сургалтын хүрээнд ойлголт төрүүлэх магадлалтай юм.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог цагдаагийн алба хаагчид мэргэжлийн боловсрол олгох, боловсролын зэрэг дээшлүүлэх сургалтууд буюу их сургуулийн үйл ажиллагаа, албаны, давтан, мэргэшүүлэх сургалтууд буюу цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны нэгдмэл бүтэцтэй, дэс дараалан хэрэгжүүлэх шинжтэй байхаар загварчлах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнд цагдаагийн албаны холбогдох бүх асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг олгох нь цагдаагийн байгууллагын чадамж, үнэлгээг дээшлүүлэх нэг хүчин зүйл бөгөөд үүнийг сургалтаар буюу хэрэгжиж буй сургалтын тогтолцоог боловсронгуй болгосноор хангах боломжтой.

Бид цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо буюу дээрх загвараар цагдаагийн алба хаагийг бэлтгэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх бүхий л сургалтын тогтолцоог нэгтгэж, шат дараалсан байдлыг процессын зураглалаар харууллаа.

Харин сургалтыг бүрдүүлэх гол элементүүдэд тулгуурлан дээр дурдсан үе шатуудыг нэг бүрчлэн авч үзвэл эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтад өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлагуудыг тогтоох боломжтой гэж үзлээ.

Тухайлбал, мэргэжил олгох сургалтын тогтолцоонд бакалаврын сургалт хамаарах бөгөөд өнөөгийн байдлаар судалгаагаар тогтоогдож буй гол асуудал нь мэргэжлийн индекс зөрүүтэй байгаа явдал юм. Энэ нь Боловсролын тухай хууль, ажил мэргэжлийн ангилал тогтооход үүсэж байгаа асуудал юм.

Магистр, докторын сургалт буюу мэргэжил дээшлүүлэх сургалтын хувьд хамрагдах хүсэлтэй алба хаагчдад тэгш боломж олгох, нэгдсэн хэв шинж тогтоогүй зэрэг нь зохион байгуулалтад тулгарч байна. Мөн зарим албан тушаалд энэ төрлийн боловсролын зэрэг шаардагддаг хэдий ч практикт тэр болгон хэвшээгүй нь ажиглагдана.

Гэвч дээр дурдсан сургалтууд нь цагдаагийн байгууллага, хууль зүйн үүднээс зарим зохицуулалтад тохирохгүй байгаа хэдий ч хөтөлбөр, сургалтын орчин, чанарын үнэлгээ зэргээр үнэлбэл аль аль түвшинд магадлан итгэмжлэгдсэн бөгөөд боловсролын салбараас тавигдах шаардлага шалгуурт бүрэн нийцэж байгаа юм.

Дотоод хэргийн их сургуулийн хувьд 5 сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн бөгөөд эдгээр үйл ажиллагаа нь тухайн сургалтын байгууллага хөндлөнгийн

шинжээчээр сургалтын чанараа үнэлүүлэх үйл ажиллагаа бөгөөд шалгуур шаардлагад нь оюутан, төгсөгчид, ажил олгогчдоо судалдаг байхыг шаарддаг. Үүний дагуу тус сургууль сүүлийн 2 жилд олон төрлийн судалгааг авч байна. Судалгаа авч буй нь сайшаалтай хэдий ч сургалтын хөтөлбөр бүрийн хувьд өөр байгаа бөгөөд талуудын оролцоог хангаагүй байгаа нь цаашид энэ асуудлыг журамлаж шийдвэрлэх нь зүйтэйг харуулж байна.

Харин цагдаагийн алба хаагчдыг ажил, үүргээ гүйцэтгэж байх явцад зохион байгуулагдаж байгаа ажлын байрны, давтан, мэргэшүүлэх сургалтууд нь сургалтыг бүрдүүлэх элементийн хувьд учир дутагдалтай байна. Тухайлбал, сургалтуудын ангилал, зорилгыг нарийвчлан тогтоогоогүй, сургалтын хөтөлбөр батлагддаггүй, сургалтын орчин хомс, сургагч багш, судалгааны хэрэглэгдэхүүн дутмаг, сургалтын үр дүнг эргээд үнэлэх хяналтын тогтолцоо байхгүй байгаа нь сул тал болж байна.

Тээврийн цагдаагийн байгууллагын албаны сургалт нь сургалтын тогтолцооны нэг дэд тогтолцооны хэсгийг бүрдүүлэх бөгөөд нэг талаас цагдаа судлалын болон цагдаагийн эрх зүйн шинжлэх ухааны хүрээнд цагдаагийн байгууллагын эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаатай, нөгөө талаас тухайн бүс болон ажиллаж буй цагдаагийн албаны онцлогтой нягт уялдаа, холбоотойгоор шаталсан хэлбэрээр явагдах зүй тогтол бүхий хэлбэртэй байх нь оновчтой юм.

Тээврийн цагдаагийн алба хаагчийг давтан болон мэргэшүүлэх сургалтыг нэг дэд тогтолцоо болгон авч үзэж, “мэргэшүүлэх сургалт”, “давтан сургалт” гэсэн агуулгатай байх бөгөөд мэргэжил олгох сургалтаар болон албаны бэлтгэл сургалтаар олгогдсон мэдлэг, чадварын хүрээнд явагдахаар ангилах нь оновчтой байна.

Шат дараалсан албан тушаалд дэвших, нөөцөд бүртгэгдсэн албан хаагчийг тухайн албан тушаалын онцлогт нийцүүлсэн мэргэшүүлэх сургалтад, алба хаагч тодорхой албан тушаалд дэвших нөөцөд бүртгэгдээгүй, ажлын үр дүнгээ гаргаж чадахгүй байгаа тохиолдолд давтан сургалтыг хөгжүүлэх чиглэлээр тус тус зохион байгуулна.

Боловсролын зэрэг дээшлүүлэх сургалтын тогтолцоо нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр тус тус зохион байгуулагдах сургалтуудаас бүрдэнэ.

Иймд цагдаагийн хүний нөөцийг бэлтгэж ирсэн болон бэлтгэж байгаа байдал, цаашдын хөгжлийн хандлагыг судалсны үндсэн дээр цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх үйл ажиллагаа нь бие даасан цогц тогтолцоо, эрэмбэлэг чанартай, тасралтгүй, шаталсан шинжтэй болохыг онолын талаас нэгтгэн дүгнэлээ.

Өнөөгийн байдлаар цагдаагийн байгууллагад ажиллаж буй алба хаагчдын боловсролын түвшин, нөхөн хангаж буй байдалд дүн шинжилгээ хийхэд тэнцвэртэй байдал алдагдсан гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага нь дотроо сургалтын нэгжтэй бөгөөд энэ нь анхан шатны сургалтыг зохион байгуулж, хүний нөөцийн бодлогоо хэрэгжүүлдэг бөгөөд зарим нь бакалаврын түвшинд академи болон энэ төрлийн дээд сургуулийг хүртэл байгуулсан нь бий. Мөн үүнээс гадна цагдаагийн байгууллагын сургалтын нэгж нь бусад энгийн хууль,

эрх зүйн дээд сургуулийг түшиглэн суралцагчдад дээд боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг тогтолцоо хүртэл бий.

Ерөнхийдөө цагдаагийн алба хаагчийн хамрагдах сургалт дэлхийн улс орнуудад хэд хэдэн төрөл болж хэрэгжиж байна. Тухайлбал,:

- Анхан шатны сургалт;
- Ажилд авах үеийн;
- Жил бүрийн тогтмол сургалт;
- Мэргэжил дээшлүүлэх сургалт;
- Дадлагажилт;
- Ажлын байран дээрх сургалт;
- Ажил сэлгэх үеийн сургалт;
- Дагалдан сургалт;
- Зөвлөх сургалт;
- Ажлын байрнаас гадуурх сургалт зэргүүд багтаж байна.

Бид дээр дурдсан цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоонд эдгээр сургалтын ангиллаас багцлан хамгийн чухал гэсэн ангиллуудыг оролцуулж, үе шатанд хувааж, эрэмбэлэгдэх шинжийг бүрдүүлэхийг зорьсон.

Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт хамгийн эхний үе шат буюу цагдаагийн алба хаагчийг анхан шатанд бэлтгэх, бакалаврын боловсрол олгох сургалтууд байх шаардлагатай. Энэ нь дотроо хэд хэдэн хөтөлбөртэй байхыг цаг үеийн нөхцөл байдал, шинэ санаачилгаас үүдэн өөрчлөгдөж болно гэж үзлээ. Тухайлбал, өдрийн болон эчнээ хөтөлбөрүүд хэрэгжиж байсан бол сүүлийн жилүүдэд өмнө өөр мэргэжлээр их, дээд сургууль төгссөн иргэдийг 2 жилийн хугацаанд суралцуулж, цагдаагийн офицер болгон бэлтгэж байгаа шинэлэг хөтөлбөрийг хэрэгжүүлээд багагүй хугацаа өнгөрч байна.

Энэ нь цагдаагийн байгууллагын зарим алба нэгжид шаардлагатай нарийн мэргэжлийн чиглэлээр өмнө мэргэжил эзэмшсэн байх нөхцөлийг бүрдүүлж өгч байгаа төдийгүй, эдийн засгийн мөрдөгч, сэтгэл зүйч, кибер гэмт хэрэгтэй тэмцэх, мал хулгайлах гэмт хэргийг мөрдөх гэх мэт үндсэн сургалтад тэр бүр агуулгаар багтаагүй бусад мэдлэгийг эзэмшсэн элсэгч хамрагддагаараа онцлогтой байна.

Харин хоёр жилийн хөтөлбөрт элсэгч нь бакалаврын боловсролтой байх шаардлагатай бөгөөд голч дүн нь төрийн өмчийн сургууль бол 2.5, төрийн бус өмчийн сургууль бол 3.0-аас доошгүй байх, эдийн засаг, сэтгэл судлал, нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, даатгал, байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, мэдээлэл харилцаа холбооны технологи, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээгч, хөдөө аж ахуй мал эмнэл зүй, эрүүл мэнд, цэрэг, батлан хамгаалахын мэргэжил эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.

Хос мэргэжил шаардлагатай тохиолдолд энэ төрлийн сургалт ашиглаж байгаа нь давуу талтай байгаа боловч энэ чиглэлээр томилон ажиллуулахгүй байгаа нь практик ажиглагдаж байна.

Мөн цагдаагийн төв байгууллагын сургалт хариуцсан нэгжээс алба хаагчдад зохион байгуулах сургалтыг үндсэн гурав ангилсан. Эдгээр нь албаны, давтан, мэргэшүүлэх сургалтууд юм.

Эдгээрийг цааш нь өөр төрөлд ангилах шаардлагагүй гэж үзлээ. Тухайлбал, ажлын байрны, дасан зохицох, албаны бэлтгэл, хууль эрх зүйн, үргэлжилсэн зэрэг сургалтууд нь бүгд албаны сургалтын шинжийг агуулж байна. Харин тухайн алба хаагч өөрийн ажил мэргэжилдээ ахиц, дэвшилтэй ажиллаж байгаа, цаашид албан тушаал дэвших боломжтой, нөөцөд бүртгэгдсэн тохиолдолд мэргэшүүлэх сургалтад хамруулах нь зүйтэй.

Бусад тохиолдолд буюу ажил, чиг үүргийн хүрээнд амжилт гаргахгүй, алдаа дутагдал гаргах, сахилга хариуцлага алдах зэрэгт давтан сургалтыг зохион байгуулах чиглэлийг баримтлах хэрэгтэй гэж дүгнэж байна.

Сургалтын нэг шатнаас нөгөөд дэвшин суралцахад цагдаагийн алба хаагч өмнөх шатанд туршлагажсан байхыг шаарддагаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл, тактикийн жижиг салбарыг удирдаж чадахгүйгээр түүнд тодорхой хэмжээгээр туршлагажиж, ур чадвар эзэмшээгүйгээр тактикийн үндсэн салбарыг удирдах боломж байхгүйн зэрэгцээ үүнд заавал суралцах шаардлагатай болно.

Үүнээс үзэхэд, цагдаагийн байгууллагын хүний нөөц нь албан тушаал ахихын тулд тодорхой төвшинд сурч бэлтгэгдсэн ажлын туршлага, үйл ажиллагааны ур чадвар заавал эзэмшсэн байх шаардлагатай болдог учир сургалтын үйл ажиллагаа нь шаталсан тогтолцоотой байдаг зүй тогтолтой байна.

Энэ үндэслэлээр цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог цагдаагийн алба хаагчийг бэлтгэж, боловсрол олгож, мэргэжил эзэмшүүлэх “сургууль”-ийн, албан тушаалын ба мэргэжил дээшлүүлэх дамжааны, ажлын байран дээр нь сургаж дадлагажуулах “хичээлийн” гэсэн дэд тогтолцоонуудыг агуулдаг цогцолбор тогтолцоо гэж дүгнэлээ.

Мөн цагдаагийн өндөр албан тушаалын офицерууд, чөлөөнд гарсан бэлтгэл офицер, ахмад албан тушаалтнуудыг тодорхой зорилгоор бэлтгэх, цагдаагийн байгууллагын стратеги, техник технологийн судалгаа явуулдаг сургалт, судалгааны нэгжийг цагдаагийн төв байгууллагад тусгай бүтэцтэйгээр байгуулснаар төр, нийгмийн олон талт асуудлыг улсын хэмжээнд шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын шатлал нь цаашид:

- Албан тушаалын ба мэргэжил дээшлүүлэх;
- Боловсролын зэрэг дээшлүүлэх;
- Удирдлагын гэсэн дэс дарааллаар дамжина.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх боловсролын агуулга, гүнзгийрэлт, олон улсын жишиг Монгол Улсын Дээд боловсролын хуульд нийцэж байгаа боловч хичээлүүдийн интеграцчилал, дифференциалчлал, хичээлийн бүрэн төгс байдлыг үнэлж хичээлийн хөтөлбөрүүдийг стандартжуулах асуудлыг сургалтын чанарыг хангах гол хүчин зүйл гэж үзэж байна.

Дээр өгүүлснийг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Бид энэхүү судалгаандаа цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллага, цагдаагийн төв байгууллага сургалтыг ямар эрэмбэ дараалал бүхий тогтолцоотой хэрэгжүүлэх талаар авч үзэхийг чухалчилсан цагдаагийн алба хаагчийн

сургалтын тогтолцоо нь хэд хэдэн тодорхой үе шаттай, байгууллагуудын хамтарсан буюу эрэмбэ, дараалал бүхий зохион байгуулалттай байх шаардлагатай гэж дүгнэлээ.

Энэхүү судалгаагаар цагдаагийн алба хаагчийг мэргэжлийн боловсрол олгох түвшинд бэлтгэх чиглэлээр түлхүү анхаарал хандуулж байгаа боловч практикт ажиллаж буй алба хаагчдыг хөгжүүлэх, тэднийг давтан болон мэргэшүүлэх чиглэлээр сургах асуудал үр дүнгүй, нэгдсэн ойлголтгүйгээс гадна сургалтуудыг зохион байгуулж буй байгууллагуудын харилцан уялдаа, холбоо сул байгаа нь дээр дурдагдсан нөхцөл байдлыг үүсгэх гол шалтгаан болж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны загварыг шинээр боловсруулсан бөгөөд энэхүү тогтолцоо нь “Мэргэжил олгох сургалт”, “Албаны бэлтгэл сургалт”, “Давтан, мэргэшүүлэх сургалт”, “Боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт” гэсэн хоорондоо харилцаа хамаарал бүхий дэд тогтолцооноос бүрдсэн бүтэцтэй байх нь оновчтой бөгөөд тус бүрийн дэд тогтолцоо бүхий сургалтуудыг холбосон үйл явцын дэс дарааллыг харах боломжтой юм.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан, практикт хэрэгжүүлэх шаардлага тулгарсан бөгөөд сургалтын хэв шинжийн ерөнхий гол агуулга, түвшин, стандартыг тогтоож өгөх бөгөөд нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөөг сургалтын нэгдсэн зөвлөл үүсгэн боловсруулж, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх нь дэвшилттэй тал болно.

Цагдаагийн алба хаагчийг ахлагч, офицер, удирдах албан тушаалтан гэсэн зэрэглэлд ангилж, үе шатанд нь тохирсон сургалтыг зохион байгуулах, дээд шатны албан тушаалд ахих боломжийг мэдлэг, ур чадварын түвшинд үндэслэх боломж, шударга ил тод байдлыг нэвтрүүлэх нь тус үзэл баримтлалын гол шинж чанар болно гэж үзэж байна.

Мөн алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх, боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт нь алба хаагчийн өөрийн хүсэл, эрмэлзэлд суурилах шаардлагатай бөгөөд хүчээр, албадан сургах сургалт үр дүнгүй болдог нь судалгаагаар тогтоогдсон билээ.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Тээврийн цагдаагийн албаны зорилго, нийгэмд гүйцэтгэдэг үүргийн талаар хууль дээдлэх ёсны дагуу төрийг төлөөлөх, нийгмийн хэм хэмжээг сахиулах, шаардах, албадах, хуулийг хэрэгжүүлэхэд чиглэдэг онцлогтой байдаг бол нийгмийн хяналтын онолын үүднээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгмийн нэг төрлийн хяналтын хэсгийг бүрдүүлэгч гол хүчин зүйл мөн бөгөөд хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд албадлага хэрэглэх, бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлах, боломжтой.

Орчин үеийн тээврийн цагдаагийн алба нь хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэдэг мэргэжлийн бүтэц, зохион байгуулалттай байх, орон тооны мэргэшсэн алба хаагчидтай байх, үйл ажиллагааг нь зохицуулсан эрх зүйн акттай байх зэрэг хэд хэдэн шинжийг бүрдүүлсэн байдаг ба алба хаагчдын мэргэшил, боловсрох, тэднийг сургах, бэлтгэх, хөгжүүлэх асуудал нь хууль сахиулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн үндэс болдог нь эрдэм судлаачдын үзэл баримтлалд харьцуулсан үр дүнгээр илэрч байна.

Бид судалгааны ажлын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж, тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын үйл ажиллагааны өнөөгийн байдал, тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, практик хэрэглээний нөхцөл байдлыг судалж үзсэнээр дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Цагдаагийн төв байгууллагаас жил бүр цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлдэг хэдий ч хэрэгжүүлж буй сургалтын үйл ажиллагаа тогтворгүй, нэгдсэн стандартгүй, сэдэв, ангилал, хүрэх үр дүн тодорхойгүй байгаа нь ажиглагдаж байна.
2. Алба хаагчийг бэлтгэх, хөгжүүлэх сургалтын тогтолцоог алдаатай ангилсан нь сургалтуудын уялдаа холбоо, ялгаа заагийг тогтооход хүндрэл учруулж байгаа бөгөөд цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог дүгнэхэд уялдаа хол буюу тус тусын сургалтын байгууллага тус тусдаа сургалтаа зохион байгуулж байна.
3. Судалгааны ажлын үр дүнг хэрэгжүүлэлт харьцангуй сул байгаа нь ажиглалт, санал асуулгын дүнгээр илэрч байна. Учир нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь дан ганц судлаач, байгууллагын үйл ажиллагаа бус олон төрлийн салбарын хамтын ажиллагааг шаарддаг онцлогтой билээ.
4. магистрын судалгааны ажлын чанар сул, хэрэгжилт тааруу байдгаас гадна судалгааны ажлын сэдэв, агуулга маш их давтагдаж байна нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил, оюуны өмчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сул, нөгөөтээгүүр хуулбарлалтыг шалган тогтоох үйл ажиллагаа харьцангуй сүүлд нэвтэрч эхэлж буйтай холбоотой юм.
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг авч үзсэн бүтээлүүдийн 60% нь 2000 оноос хойш бичигдсэн байгаа нь тухайн үеэс замын хөдөлгөөний асуудлыг тулгамдсан асуудалд тооцож, судлаачид өнөөгийн нийгмийн гол асуудлыг урьдчилан сэргэмжлүүлж эхэлж байсантай холбож үзэж болох юм.
6. Эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэн судлаачид мэргэжлийн чиглэлээр ном бүтээл харьцангуй бага эрхлэн гаргаж байна гэж дүгнэлээ. Сургалтад хэрэглэж байгаа

сурах бичиг, гарын авлага хэт хуучирсан бөгөөд бэлтгэгдэж буй алба хаагчидад унших судлах материал хомс зэрэг асуудлууд урган гарч болхоор байна.

7. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Боловсролын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоод хэргийн их сургуулийн захирал дангаар болон хамтарсан байдлаар батлан хэрэгжүүлж байгаа эрх зүйн актууд нь цагдаагийн алба хаагчийн сургалт, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулж байна. Үүнээс үзвэл, тээврийн цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх талаар алба хаагчийн сургалтын тогтолцоо, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн эх сурвалж, баримт бичиг, хууль тогтоомжууд хангалттай мэт байгаа боловч нэгдсэн тогтолцоог бүрдүүлээгүй, сургалтууд нь зөвхөн тухайн нэг үе шатны боловсролыг олгоход чиглэж байгаа нь хоорондын уялдаа, залгамж холбоог хангахгүй байх гол нөхцөл болж байна.
8. Тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалт, хүний нөөцийн бодлого, холбогдох дүрэм, журмуудын заалтууд агуулгын зөрчилтэй, хэрэгжилтийн зөрчилтэй байгаа нь эрх зүйн зохицуулалтын өнөөгийн нөхцөлд хийсэн дүн шинжилгээгээр тогтоогдож байна.

САНАЛ

Судалгааны үр дүнд хийсэн дүгнэлтэд түшиглэн цаашид тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалт, судалгааны чиглэлийг тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, харилцан уялдааг хангах үүднээс тодорхой саналыг дараах чиглэлээр боловсрууллаа.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад алба хаагчийг бэлтгэх, давтан бэлтгэх сургалтын тогтолцоог загварчлах, тус тусын буюу өөр хоорондоо захиалга төдий өгөх байдлаар харилцаж буй агентлаг байгууллагуудын үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагаанд хамтрах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилан урт болон богино хугацааны сургалтуудын эрэмбэ, дараалал, ажлын байранд нь шаардагдах сургалтуудыг журамлан зохион байгуулах;

2. Тогтолцооны загварын дагуу тээврийн цагдаагийн алба хаагчийн сургалтын процессын үйл ажиллагааг алдагдуулахгүй байх хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, ашиглах;

3. Цагдаагийн төв байгууллагын сургалт хариуцсан нэгж буюу институтийн орон тоо, албан тушаалыг шинээр байгуулж, сургалтуудын үр дүнг үнэлэх, эргэх холбоог хангах, үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй явуулах нөхцөлийг хангах;

4. Цагдаагийн албаны бэлтгэл, давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, сэдвүүдийг хөгжүүлэх, тогтмол болон үе шаттай хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг ангилан зохион байгуулж, алба хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийж хэвших;

5. Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны загварыг шинээр боловсруулсан тогтолцоо нь “Мэргэжил олгох сургалт”, “Албаны бэлтгэл сургалт”, “Давтан, мэргэшүүлэх сургалт”, “Боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт” гэсэн хоорондоо харилцаа хамаарал бүхий дэд тогтолцооноос бүрдсэн тогтолцоотой байх нь оновчтой бөгөөд тус бүрийн дэд тогтолцоо, элементийн бүрдлийг харгалзан эрх зүйн зохицуулалтыг хангах;

6. Сургалт, судалгаанд ашиглаж буй орчуулгын материалуудад зохих үнэлэлт, дүгнэлт өгч, эрдэм шинжилгээний хурал, магистр, докторын судалгааны ажлын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр практик байгууллагуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах;

7. Салбарын эрдэмтэн судлаачдын судалгаа, шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлийн магистр, докторын ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, ном бүтээл эрхлэн гаргах ажлыг эрчимжүүлэх;

8. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй албаны сургалтын төрлүүдийг түвшин, хугацаа, зохион байгуулалтын талаар шинэчлэх шаардлагатай бөгөөд ангилал тус бүрд бүрдлийг ханган, цахим сан үүсгэж, алба хаагчдыг хамрагдах боломжийг бүрдүүлэх зэргийг журмаар зохицуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

9. Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, үйл ажиллагааг зохицуулсан Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бөгөөд цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны ойлголтыг бусад нөхцөл байдлаас ялгах, практикт зөв хэрэглэх нь хууль сахиулагчдын онолын мэдлэг, ур

чадварыг дээшлүүлэх, сургалтын тогтолцоог эргэлтэд оруулах, цаашид хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, хууль тогтоомжийн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №01. 1992
2. Боловсролын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №19. 2002
3. Дээд боловсролын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №19. 2002
4. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №10. 2009
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №42. 2019
6. Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №01. 2018
7. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №8. 2017
8. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. №8. 2017
9. Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааны журам. 2022
10. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2022

Хоёр. Бодлогын баримт бичиг

11. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. -Уб., 2010
12. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
13. “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр” (Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор баталсан)

Гурав. Сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага

15. Авдай, Ч., Энхтуяа, Д. Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй. –Уб., 2010
16. Ариунаа, С. Албан бус боловсролын төв. Насанд хүрэгчдийн боловсрол. –Уб., 2009
17. Баасандорж, С. Сургалтын арга, эрэл, олз. –Уб., 2008
18. Батдаваа, Д., Ганбаатар, Г. Цагдаагийн албаны үйл ажиллагааны эрх зүйн үндэс. -Уб., 2014
19. Батдаваа, Д. Цагдаагийн албаны үйл ажиллагааны эрх зүйн үндэс. -Уб., 2012
20. Болдбаатар, Ж., Төрмандах, З. Эрүүгийн эрх зүй: ерөнхий ба тусгай анги. -Уб., 2008
21. Болдсайхан, Б. Системийн онолын үндэс (системийн аюулгүй байдлын асуудлууд). -Уб., 2008.
22. Болдсайхан, Б. Системийн аюулгүй байдлын асуудлууд. -Уб., 2008
23. Бэгз, Н. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. –Уб., 2008 Гүнсэн, Р., Сэнгэдорж, Б. Цагдан сэргийлэхийн түүхэн өгүүлэл. –Уб., 1979
1. Даваа, Ж. Сургалтын технологи. -Уб., 2017
2. Даваасамбуу, Б., Думбурай, А., Сэнгэдорж, Б., Сайжаа, Р., Тархаашин, Д. Энх амгалангийн манаанд. –Уб., 1971
24. Ичинхорлоо, Ш. Насанд хүрэгчдийн сургалтын гарын авлага. –Уб., 2013
25. Ичинхорлоо, Ш. Сургалт. –Уб., 2005
26. Ичинхорлоо, Ш. Сургалтын арга зүйн шинэчлэл. –Уб., 2013
27. Ичинхорлоо, Ш., Эрдэнэцэцэг, С. Багш боловсролын үндэс.-Уб., 2011
28. Макото, Т. Монголын мартагдсан түүх. Богд хаант засгийн газар. –Уб., 2011
29. Монгол ардын журамт цэргийн дургалууд. Тэргүүн дэвтэр. –Уб., 1982
30. Монгол Улсын Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам”, (Баримт бичгийн эмхэтгэл), (1911-1919), –Уб., 2011
31. Монгол Улсын хууль зүйлийн бичиг. –Уб., 2011

32. Оюун, Ц. Их, дээд сургуулийн үйл ажиллагааны онол, арга зүй. -Уб., 2015
33. Пүрэвдорж, Ч. Багшлахуйн менежмент. –Уб., 2011
34. Пүрэвдорж, Ч. Боловсролын тогтолцоо олон улсад. -Уб., 1999.
35. Роберт, А. Хорьдугаар зууны Монголчууд. –Уб., 2000
36. Сувдмаа, Т. Зайны сургалт. –Уб., 2003
37. Тогтохмаа, З. Албан бус боловсролын бичиг баримтын эмхэтгэл. –Уб., 2011
38. Урангуа, Ж. XX зууны эхэн үеийн Монгол Улс (1911-1919). –Уб., 2006
39. Урангуа, Ж. XX зууны Монгол Улс (1911-1919). –Уб., 2010
40. Уянга, С. Системийн шаардлагын шинжилгээ. -Уб., 2016.
41. Хоролсүрэн, М. Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа. –Уб., 2004
42. Хүрэлбаатар, Т., Дулаанжаргал, А., Отгонбаатар, Г. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхэтгэл. –Уб., 2016
43. Цагдаагийн байгууллагын түүх I боть. -Уб., 2021
44. Цагдаагийн байгууллагын түүх II боть. -Уб., 2021
45. Цагдаагийн байгууллагын түүх III боть. -Уб., 2021
46. Цээпил, С. Мэргэжлийн боловсрол, сургалтын сургах зүй. –Уб., 2005
47. Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. –Уб., 1966

Дөрөв. Докторын диссертац

48. Г.Ринчиндорж ТУ-ны доктор (Ph.D) “Ачааны автомашины тормозны системийн ажиллагаанд хийсэн судалгаа” Москва 1981
49. Ш.Бямбаа ТУ-ны доктор (Ph.D) “Спектр судалгааны аргаар цэргийн автомашины нөөц явалтыг тодотгож, тохируулах аргачлал боловсруулах” ЦАТТА-д Ленинград 1986.
50. Шинжлэх ухааны доктор/Sc.D/-ын сэдэв: “Цэргийн автомашины найдварт ажиллагааны шинжлэх ухааны үндэс” ЦАТТА-д Санкт-Петербург 1995
51. Т.Занашир ТУ-ны доктор (Ph.D) “Зам тээврийн ослын хар цэгийн судалгаа” Эрхүүгийн ТИС Иркутск 2000 он
52. Х.Доржпалам Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал. УБ 2000 он
53. Ч.Жаргалсайхан ТУ-ны доктор (Ph.D) “Жолоодлогын тусгай талбай ашиглан жолооч бэлтгэх үйл ажиллагааг эрчимжүүлэх” ШУТИС Улаанбаатар хот 2002 он
54. Д.Нямдорж ХЗУ-ны доктор (Ph.D) “Монголд улсад хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн зөрчил, тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологийн шинж” 2009 он
55. Н.Ганбат ТУ-ны доктор (Ph.D) “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зарим хүчин зүйлийн судалгаа” ШУТИС Улаанбаатар 2018
56. М.Ариунболд ТУ-ны доктор /Ph.D/ “Зохицуулдаггүй явган хүний гарц дээр явган хүний аюулгүй байдлыг дээшлүүлэх” ШУТИС Улаанбаатар 2021 он

Тав. Эрдэм шинжилгээний өгүүлэл

Зургаа. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, тайлан, архив

57. Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замнал, хөгжлийн чиг хандлага. 2019
58. Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны үйл ажиллагааны тайлан
59. Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

60. Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан
61. Хууль зүйн боловсролын тулгамдаж буй асуудал, хөгжлийн чиг хандлага. 2021
62. Хууль зүй, дотоод хэрэг, онцгой байдлын салбарын боловсролын тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлага. 2022
63. Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, Цагдаагийн шинжлэх ухааны зарим нэр томъёоны гарын авлага. –Уб., 2017
64. Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны тайлан 2017
65. Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны тайлан 2018
66. Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны тайлан 2019
67. Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны тайлан 2020
68. Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны тайлан 2021
69. Цагдаагийн ерөнхий газрын хүний нөөцийн судалгаа. 2022 он
70. Монгол Улсын Үндэсний төв архив.
71. ТЕГ-ын тусгай архив

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АЖЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨӨЛӨЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ (2023-2026 ОН)

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт, судалгааны ажлыг сайжруулах төсөөлөл



Институтийн бүтэц, орон тооны төсөөлөл

№	Албан тушаалын нэр	Гүйцэтгэвэл зохих “А” багц цаг
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын институт		
1	Захирал	
замын хөдөлгөөний аюулгүй байдал судлалын төв		
2	Төвийн эрхлэгч	1
3	Эрдэм шинжилгээний ажилтан	2
4	Эрдэм шинжилгээний ажилтан	2
Замын хөдөлгөөний хяналтын арга зүйн тэнхим		
5	Эрхлэгч	12
6	Дэд профессор	14
7	Ахлах багш	16
8	Техникч лаборант	
Зам тээврийн ослыг шалгах процессын тэнхим		
9	Эрхлэгч	12
10	Дэд профессор	14
11	Ахлах багш	16
12	Лаборант	
Нийт 12 албан хаагч		89

Замын цагдаагийн сургуулийн багш нарт тавигдах шаардлага:

1. Авто инженер, Мэдээллийн статистикч, замын зохион байгуулалтын инженер, Эрх зүйч /хосолсон байх/ магистраас дээш зэрэгтэй 5-дээш жил мэргэжлээрээ ажилласан
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлаар мэргэшсэн, эрх зүйч мэргэжилтэй

3. Зам тээврийн осол, гэмт хэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн байх

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр 2022-2024 оны эрдэм шинжилгээний ажлын төсөөлөл

д/д	Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026	2027	2028
1	Докторын ажил	4	1	3	2	4		
2	Магистрын ажил	1	3	4	5	6	6	7
3	Эрдэм шинжилгээний олон Улсын хурал	0	1	1	1	2	2	3
	Эрдэм шинжилгээний Улсын хурал	0	1	1	1	2	2	2
4	Ном сурах бичиг, гарын авлага	0	1	1	1	1	1	2
5	Гадаадын сэтгүүлд	1	1	2	2	2	2	2
6	Өгүүлэл дотоодын сэтгүүлд	1	2	3	4	5	6	8
7	ЗХАБ-ын мэргэшүүлэх хөтөлбөрөөр төгсөгч	20	7	20	20	20	20	20

Дээрх төсөөллөөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог бий болгосноор мэргэжлийн алба хаагчаар хангагдаж, зам тээврийн осол шалгах үйл ажиллагаанд ахиц гарч, замын хөдөлгөөний хяналт сайжирч, үйл ажиллагааг боловсронгуй болгоход анхаарч хэвшмэл энгийн урсгалаараа явагддаг замын хөдөлгөөний аюулгүй байдлын цогц үйл ажиллагаанд өөрчлөлт гарах үндэслэлтэй юм.

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР
2022-2024 ОНЫ ХООРОНД ХИЙХ АЖЛУУД (КАЛЕНДАРЬЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ)**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2022-2024 онд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна:

23. Хүснэгт

Үйл ажиллагааны зорилт: 1		“Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах”				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон улсын жишигт нийцсэн эрх зүйн болон эдийн засгийн хосолсон зохицуулалтыг бүрдүүлнэ;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай “Цагаан ном”-ыг боловсруулан, гаргана.	Цагаан ном хэвлэгдэж, нийтийн хүртээл болсон байна.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ, ХЗДХЯ, ЭМЯ	2022 оны 1 дүгээр улирал
2.		Хот байгуулалтын тухай хуулийг УИХ-аар батлуулан, түүнд нийцүүлсэн журамд өөрчлөлт оруулж, түгжрэлийн, зогсоолын төлбөрийг албан үүргээ гүйцэтгэж байгаа тусгай дуут дохио хэрэглэсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тээврийн хэрэгслээс бусад	Албан тушаал, ажлын байрны онцлог үл харгалзан авто замын болон зогсоолын төлбөр тогтоох эрх зүйн зохицуулалттай болсон байна.	БХБЯ, СЯ	ЗТХЯ, ХЗДХЯ, Нийслэлийн засаг дарга	2022-2024

		тээврийн хэрэгсэлд ногдуулдаг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүрэг хэрэглэнэ.				
3.		Замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж боловсронгуй болгох.	Үнэлгээ хийгдэж, зөвлөмж гаргасан байна.	Үндэсний зөвлөл, ЗТХЯ	ХЗДХ, ЭМЯ	2022 оны 2 дугаар улирал
4.		Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохион байгуулахад холбогдох яам, засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурал төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Заагдсан байгууллагууд төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Үндэсний зөвлөл НЗДТГ	ЗТХЯ, ХЗДХЯ Харьяа агентлаг ууд	2022 оны 1 дүгээр улирал
5		“Авто замын сүлжээг өргөтгөж, шинэчлэн, түгжрэлийг бууруулах хүрээнд” хотын гол, тойрог болон туслах гудамж замуудыг шинээр болон өргөтгөн шинэчлэх, уулзваруудын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, нүхэн гарц, холбоос замууд, авто зогсоолыг нэмэгдүүлэх.		Үндэсний зөвлөл НЗДТГ Нийслэлийн төсвөөс 420 тэрбум төгрөг	БХБЯ, ЗТХЯ, ХЗДХЯ	2022-2024
6.		“Дугуйт тээврийн хэрэгсэл болон тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай хийгээд эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”-т нэгдэн	Олон улсын хэлэлцээрт нэгдэн орсон байна. Тус хэлэлцээрийн 144 хавсралтаас нэн шаардлагатай 50 стандартыг нутагшуулсан байна.	ЗТХЯ	ХЗДХ, СХЗГ	2022-2024

		орно.				
7.		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой шилдэг туршлага, эрх зүйн хэм хэмжээ, стандарт норм, дүрмийг судлан нутагшуулах.	2-оос доошгүй судалгаа хийж, өндөр хөгжилтэй улсад ашиглаж буй 1-ээс багагүй туршлагыг хэрэгжүүлсэн байна.	ЗТХЯ	ХЗДХ, СХЗГ	2022-2024
8.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, чадавхыг бэхжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг цогц байдлаар шинжлэн судлах бие даасан, хараат бус тогтолцоог бүрдүүлнэ;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл”-ийн хуралдааныг 2-оос доошгүй удаа зохион байгуулна.	Үндэсний зөвлөл хуралдаж холбогдох шийдвэр гарсан байна.	ЗТХЯ	ХЗДХЯ	2022-2024
9.		Зам тээврийн ослыг шинжлэн шалгах үйл ажиллагааг боловсронгуй болгохтой холбоотой хэлэлцүүлэг, онол практикийн бага хурал зохион байгуулна.	Зам тээврийн ослыг шинжлэн шалгахтай холбоотой хэлэлцүүлэг хийгдэж, зөвлөмж гаргаж холбогдох байгууллагад хүрсэн байна.	ЗТХЯ	ХЗДХЯ	2022 оны 2 дугаар улирал
10.		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдыг давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулах.	Салбар тус бүрт 3-аас доошгүй сургалт зохион байгуулсан байна.	ЗТХЯ, ХЗДХЯ	БШУЯ, ХНХЯ	2022-2024
11		“Зам тээврийн ослыг шинжлэн шалгах албыг байгуулах эрх зүйн орчныг бий болгоно.	АТТухай хуульд холбогдох санал туссан байна.	ЗТХЯ	БШУЯ, ЭМЯ, ЦЕГ-ын ШША, ТЦА	2022-2024

12.		Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо – Зааврыг хэрэглэх хэрэгцээ шаардлага MNS ISO 39001 : 2014 стандартыг хэрэгжүүлнэ.	MNS ISO 39001:2014 стандартын шаардлага хангагдсан байна	ЗТХЯ	ХЗДХЯ, БШУЯ, ХНХЯ,ЭМЯ, МХЕГ, Нийслэл , аймгуудын засаг дарга нар	2022-2024
13.	Замын хөдөлгөөн зохион байгуулалтын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэргэжилтэн, тээврийн эдийн засагч нарыг гадаадын их дээд сургуульд бэлтгэх, цаашид дотоодын их дээд сургуульд бэлтгэх замаар хүний нөөцийг бүрдүүлэх;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөн зохион байгуулах чиглэлээр 3-аас доошгүй хүнийг гадаадад сургахад бодлого, эдийн засгаар дэмжих.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөн зохион байгуулах чиглэлээр судалгаа шинжилгээ хийж байгаа хүмүүсийн судалгааг ашиглаж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	БШУСЯ	ЗТХЯ, ХЗДХЯ	2022-2024
14.		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохион байгуулах сургалтыг байгууллагын удирдлага, мэргэжилтэн, судлаач, хэрэглэгч нарын төвшинд жилд 3-аас доошгүй сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	Холбогдох төлөвлөгөө, удирдамжийн дагуу сургалт зохион байгуулсан байна.	ЗТХЯ, ХЗДХЯ, ЭМЯ	Нийслэл , аймгийн засаг дарга нар	2022-2024
15.		Замын хөдөлгөөнд хяналт тавьдаг замын цагдаа, авто тээврийн улсын байцаагч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарт эрх зүйн мэдлэг олгохоос гадна ёс зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулна.	Холбогдох сургалтууд төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.	МХЕГ, ТЦА, АТҮТ	Нийслэл , аймгийн засаг дарга нар	2022-2024

16.		Зам тээврийн ослыг цогц байдлаар судлах судалгааны ажлыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг их дээд сургуулиудад захиалга өгч хийлгэх.	Зам тээврийн ослыг цогц байдлаар судлах судалгааны ажлыг их дээд сургуулиудад хийгддэг болсон байна.	БШУЯ	ЗТХЯ, ХЗДХ, ЭМЯ	2022-2024
17.		Зам тээврийн осол, зөрчлийг бүртгэх нэгдсэн системийг нэвтрүүлж, судалгаа, шинжилгээ хийхэд шаардлагатай өгөгдөл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгоно.	Зам тээврийн осол, зөрчлийг бүртгэх нэгдсэн систем бий болж, судалгаа шинжилгээнд ашиглагдсан байна.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ, ХЗДХ, ЭМЯ	2022-2024
18.	Судалгаа, шинжилгээ, төлөвлөлтөд суурилсан замын хөдөлгөөн зохион	Зам тээврийн ослыг судлах чиглэлээр гадаад дотоодод сурч байгаа магистр, докторуудад бодлогын дэмжлэг үзүүлнэ.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2-3 хүн магистр, докторын зэрэг хамгаалсан байна.	БШУЯ	ЗТХЯ, ХЗДХ, ЭМЯ, Их, дээд сургуул иуд	2022-2024
19.	байгуулалтын оновчтой зохицуулалтыг нэвтрүүлэх, замын хөдөлгөөний удирдлага зохицуулалтыг боловсронгуй болгох	Сургууль, цэцэрлэгийн орчныг хөдөлгөөний эрчим ихтэй авто замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг ашиглах.	Сургууль, цэцэрлэгийн орчин болон ачаалал ихтэй гудамж, авто замын аюулгүй байдал хангагдсан байна.	ЗТХЯ, БХБЯ	ХЗДХЯ, ЭМЯ Аймаг, нийслэл ийн засаг дарга	2022-2024
20.		Замын хөдөлгөөнийг зохион байгуулахтай холбоотой судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Нэгээс доошгүй судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	БХБЯ	ЗТХЯ, ХЗДХЯ	2022-2024
21.		Тээврийн хэрэгслийн идэвхтэй, идэвхгүй, ослын дараах аюулгүй байдлыг шалгах иж бүрэн лаборатори, судалгааны төвийг барьж байгуулах ажлыг эхлүүлж ТЭЗҮ боловсруулна.	Тээврийн хэрэгслийн идэвхтэй, идэвхгүй, ослын дараах аюулгүй байдлыг шалгах иж бүрэн лаборатори, судалгааны төвийн ТЭЗҮ-г дуусгана.	ЗТХЯ	АТҮТ	2022 оны 4 дүгээр улирал
Үйл ажиллагааны зорилт: 2		“Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах”				

22.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоногдсон зам, явган хүний гарцыг нэмэгдүүлнэ.	Нийслэл, аймаг бүрд хэрэгжсэн байна.	ЗТХЯ	ЗТХТ Нийслэл, аймгийн засаг дарга	2022-2024
23.	Явганаар болон унадаг дугуйгаар зорчих, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан, бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлийг бүрдүүлэх;	Бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнөөс тусгаарласан унадаг дугуйн замын уртыг нэмэгдүүлнэ.	1км-ээс багагүй урттай зөвхөн унадаг дугуйгаар зорчиход зориулсан зам барьсан байна.	Нийслэл, аймгийн засаг дарга	БХБЯ	2022-2024
24.		Явган хүний гарцын техникийн шаардлага, стандартад өөрчлөлт оруулж хэрэгжүүлсэн байна.	Явган хүний гарам, гарцыг тооцоо, судалгааны үндсэн дээр цогц байдлаар шийдвэрлэх. Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацын арга хэрэглэн тоноглох. Шөнийн харанхуй үед замын бусад хэсгээс илт ялгарах техникийн шийдлийг бий болгох, холбогдох стандартыг шинэчлэн, хэрэгжүүлнэ.	БХБЯ, ЗТХЯ	Аймаг, нийслэлийн засаг дарга	2022-2024
25.		Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн талаарх Европын хэлэлцээр /AETR/-т нэгдэн орно.	Хэлэлцээрт нэгдэн орсон байна.	ЗТХЯ	ГХЯ, ХЗДХЗ	2022-2024
26.	Жолоочийн сахилга хариуцлага сул байдлаас шалтгаалсан зам тээврийн ослыг бууруулах;	Жолоочийн ажил, амралтын дэглэмтэй холбогдсон шаардлагыг мөрдүүлэх, жолоочийн ядаргаанаас үүсэлтэй шалтгаалсан зам тээврийн ослыг бууруулна.	Жолоочоос хамаарсан зам тээврийн ослын тоо буурсан байна. /Судалгаа хийнэ/	ЗТХЯ	МАТНХ, Судалгааны байгууллагууд, Их дээд сургуулиуд	2022-2024

28.		Зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчилд судалгаа хийж ноцтой, зам тээврийн осол, түүний үр дагаварт нөлөөлж байгаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх компани ажил зохион байгуулна.	Холбогдох судалгааны үндсэн дээр жилд 1-ээс доошгүй компани ажил хийгдсэн байна.	ХЗДХЯ, ЭМЯ АЖДХ	ЗТХЯ, НЭМХ, ТЦА, АТҮТ	2022-2024
29.		Жолоочийн зөрчлийн бүртгэлд оноо тооцох, зөрчил болон ослын бүртгэлийг даатгалын системтэй уялдуулах	Жолоочийн гаргасан зөрчил, осол гаргасан байдал нь даатгалын эрсдэлийн үнэлгээнд нөлөөлдөг нөхцөл бүрдэж, хэрэгжсэн байна.	ЗТХЯ, СЗХ, ЦЕГ, АТҮТөв	ХЗДХЯ	2022-2024
30.		Замын хөдөлгөөнд оролцогчдын зөрчлийг иргэдийн мэдээллээр “E-Police” аппликейшн ашиглан зөрчилд арга хэмжээ тооцох ажлыг эрчимжүүлэх, Зөрчлийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авах журмыг батлуулах	Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх техникийн шийдлийг бий болгоно. Техникийн шийдлийг ашиглах хууль, журмыг батлан хэрэгжүүлнэ.	ХЗДХЯ СЯ	ХЗДХЯ, ЦЕГ, ТЦА	2022-2024
31		Жолоочийн зөрчилд хариуцлага тооцох онооны үзүүлэлтүүдийг чангаруулах	Зөрчил гаргасан жолоочид тооцох хариуцлагын системийг шинэчлэсэн байна.	ХЗДХЯ ЗХАБҮЗ	ЦЕГ	2022-2024
32		Замын хөдөлгөөний ноцтой зөрчсөн, замын хөдөлгөөнийн түгжрэл сааталд нөлөөлөх, урсгал сөрсөн, уулзвар руу улаан гэрлээр орсон зэр үйлдэлд жолоодох эрх хасах эрх зүйн тогцтолцоог бий болгож хэрэгжүүлэх.	Ноцтой зөрчил гаргасан жолоочид тооцох эрх хасах зүйл заалтууд нэмэгдсэн байна.	ХЗДХЯ ЗХАБҮЗ	ЦЕГ	2022-2024
33.	Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшүүлэх	Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх жишиг төвийг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих	Эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Улаанбаатарт 1, орон нутгийн хэмжээнд 1-ээс	БШУЯ, ХЗДХЯ, ЗТХЯ	ЦЕГ, АТҮТ, БХТӨв	2022-2024

	тогтолцоог боловсронгуй болгох	замаар байгуулах асуудлыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.	багагүй төвийг байгуулсан байна.			
34.		Жолооч бэлтгэх арга, хөтөлбөр, тогтолцоог боловсронгуй болгох, мэргэшүүлэх, шалгах үйл ажиллагаанд хүнээс хамаарсан хамаарлыг багасгаж, ЕХУ, БНСУ, АНУ зэрэг улсуудад хэрэглэж байгаа программ хангамж, тоног төхөөрөмжөөр хангана.	Жолоочийн шалгалтын үйл ажиллагаа ЕХУ, БНСУ, АНУ-ын тухайн үеийн жишигт хүрсэн арга хэрэгслийг ашиглаж эхэлсэн байна.	БШУЯ, ХНХЯ, ХЗДХЯ, ЗТХЯ	ЦЕГ, АТҮТ, БХТөв	2022-2024
35.		Олон Улсын Авто тээврийн Холбооны жолооч, менежер, тээврийн байгууллагын удирдах ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлнэ.	Олон улсын жишигт нийцсэн хүний нөөцийг бүрдүүлсэн байна.	ЗТХЯ, БШУЯ	ХЗДХЯ, АТҮТ, НТГ, Төрийн бус байгууллагауд	2022-2024
36.	Боловсролын тогтолцооны бүх шатны сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг тусгах замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлнэ;	Хүүхдүүдийн дунд уламжлан болгон зохион байгуулдаг “Ногоон гэрэл, цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээн болон бусад хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулна.	Уралдаан тэмцээн зохион байгуулсан байна	ГХУСЗ БШУЯ, Аймаг, нийслэлийн засаг дарга	ХЗДХЯ, ТЦА, ЗТХЯ	2022-2024
37.		Ерөнхий боловсролын сургуулийн сурагч бага наснаасаа Замын хөдөлгөөний дүрэм үзэж, жолоодлогын дадлага хийж, 18 нас хүрэхдээ жолоочийн шалгалт өгдөг байх нөхцөл бүрдүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийнэ. .	Холбогдох судалгаа хийгдсэн байна.	БШУЯ ЗХАБҮЗ-ийн Ажлын алба	ХЗДХЯ, ЗТХЯ	2022 оны 2-3 дугаар улирал
38.		Боловсролын тогтолцооны бүх шатны сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг боловсруулагдан батлагдаж	БШУЯ, ХНХЯ	ХЗДХЯ, ЗТХЯ	2022-2024

		дээшлүүлэх сургалтыг оруулж, сургалтыг зохион байгуулна.	хэрэгжүүлсэн байна.			
39.		Сургуулийн бүс. Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартыг улсын хэмжээний нийт сургуульд хэрэгжүүлэх арга хэмжээг авна.	Сургуулийн бүс. Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартыг улсын хэмжээний сургуулиудын 30 хувьд хангагдсан байна.	БШУЯ	ЗТХЯ, Нийслэл, аймгийн засаг дарга	2022-2024
40.		Эрүүл мэнд, ёс зүй, сэтгэхүйн сорилтын хичээлийн цагийг нэмэгдүүлэн сургалтын хөтөлбөрт оруулж, шалгалтын шалгуур үзүүлэлтэд багтаана.	Сургалтын хөтөлбөр батлагдаж, жолоочийн шалгалт авахад замын хөдөлгөөнд оролцох бие болон сэтгэл зүйн онцлог, ёс зүйн асуултууд шалгалтын тестэд багтсан байна	ХЗДХЯ, ЗТХЯ	МУЗН	2022-2024
41.		Мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулна.	Үйл ажиллагааг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлагдсан байна.	ЗТХЯ, ХЗДХЯ, МХЕГ	МХЕГ, ТЦА, АТҮТ	2022-2024
42.	Замын хөдөлгөөнд оролцогчийн хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх	Аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын анхаарлыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хандуулж, хууль тогтоомжийн хүрээнд сургалт сурталчилгаа явуулах, олон нийтийг уриалах үйл ажиллагаанд татан оролцуулна.	Олон нийтийн болон аж ахуйн нэгжүүдийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцох нөхцөлийг бүрдүүлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгжүүд дэмжсэн байна.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ, ХЗДХЯ, ЭМЯ	2022-2024
43.		Хамгаалах бүс, хамгаалалтын малгай болон бусад аюулгүйн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр компани ажлыг үе шаттай, системтэй хэрэгжүүлнэ	Хэрэглээг 90 хувьд хүрсэн байна.	ХЗДХЯ ЗТХЯ	ЭМЯ БШУЯ	2022-2024

44		Замын хөдөлгөөнд соёлтой зан үйлийн горимын аргчлалыг боловсруулж хэрэгжүүлж ажлыг зохион байгуулах.	Замын хөдөлгөөнд соёлтой оролцох аргчлалыг боловсруулж, сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.	ЗТХЯ БХБЯ НЗДТГ		2022-2024
45.		Улс хооронд, орон нутгийн авто замын дагуу түр амрах талбай, үйлчилгээний цогцолборыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан барьж байгуулна	3-аас багагүй зогсох талбайг тохижуулж ашигласан байна.	ЗТХЯ	ХХААХ ҮЯ, БОАЖЯ Аймгийн засаг дарга нар	2022-2024
46.	Зам тээврийн ослын үед ашиглах техник хэрэгслийн хангалтыг сайжруулах, орчин үеийн шаардлагад нийцүүлэх, осол саатлын үед үзүүлэх тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулна.	Зам тээврийн ослын үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, байрлал тогтоох техникийн шийдэл, журам боловсруулан хэрэгжүүлнэ.	Яаралтай тусламжийн сүлжээг 3-аас багагүй цэгт бий болгосон байна. Орчин үеийн интернет, үүрийн телефон, сансрын холбооны сүлжээ ашиглахаас гадна олон улсын чанартай авто замын сүлжээний дагуу яаралтай тусламжийн утсан сүлжээ бий болгоно.	ЗТХЯ, МУЗН, ЭМЯ	Аймгийн засаг дарга нар	2022-2024
47.		Зам тээврийн ослын үед эмнэлгийн тусламжийг автомашинаар саадгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхээс гадна ноцтой, хүнд гэмтлийн үед нисдэг тэрэг, бага оврын агаарын хөлөг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ;	Ослын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хугацаа богиносох, ослоор нас барагсдын болон гэмтсэн бэртсэн хүний тоо буурна.	ЭМЯ, ОБЕГ	ЗТХЯ, Аймгийн засаг дарга нар	2022-2024
48.		Авто замын дагуух үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг түшиглэн тэдгээрийн ажилчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг чадварыг эзэмшүүлэх замаар	Анхны тусламжийн үйлчилгээг авто замын дагууд бүрэн хангагдсан байна.	ЭМЯ МУЗН	ЗТХЯ	2022-2024

		тусламж үзүүлэх цэгүүдийг байгуулна;				
49		Зам тээврийн осол гарсан үед хэргийн газрын үзлэгийг богино хугацаанд хийх, ослын тусламжийг яаралтай үзүүлэх тогтолцоог бий болгох.	Зам тээврийн ослын дуудлага, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах, цахимжуулах ажлыг зохион байгуулна.	ХЗДХЯ ЭМЯ	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, ЦЕГ	2022-2024
Үйл ажиллагааны зорилт: 3		“Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлнэ” гэсэн хөтөлбөрийн зорилтын хүрээнд:				
50.	Авто тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, техникийн үйлчилгээ, техникийн хяналт, устгал, дахин боловсруулахт ай холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, үндэсний стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулан мөрдүүлнэ.	Авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, техникийн шаардлага хангах болон хүрээлэн буй орчинд ээлтэй байх нөхцөлийг даатгалын тогтолцоотой уялдуулан хяналтын тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	Тээврийн хэрэгслийн идэвхтэй, идэвхгүй, ослын дараах, байгаль орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг тээврийн хэрэгслийн даатгалд хамруулсан байна. Замаар тээврийн хэрэгслийн техникийн болон экологийн аюулгүй байдалд тавих шаардлагыг нэмэгдүүлнэ.	ЗТХЯ, АТҮТ СЗХ	АЖДХ МХЕГ ТЦА ЗТХЯ	2022-2024
51.	Үйлдвэрлэгчээс баталгаат авто тээврийн хэрэгсэл, сэлбэгийг шууд хэрэглэгчид хүргэх тогтолцоог бүрдүүлэх, мөн тухайн оронд болон Монгол Улсад ашиглахыг хориглосон, ашиглалтын	Тээврийн хэрэгсэлд дүрс бичлэг хийх камер суурилуулж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, эрх үйргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Тээврийн хэрэгсэлд дүрс бичлэг хийх камер суурилуулж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаанд ашиглах ажил дэмжигдсэн байна.	ЗТХЯ, ХЗДХЯ	ТЦА, АТҮТ	2022-2024

	хугацаа дууссан, баруун гар талдаа жолооны хүрдгэй, зургаагаас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах замаар авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй осол, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулна;					
52.	Тээврийн хэрэгслийн хийц, технологийн онцлогт тохирсон, техник технологийн дэвшилд суурилсан, тээврийн хэрэгслийн тооны зохистой харьцаанд нийцүүлэн “Үйлчилгээ-Оношилгоо-Хяналт”-ын нэгдсэн системийг бүрдүүлнэ;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан сангууд, тэдгээрийг ашиглах журмыг хэрэгжүүлнэ.	Хуульд заасан сан, тэдгээрийг ашиглах нөхцөлийг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж эхэлнэ.	ЗХАБҮЗАА, ЗТХЯ, ХЗДХЯ	ЦЕГ, АТҮТ, ЗТХТ	2022- 2024
53.	Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын хөдөлгөөний удирдлага, хяналт,	Мэдээллийн нэгдсэн системийг ашиглан жилд 3-аас доошгүй судалгаа хийж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглана.	Судалгааны үндсэн дээр 3 доошгүй компани ажил зохион байгуулсан байна.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ	2022- 2024

	зохицуулалт, осол зөрчлийг бүртгэх мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ					
54.	Авто тээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд ирэх санхүүгийн дарамтыг багасгана.	Авто тээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох судалгааг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор хийнэ.	Жолооч, тээврийн хэрэгслийн даатгалыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох судалгаа хийгдсэн байна.	ЗТХЯ СЗХ	ХЗДХЯ Албан журмын даатгагчдын холбоо	2022-2024
55.	Авто тээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд ирэх санхүүгийн дарамтыг багасгана.	Авто тээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад импорт-оношлогоо үйлчилгээ-засвар-техникийн хяналтын бүх шатанд даатгалын цогц систем бий болгоно.	Жолоочийн даатгалын тухай хуульд холбогдох өөрчлөлт орж хэрэгжсэн байна	ХЗДХЯ ЗТХЯ	СЗХ	2022-2024
56.	Иргэдийг хувийн автомашинаас татгалзах зогсоол, зорчилтын менежментийн системийг боловсруулж мөрдүүлж эхэлнэ.	Иргэдийг хувийн автомашинаас татгалзах зогсоол, зорчилтын менежментийн системийг боловсруулж мөрдүүлж эхэлнэ.	Авто зогсоолын тухай хууль, хөдөлгөөний ачаалал ихтэй замд төлбөр оногдуулах эрх зүйн бодлого батлуулж хэрэгжүүлнэ.	БХБЯ	ЗТХЯ ХЗДХЯ Нийслэлийн засаг дарга	2022-2024
57.	Нийтийн тээврийн үйлчилгээнд суурилсан хот төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлнэ;	Нийтийн тээврийн үйлчилгээг боловсронгуй, ая тухтай, аюулгүй, шуурхай байх нөхцөлийг бүрдүүлсэн менежментийг бий болгоно.	Нийслэлийн иргэдийн 45 хувь нь нийтийн тээврээр зорчдог байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	БХБЯ ЗТХЯ	Нийслэлийн засаг дарга	2022-2024
58.	Хот төлөвлөлтийг боловсронгуй болгох, дахин төлөвлөлт хийх, хэсэгчилсэн төлөвлөлт хийх, замналыг шинэчлэх замаар нийтийн тээврийн шуурхай байдлыг хангана.	Хот төлөвлөлтийг боловсронгуй болгох, дахин төлөвлөлт хийх, хэсэгчилсэн төлөвлөлт хийх, замналыг шинэчлэх замаар нийтийн тээврийн шуурхай байдлыг хангана.	Нийтийн тээврээр зорчих нь хувийн автомашинаар зорчих хугацаанаас 2 дахин ашигтай байх нөхцөл бүрдсэн байна.	БХБЯ ЗТХЯ	Нийслэлийн засаг дарга	2022-2024
59.	Өнөөгийн нийтийн тээврийн үйлчилгээнд иж бүрэн судалгаа хийж	Өнөөгийн нийтийн тээврийн үйлчилгээнд иж бүрэн судалгаа хийж	Нийтийн тээврийн замнал, зогсоолын шийдэл хамгийн	ЗТХЯ АТҮТ\ Нийслэлийн	НТҮГ МХЕГ ТЦА	2022-2024

		хөдөлгөөний замналаас гадна, зогсоолын шийдлийг оновчтой болгоно.	оновчтой хувилбараар зохион байгуулсан байна.	засаг дарга	Нийслэлийн зам, тээврийн байгууллагууд	
60.	Хот суурин газрын төлөвлөлт, газар олголтод замын хөдөлгөөн зохион байгуулалт, замын	Хот тосгоны төлөвлөлт, барил-гажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-ийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэнэ.	Хот тосгоны төлөвлөлт, барил-гажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-ийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэгдсэн байна.	БХБЯ	ЗТХЯ	2022-2024
61.	хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг нэн тэргүүнд тавих зохицуулалтыг бүрдүүлнэ.	Шинээр хорооллыг төлөвлөхдөө сургууль цэцэрлэгийг төвд нь байхаар, хөдөлгөөний эрчим ихтэй замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, удирдлага, мэдрэгч тэргүүний арга хэрэгслийг ашиглана	Шинээр баригдаж байгаа суурьшлын бүсийн хүн амын тоо, эрэлт хэрэгцээг тооцсон сургууль, цэцэрлэг нийгмийн үйлчилгээний байгууллага хамт баригдах нөхцөл бүрдэж, хэрэгжсэн байна.	БХБЯ	Аймаг, нийслэлийн засаг дарга	2022-2024
62.	Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийх;	Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх аргачлал боловсруулан, туршилтаар ашиглана.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх чиглэлээр судалгаа хийгдсэн байна.	ЗХАБҮЗАА, ЗТХЯ, ТЦА	ХЗДХЯ	2022-2024
63.	зураг, төсөл зохиох, барих, ашиглах, ашиглалтын дараах үе шатанд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх тогтолцоог бүрдүүлнэ;	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх, холбогдох судалгаа, шинжилгээ хийх замаар “хар цэг”-ийг тодорхойлж, ослын	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудитын туршилт хийгдсэн байна.	ЗХАБҮЗАА, ЗТХЯ, ТЦА	ТЦА, ЗТХТ, АТҮТ	2022-2024
64.		Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх, холбогдох судалгаа, шинжилгээ хийх замаар “хар цэг”-ийг тодорхойлж, ослын	“Хар цэг”-ийг тодорхойлж осол гарах нөхцөлийг арилгах арга хэмжээ авсан байна.	ЗТХТ	ЗТХЯ, ЗХАБҮЗ АА, ЗТХТ, АЗЗА	2022-2024

		шалтгаан нөхцөлийг тогтоож, үр дагаврыг арилгах арга хэмжээ авна.			ХК-ууд Их дээд сургууль, судалгааны байгууллага	
65.		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах судалгааг мэргэжлийн байгууллага, судлаачдын оролцоотойгоор зохион байгуулж, тэмдэг, тэмдэглэл, техникийн шийдлийг оновчтой хэрэглэх ажлыг зохион байгуулна.	Судалгааны үндсэн дээр замын хөдөлгөөнийг эдийн засгийн үр ашигтайгаар зохион байгуулсан байна.	ЗТХТ	ЗХХАБ ҮЗАА Их дээд сургууль, судалгааны байгууллага	2022-2024
66.	Тусгай зориулалтын авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бүрдүүлнэ.	Уул уурхайн болон нийтийн хэрэгцээний бус замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, хуультай нийцүүлэн холбогдох дүрэм, журам, стандарт боловсруулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулна.	Холбогдох хэлэл хууль, дүрэм журам, стандарт боловсруулах чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	ЗТХЯ, УУХҮЯ, ЗХАБҮЗАА	ХЗДХЯ, ТЦА	2022-2024
67.		Уул уурхайн замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийж, шаардлагатай тоног төхөөрөмж, тэмдэг тэмдэглэлээр хангана.	Жил бүр уул уурхайн 1-ээс доошгүй замд аудит хийж, холбогдох дүгнэлтийн дагуу өөрчлөлт хийсэн байна.	ЗТХЯ, УУХҮЯ	ХЗДХЯ, УУХҮЯ, ЭМЯ, ХНХЯ	2022-2024
68.		Орон нутгийн бэлчээр хэсэг, замгүй газарт тээврийн хэрэгсэл ашиглах талаар жил бүр 1-ээс доошгүй компани ажиг зохион байгуулах	Холбогдох судалгаа хийж, жил бүр 1-ээс доошгүй компани ажиг зохион байгуулсан байна.	ХЗДХЯ, ХХААХҮЯ	ЭМЯ, ХНХЯ, ЗТХЯ	
Үйл ажиллагааны зорилт: 4		“Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна”. гэсэн хөтөлбөрийн зорилтын хүрээнд:				
69.	Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын удирдлага, хяналт,	Тээврийн ухаалаг системд суурилсан эрэлтийн удирдлагын системийг бий болгоно;	Зорчигч, ачаа урсгалын судалгаа хийж эрэлт, хэрэгцээнд суурилсан тээвэрлэлт хийгдэж эхэлсэн байна.	ЗТХЯ	Нийслэл, аймгуудын Засаг дарга	2022-2024

70.	зохицуулалтын систем нэвтрүүлнэ;	Тээврийн хэрэгслийн даац хэтрэлтэйг хянаж, зохицуулах систем нэвтрүүлнэ	Тээврийн хэрэгслийн даац хэтрүүлэх зөрчлийг таслан зогсоох нөхцөл бүрдсэн байна	ЗТХЯ	ХЗДХЯ, Нийслэл, аймгуудын Засаг дарга, МХЕГ	2022-2024
71.		Тээврийн хэрэгслийн зогсолт, зогсоолыг хянаж, зохицуулах систем нэвтрүүлнэ.	Тээврийн хэрэгслийн зогсоолын зөрчлийг таслан зогсоох, тээврийн хэрэгслийн зогсоолыг зохицуулах нөхцөл бүрдсэн байна.	ЗТХЯ	ХЗДХЯ, Нийслэл, аймгуудын Засаг дарга МХЕГ	2022-2024
72		Гудамж, замын хөдөлгөөнийг теле хяналтын камераар иж бүрэн хянах.	Хөдөлгөөнд оролцогчдын сахилга, дэг журам сайжирч, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	НЗДТГ Аймгийн Засаг дарга	ЗХАБҮЗ	2022-2024
73		Хөдөлгөөнт хяналтын удирдлагын систем нэвтрүүлэх	Замын хөдөлгөөний бүртгэл сайжирсан байна	ХЗДХЯ	НЗДТГ	2022-2024
74.	Улсын болон орон нутгийн чанартай авто замын дагууд тээврийн хэрэгслийн зөрчлийг хянах	Улсын чанартай замд тээврийн хэрэгслийн хурдыг хянах хяналтын камер систем ашиглана.	Улсын чанартай замын 10 цэгт камерын хяналт нэмж нэвтэрсэн байна	ЗТХЯ	ХЗДХЯ, Нийслэл, аймгуудын Засаг дарга	2022-2024
75.	дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.	Улсын чанартай замын дагуу хяналтын тоног төхөөрөмж бүхий хяналтын постын ашиглалтыг сайжруулах.	Нийт улсын чанартай замын дагуу хяналтын тоног төхөөрөмж бүхий 60 пост ашигласан байна	ХЗДХЯ	ЗТХЯ, ТЦА	2022-2024
76.	Тээврийн хэрэгслээс хөдөлгөөнийг хянах тогтолцоог бий болгоно.	Тээврийн хэрэгсэлд камер суурилуулж ашиглах ажлыг зохион байгуулна. Улсын хэмжээнд нийтийн тээврийн хэрэгслийн /таксиг оролцуулан/ хяналтын камераар тоноглох асуудлыг эрчимжүүлэн, чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал дээр зогссон,	Холбогдох хууль тогтоомжийн дагуу тээврийн хэрэгсэлд камер суурилуулах ажлыг зохион байгуулж эхэлсэн байна.	ЗТХЯ, ХЗДХЯ	Албан журмын даатгагчдын холбоо, ТЦА АТҮТөв”, НТҮГ, МХЕГ,	2022-2024

		нэгдүгээр эгнээгээр зорчсон, гүйцэж түрүүлэх үйлдэл хориглосон газар хийсэн зэрэг зөрчүүдийг камераар баримтжуулан шийтгэлийн хуудсыг тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийн гэрийн хаягаар хүргүүлэх ажлыг зохион байгуулах				
77.		Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлнэ.	Е-Police цахим систем ашиглан замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг шийдвэрлэнэ	ХЗДХЯ	ЦЕГ Аймаг, нийслэлийн засаг дарга	2022-2024
78		Хөдөлгөөний урсгал, ачааллын талаар бодит мэдээллээр хангагдах “хөтөч” /Navigation/ -ийг бий болгох	Хөдөлгөөний ачааллын мэдээлэл иргэн бүрт хүрэх нөхцөл бүрдэж, иргэд зөв сонголт хийнэ.	НЗДТГ	ЗТХЯ	2022-2024
79.	Гудамж замын хөдөлгөөнийг сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ “Аюултай нь бага, аюулгүй нь их” гэсэн олон улсын зарчмыг баримталж явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцөл бүрдүүлнэ.	Гудамж замын хөдөлгөөний сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ олон улсын жишиг аргачлал ашиглан, судалгаа тооцоо хийж гэр хорооллын дундах замыг явган хүн зорчих аюулгүй байдлыг хангахаас гадна, гэмт халдлагаас хамгаалах, ая тухтай нөхцөлийг бүрдүүлнэ.	Нийтийн тээврээр зорчихын тулд автобусны буудлаас гэр хүртэл зорчих хэв журам хамгаалагдсан, гэрэлтүүлэг, явган хүний зам, ногоон байгууламж, камер зэрэг явган хүн ая тухтай зорчих бүхий л нөхцөл хангагдсан байна.	ХЗДХЯ БХБЯ	Аймаг, нийслэлийн засаг дарга	2022-2024
80.		Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг хөдөлгөөний эрчим ихтэй замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг ашиглана;	Сургуулийн бүс. Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартын дагуу дүүрэг, аймаг тус бүр 1-ээс багагүй Ерөнхий боловсролын сургуулийг тохижуулж хангагдаж, хөдөлгөөнийг хянах камераар тоноглогдсон байна.	БШУЯ	ХЗДХЯ	2022-2024

81.		<p>Явган хүний гарам, гарцыг тооцоо, судалгааны үндсэн дээр цогц байдлаар шийдвэрлэнэ. Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацын арга хэрэглэн тоноглож бусад техникийн шийдлийг бий болгоно.</p>	<p>Суурин газрын нийт явган хүний гарц стандартын шаардлага хангаж, шөнийн цагт замын бусад хэсгээс илт ялгарч харагдах нөхцөл бүрдсэн байна.</p>	ЗТХЯ	ХЗДХЯ, ЗТХТ	2022-2024
-----	--	---	---	------	-------------	-----------